



USAID
FROM THE AMERICAN PEOPLE



The Asia Foundation

МОНГОЛ УЛСЫН СОНГУУЛЬ

(1992-2021)



ЭМХЭТГЭЛ

Улаанбаатар, 2023
Азийн сан



Энэхүү эмхэтгэлийг АНУ-ын олон улсын хөгжлийн агентлагийн тусламжтайгаар Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэн, Азийн сангийн хамтран хэрэгжүүлж буй "Залуучууд, эмэгтэйчүүдийн сонгууль, улс төрийн оролцоог идэвхжүүлэх нь" хөтөлбөрийн хүрээнд бүтээв. Бүтээлд илэрхийлэгдсэн агуулга нь судлаачдын хувийн үзэл санаа бөгөөд АНУ-ын засгийн газар эсвэл дээрх агентлаг, хүрээлэн, сангийн албан ёсны байр суурь биш болно.

Хувь нэмэр оруулсан:

Судлаачид:

Д. Бадамдаш, МУИС-ийн Улс төр судлалын тэнхимийн багш
Э. Гэрэлт-Од, МУБИС-ийн Нийгмийн ухааны тэнхимийн багш, улс төр судлаач, доктор
А. Бат-Оргил, ХБНГУ-ын Боннын Их Сургууль, Ази, дорно дахины судлалын тэнхимийн докторант
А. Алтанзул, Удирдлагын академийн Эрх зүйн тэнхимийн эрхлэгч, доктор
Г. Шинэбаяр, Нихон Их Сургууль, Хууль зүйн Сургууль, Улс төр судлалын докторант
Д. Ундрах, МУИС-ийн Улс төр судлалын тэнхимийн дэд профессор, доктор
Б. Эрдэнэдалай, МУИС-ийн Улс төр судлалын тэнхимийн дэд профессор, доктор
Б. Сарантуяа, Улс төр судлаач, МУИС-ийн Хууль зүйн Сургууль, Эрхзүйн оюутан
Марк Кэйниг, Азийн сангийн Монгол дахь суурин төлөөлөгч

Орчуулагчид:

Д. Ганхуяг, Орчуулагч
Б. Барисбек, Орчуулагч

Редакторууд:

Мишел Борок, Англи хэлний редактор
Г. Доржтүвдэн, Монгол хэлний редактор, Цогц хөгжлийн үндэсний төв ТББ
Б. Уянга, Монгол хэлний редактор, Цогц хөгжлийн үндэсний төв ТББ
Л. Дэлгэрмаа, Орчуулгын болон техник редактор, Азийн сангийн хөтөлбөрийн дэд менежер
О. Намуун, Орчуулгын болон техник редактор, Азийн сангийн төслийн ажилтан

Товчилсон үгийн жагсаалт:

АИХ	Ардын Их Хурал
АН	Ардчилсан Нам
АН (ЭОАЭ)	Ардчилсан Нам (Эх Орон Ардчилсан Эвсэл)
АНУОУХА	АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг
АСДҮОУХ	Ардчилал, Сонгуульд Дэмжлэг Үзүүлэх Олон Улсын Хүрээлэн
АХЭ	Ардчилсан Холбоо Эвсэл
АТГ	Авлигатай Тэмцэх Газар
АШН	Ардчилал Шинэчлэлийн Нам
БНН	Бүгд Найрамдах Нам
БНОУХ	Бүгд Найрамдахчуудын Олон Улсын Хүрээлэн
ДМН	Дэлхийн Монголчууд Нам
ЗХЭЭ	Зөв Хүн Электорат Эвсэл
МУЗЗНДНТУТХ	Монгол Улсын Засаг Захиргаа, Нутаг Дэвсгэрийн Нэгж, Түүний Удирдлагын Тухай Хууль
ИЗНН	Иргэний Зориг Ногоон Нам
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ИХН	Иргэний Хөдөлгөөний Нам
ИЭ	Иргэний эвсэл
МАН	Монгол Ардын Нам
МАХН	Монгол Ардын Хувьсгалт Нам
МАХН-МҮАН-ШЁЭ	Монгол Ардын Хувьсгалт нам, Монголын Үндэсний Ардчилсан Намын Шударга ёс эвсэл
МНН	Монголын Ногоон Нам
МНН-ИХН-ИЭ	Монголын Ногоон Нам, Иргэний Хөдөлгөөний Намын Иргэний Эвсэл
МоАН-МҮДН-ННЭ	Монголын Ардчилсан Нам, Монголын Үндэсний Дэвшлийн Нам, Ногоон Намын Эвсэл
МСДН	Монголын Социал Демократ Нам
МСДН-МоАН-АХЭ	Монголын Социал Демократ Нам, Монголын Ардчилсан Нам, Ардчилсан Холбоо Эвсэл
МУНН	Монголын Уламжлалтын Нэгдсэн Нам
МҮАН	Монголын Үндэсний Ардчилсан Нам
МҮАН-МСДН-АХЭ	Монголын Үндэсний Ардчилсан Нам, Монголын Социал Демократ Нам, Ардчилсан Холбоо Эвсэл
МҮДН	Монголын Үндэсний Дэвшлийн нам
МҮОНРТ	Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевиз
ОНС	Орон Нутгийн Сонгууль
ӨСЭ	Өргөн Сэлэнгэ Эвсэл
СЕХ	Сонгуулийн Ерөнхий Хороо
СҮХ19Э	Сахигтун, Үндсэн Хуулийн 19 Эвсэл
ТБЭ	Та Бидний Эвсэл
УИХ	Улсын Их Хурал
ҮЗН	Үнэн ба Зөв Нам
ХҮН	Хөдөлмөрийн Үндэсний Нам (2020 оноос хойш ХҮН нам болсон)
ШИНЭН	Шударга Иргэдийн Нэгдсэн Эвсэл Нам
ЭОАЭ	Эх Орон Ардчилал Эвсэл
ЭО-МАШСН	Эх Орон Монголын Ардчилсан Шинэ Социалист Нам
ЭОН	Эх орон нам

Агуулга

Өмнөх үг	8
Талархал	9
Бүлэг I - Оршил	10
Сонгогчдын ирц	11
Сонгуулийн тогтолцооны тогтворгүй байдал	12
Сонгуулийн үр дүн ба улс төрийн намуудын төлөвшил	12
Цаашдын төлөв	14
Бүлэг II - Сонгуулийн нэр томъёоны тайлбар, ойлголт	15
Сонгууль	15
Сонгуулийн тогтолцоо	15
Сонгуулийн тогтолцооны ангилал	16
Сонгуулийн тогтолцооны шинжилгээний нийтлэг хамрах хүрээ	19
Монгол Улсын сонгуулийн тогтолцоог бусад ижил төстэй нөхцөл жишээтэй харьцуулсан судалгааны дүн шинжилгээ	21
Бүлэг III - Монгол Улс дахь парламентын сонгууль	26
Сонгуулийн тогтолцооны тогтворгүй байдлын үр дагаврын дүн шинжилгээ	26
УИХ-ын сонгуулийн үр дүнд ажиглагдаж буй чиг хандлага	33
Сонгуулийн санхүүжилт - байнга нэмэгдэж ирсэн авч хангалттай ил тод бус	35
Дүгнэлт	36
Бүлэг IV - Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль	40
Ерөнхийлөгчийн үүрэг	40
Ерөнхийлөгчийн сонгууль - зохион байгуулалт, ирц	43
Ерөнхийлөгчийн сонгууль - нэр дэвшигчид	45
Ерөнхийлөгчийн сонгууль - үр дүн	46
Намын харьяалал, эв нэгдэл болон нэр дэвшигчийн чадавх чансааны ач холбогдол	47
Дүгнэлт	53
Бүлэг V - Монгол Улсын орон нутгийн сонгууль (ИТХ)	55
Орон нутгийн сонгууль - Сонгуулийн тогтолцоо ба удирдлага	55
Орон нутгийн сонгуулийн дүн	58
Орон нутгийн сонгуулийн дата мэдээлэлтэй холбоотой асуудлууд	60
Дүгнэлт	61
Ашигласан бүтээлийн жагсаалт	63

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1.	Парламентын болон Ерөнхийлөгчийн сонгуулийн үр дүн аймгаар	13
Хүснэгт 2.	Дийлэнх/олонхын тогтолцооны давуу болон сул тал	18
Хүснэгт 3.	Хувь тэнцүүлсэн тогтолцооны давуу ба сул тал	18
Хүснэгт 4.	Улс орнуудын сонгуулийн тогтолцооны судалгаа	22
Хүснэгт 5.	Институтийн харьцуулсан шинжилгээ	23
Хүснэгт 6.	Сонгогчдын ирц	29
Хүснэгт 7.	Саналын хувь болон суудлын зөрүүтэй байдал	32
Хүснэгт 8.	Улс төрийн намууд болон бие даан нэр дэвшигчдийн УИХ дахь суудлын тоо	33
Хүснэгт 9.	УИХ-ын эхний 4 сонгууль болон сүүлийн 4 сонгуульд улс төрийн намуудын авсан саналыг харьцуулсан нь	34
Хүснэгт 10.	УИХ-ын болон Ерөнхийлөгчийн сонгуулийн сонгогчдын ирцийн харьцуулалт	44
Хүснэгт 11.	Сонгогчдын ирцийг аймгуудаар эрэмбэлсэн байдал (2000-2017)	44
Хүснэгт 12.	Ерөнхийлөгчийн сонгуульд ялалт байгуулсан нэр дэвшигчдийн улс төрийн нөлөөлөл	45
Хүснэгт 13.	Ерөнхийлөгч нарын нас	46
Хүснэгт 14.	Ерөнхийлөгчийн сонгуулийн үр дүнгийн тойм	46
Хүснэгт 15.	Ерөнхийлөгчийн сонгуульд ялалт байгуулсан нам, аймаг/дүүргээр	48
Хүснэгт 16.	Ерөнхийлөгч болон УИХ-ын суудал дахь олонх болсон намуудын хугацаа (29.5 жил)	49
Хүснэгт 17.	УИХ-ын болон Ерөнхийлөгчийн сонгуульд намуудын авсан санал, улс төрийн нам тус бүрээр	50
Хүснэгт 18.	Ерөнхийлөгчийн сонгуулийн хүчингүй саналын хуудас	51
Хүснэгт 19.	УИХ болон Ерөнхийлөгчийн сонгуулийг зохион байгуулах хугацаа	54
Хүснэгт 20.	2000, 2004, 2016 болон 2020 оны ОНС-ийн дүнгийн хураангуй	59

Зургийн жагсаалт

Зураг 1.	УИХ, Ерөнхийлөгч болон Орон нутгийн сонгуулийн ирцийн харьцуулалт (Ерөнхийлөгчийн сонгуультай жилүүдийг хаалтад тэмдэглэв)	11
Зураг 2.	Сонгуулийн тогтолцооны ангилал	17
Зураг 3.	Улс орнуудын ашиглаж буй сонгуулийн тогтолцоонууд	18
Зураг 4.	УИХ-ын сонгуулийн хууль, сонгуулийн тогтолцоонд хийгдсэн өөрчлөлтүүд	27
Зураг 5.	Сонгогчдын санал УИХ-д тусгалаа олсон байдал	31
Зураг 6.	Монголын сонгуулийн зохист харьцааны индекс (1992-2020)	32
Зураг 7.	УИХ-ын сонгуульд улс төрийн намуудын авсан саналын хувь хэмжээ (1992-2020)	34
Зураг 8.	Сонгуулийн кампанит ажлын зардал 1992-2020	36
Зураг 9.	Монгол Улс дахь үр ашигтай намын тоо	37
Зураг 10.	Авсан саналын тоо болон хэвлэл мэдээллээр сурталчилсан хугацаа хоорондын хамаарал	52
Зураг 11.	Нэр дэвшигчийн санхүүжилтийн задаргаа: 2009-2017	53
Зураг 12.	УИХ-ын, Ерөнхийлөгчийн болон ОНС-ийн ирцийн харьцуулалт (Ерөнхийлөгчийн сонгуультай жилүүдийг хаалтад дурдав)	57
Зураг 13.	Орон нутгийн сонгуульд оролцоогүй шалтгаан	58

Хавсралтын жагсаалт

Хавсралт I	Монгол Улсын УИХ-ын сонгуулийн үр дүн (1992-2020), улсын хэмжээнд	66
Хавсралт II	Монгол Улсын УИХ-ын сонгуулийн үр дүн (1992-2020), нийслэл, дүүрэг	70
Хавсралт III	Монгол Улсын УИХ-ын гишүүдийн нэрс (1992 - 2020), улс төрийн нам, аймаг, авсан саналын тоо, хувиар	73
Хавсралт IV	Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн үр дүн (1993-2021), улсын хэмжээнд	89
Хавсралт V	Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн хүчинтэй ба хүчингүй саналын тоо, хувь (1993-2021), улсын хэмжээнд	93
Хавсралт VI	Аймаг, нийслэлийн орон нутгийн сонгуулийн (ИТХ) үр дүн, улс төрийн намаар (2000, 2004, 2016, 2020)	95
Хавсралт VII	Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын бүрэлдэхүүн (1996-2020)	99

ӨМНӨХ ҮГ

АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг нь 2020 оноос эхлэн “Залуучууд, эмэгтэйчүүдийн сонгууль, улс төрийн оролцоог идэвхжүүлэх нь” (SWYEEPPM) хөтөлбөрийг санхүүжүүлж ирсэн. Сонгууль ба Улс төрийн үйл явцыг бэхжүүлэх консорциум, Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэн болон Азийн сан хамтран залуучууд, эмэгтэйчүүдэд хүрч, тэднийг чадавхжуулахын зэрэгцээ Монгол Улсын сонгууль, ардчилсан үйл явц дахь иргэдийн оролцоог идэвхжүүлэх зорилгоор энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэв. Гурван жилийн турш үргэлжилсэн энэхүү санаачилгын хүрээнд үйл ажиллагаагаа төлөвлөх, мэдлэг, мэдээлэл түгээхийн сацуу иргэдийн боловсролыг сайжруулах чиглэлд хувь нэмрээ оруулахаар судалгаа, шинжилгээний ажилд ихээхэн ач холбогдол өгч ирлээ. Үүний хүрээнд Монголын иргэний нийгмийн байгууллага, эрдэмтэн судлаачид болон бусад мэргэжилтнүүдтэй хамтран сонгуулийн тогтолцоо, Ерөнхийлөгчийн эрх мэдэл, сонгуулийн ирц, улс төр дэх залуучууд, эмэгтэйчүүдэд тулгарч буй сорилт бэрхшээл, нам доторх ардчилал, үндэсний хэмжээний олон нийтийн санал асуулга, улс төрийн оролцооны талаарх залуусын ойлголт, үзэл бодол зэрэг өргөн хүрээний сэдвүүдийг хамруулан судлав.

Уг эмхэтгэлээр хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн Монгол Улсын сонгуулийн сэдэвт судалгаа, шинжилгээний ажлуудыг нэмэлт дүн шинжилгээтэйгээр нэгтгэлээ. Эмхэтгэлийн гол зорилго нь сонгуулийн дата мэдээллийг хянан нэгтгэж, цаашид эрдэмтэн судлаачид, иргэний нийгмийн зүтгэлтнүүд, бодлого боловсруулагчид ажилдаа ашиглахад хялбар, хүртээмжтэй байхуйц түвшинд толилуулах явдал юм. Цаашлаад сонгуулийн сэдэвт хэлэлцүүлэг, иргэний боловсролын чухал үйл ажиллагаануудад энэ нь томоохон хувь нэмэр болох болов уу гэж найдаж байна. Сонгуультай холбоотой дата мэдээллийг ашиглахад хялбар, хүртээмжтэй болгож сайжруулахад ихээхэн хүчин чармайлт шаардлагатай хэвээр байгаа тул энэхүү эмхэтгэл нь цаашдын санал хэлэлцүүлэг, мэтгэлцээн, дүн шинжилгээ хийх ажлуудад жинтэй хувь нэмэр болно гэдэгт итгэлтэй байна. Энэхүү эмхэтгэлийн чанар, цаашдын үр нөлөө төдийгүй иргэд мэдээлэлд ойр байх нь аливаа ардчиллын адилаар Монголын ардчиллын бат бэх байдалд ихээхэн чухал байх болно.

Энэхүү эмхэтгэлийг боловсруулахад гар бие оролцож, хувь нэмэр оруулсан бүх хүмүүст гүн талархал илэрхийлье.

Томас Крэхан
АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн Монгол дахь захирал

ТАЛАРХАЛ

Энэхүү эмхэтгэл нь олон хүний хичээл зүтгэл, хөдөлмөр, хамтын ажиллагааны үр дүнд бүтэв. Юуны өмнө АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн санхүүгийн дэмжлэггүйгээр энэхүү эмхэтгэлийг таны гарт хүргэх боломжгүй байсныг онцлон тэмдэглэхийн сацуу гүн талархал илэрхийлье. “Залуучууд, эмэгтэйчүүдийн сонгууль, улс төрийн оролцоог идэвхжүүлэх нь” хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлж, уг эмхэтгэлийн үндэс суурь болсон судалгаа шинжилгээний ажлуудыг уншиж, хянаж, санал сэтгэгдлээ хуваалцаж, дэмжлэг үзүүлсэн Крэйг Кастанья болон Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэнгийн баг, мөн Азийн сангийн засаглалын хөтөлбөрийн баг, мэргэжилтнүүд, санхүү, үйл ажиллагааны багийнхны үнэтэй хувь нэмрийг тэмдэглэн талархаж байна.

Энэхүү судалгааны бүтээлд орсон дата мэдээллийг бүрдүүлэхэд боломжит бүхий л мэдээллээр хангаж, санал сэтгэгдлээ хуваалцан хамтран ажилласан Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны хамт олонд талархал илэрхийлье.

Эмхэтгэл нь эрдэм шинжилгээний болон иргэний нийгмийн байгууллагуудын олон судлаачдын бүтээлүүд, дүн шинжилгээг нэгтгэн багтаасан ба хувь нэмэр оруулсан судлаач бүрийг бүлэг тус бүрийн эхэнд дурдав. Түүнчлэн бусад олон хүний хичээл зүтгэл орсныг эмхэтгэлийн эхэнд тэмдэглэсэн болно.

Эмхэтгэлийн хэл найруулга, уялдаа холбоог сайжруулахад орчуулагч Д.Ганхуяг, Б.Барисбек, мөн англи хэлний редактор Мишел Борок, монгол хэлний редактор Цогц хөгжлийн үндэсний төвийн ахлах судлаач Г.Доржтүвдэн, Б.Уянга нар үнэтэй хувь нэмэр оруулав.

Түүнчлэн сонгуулийн түүхэн дата мэдээллийг цуглуулах, олдсон цэгцгүй мэдээллийг цэгцлэх, цахим хэлбэрт оруулан зохион байгуулах, эмхэтгэх томоохон ажилд шаргуу хичээл зүтгэл гарган тууштай ажилласан Б.Сарантуяад онцгой талархал илэрхийлье.

Эцэст нь, энэхүү эмхэтгэлийг боловсруулах үйл явцыг удирдан чиглүүлж ажилласан Азийн сангийн баг Л.Дэлгэрмаа, О.Намуун нарт тусгайлан талархал илэрхийлье. Үндсэн судалгааны ажлуудыг бүрдүүлэхэд чиглүүлэх, хянахаас эхлээд эцсийн эмхэтгэлийн Монгол, Англи хувилбарын хэл найруулгыг уялдуулах, редакторлах, эх бэлтгэх хүртэлх бүхий л явцад тууштай ажиллаж ирсэн нь энэхүү эмхэтгэлийг бүтээхэд чухал үүрэг гүйцэтгэв.

Марк Кэйниг
Азийн сангийн Монгол дахь суурин төлөөлөгч

БҮЛЭГ I

ОРШИЛ

Зохиогч:

Марк Кэйниг, Д.Бадамдаш

Монгол Улсын ардчилал нь 30 гаруй жилийн хугацаанд найман удаагийн ардчилсан сонгуулиар баталгаажжээ. Дээрх сонгуулиуд алдаа дутагдалтай байсан ч улс төрийн олон намын өрсөлдөөнийг хангасан, засгийн эрхийг тайван замаар шилжүүлсэн, чөлөөт, шударга сонгууль болсон гэж ихэнх ажиглагчид үздэг. Энэ нь залуу ардчилалтай боловч Монгол Улс нь өнөөг хүртэл тэсвэр хатуужилтай, хүчирхэг ардчиллыг бэхжүүлсээр ирснийг харуулж байна.

Монгол Улсын ардчиллын түүх ерөнхий зургаараа эерэг ч улс төр, сонгуулийн хувьд нэлээд сорилттой тулгарч иржээ. Гурван шатны сонгууль (Улсын Их Хурал (УИХ), Орон нутгийн сонгууль (ОНС), Ерөнхийлөгчийн сонгууль) бүрд сонгогчдын ирц буурч, Засгийн газар болон сонгогдсон албан тушаалтнуудад итгэх иргэдийн итгэл буурч байгааг олон нийтийн санал асуулгын дүнгээс харж болно. Эдгээр асуудал нь дэлхийн олон ардчилсан оронд тулгардаг боловч Монголын сонгуулийн тогтолцооны онцлогоос үүдэлтэй сорилтууд ч бий. Монгол Улсын сонгуулийн тогтолцооны тогтворгүй байдлаас үүдэлтэй урьдчилан таамаглах боломжгүй, тодорхойгүй байдал, улс төрийн намуудын эрх ашгаа тэргүүнд тавьдаг хандлага, улс төрийн байр сууриа бэхжүүлэх сонирхлын үүднээс сонгуулийн тогтолцоог (жишээ нь, багц саналын тогтолцоо) сонгодог, улмаар бага саналын зөрүүтэй ч төрийн эрхийг үргэлжлүүлэн барих улс төрийн зорилго зэрэг нь үүнд нөлөөлжээ.

Сонгогчийн боловсрол болон нийт ард иргэдийн сонгуулийн талаарх ойлголт дутмаг байдаг нь Монголын сонгуулийн тогтолцоо байнга өөрчлөгддөг, сонгууль, ялангуяа орон нутгийн сонгуулийн чанартай дата мэдээлэл байхгүйгээс шууд шалтгаалдаг. Эдгээр хүчин зүйлс болоод сонгуулийн дата мэдээллийг олох, цуглуулахтай холбоотой бэрхшээл, чирэгдэл нь Монгол Улсын сонгуульд зарим судалгаа, дүн шинжилгээг хийх боломжийг хязгаарлаж байна. Энэ байдал нь Монгол Улсад тохиромжтой сонгуулийн тогтолцоог сонгох чиглэлд чанартай, баримтад суурилсан хэлэлцүүлэг өрнөхгүй байх, мөн олон нийтийн сонгуулийн ойлголт болон сонирхол муу байгаагийн суурь шалтгаан байх боломжтой.

Энэхүү эмхэтгэлээр Монгол Улсын сонгуулийн дата мэдээллийн суурийг бүрдүүлж, боломжит дүн шинжилгээг хийхийг зорьсон. Ингэхдээ дата мэдээллийг судлаач, эрдэмтэд хүртээмжтэй болгох, цаашид судлагдах шаардлагатай судлагдахуунуудыг тодорхойлох төдийгүй улс төр, засаглалд сонгуулийн тогтолцооны үзүүлж буй нөлөөллийг шинжлэхийг зорив. Эмхэтгэлд УИХ, Ерөнхийлөгч болон Орон нутгийн сонгуулийг түүхэн хөгжил, ашигласан сонгуулийн тогтолцооны үр дагавар, сонгуулиудын үр дүн болон улс төрийн өрсөлдөөн зэргээр бүлэг тус бүрд тайлбарлав. Сонгууль бүрд шинжилгээ хийхэд нийтлэг нөлөөлөл, хандлага ажиглагдаж буй нь цаашид хэлэлцүүлэг, судалгаа шаардлагатайг харуулж байна.

Сонгогчдын ирц

Идэвхтэй эхэлсэн ардчилсан хөдөлгөөний эхэн үед буюу 1992 оны Монгол Улсын анхны ардчилсан сонгууль, 1993 оны Ерөнхийлөгчийн анхны сонгуулийн үеэр сонгуулийн ирц 90 гаруй хувь, орон нутгийн сонгуулийнх 70 гаруй хувьтай байсан. Үүнээс хойш бүх төрлийн сонгуулийн хувьд сонгогчдын ирц тогтмол буурсаар иржээ. Гурван төрлийн сонгууль дотроос хамгийн эхэнд зохион байгуулагддаг УИХ-ын сонгууль нь хамгийн өндөр ирцтэй байдаг ба дараа нь зохион байгуулагддаг Орон нутгийн сонгууль нь иргэдийн хамгийн идэвх муутай оролцдог сонгууль бөгөөд ирц нь УИХ-ын сонгуулийнхаас 10-15 хувиар, Ерөнхийлөгчийн сонгуулийн ирц УИХ-ын сонгуулийнхаас 4-5 хувиар бага байдаг. Сонгуулийн төрөл тус бүрийн ирцийг бүлэг тус бүрд дэлгэрүүлэв. Бүлэг III-аас УИХ-ын сонгуулийн ирц болон парламентад итгэх иргэдийн итгэл буурч, УИХ-ын сонгууль дахь зохист харьцаа ихээр алдагдаж байгааг харж болох ба энэ нь аливаа улс төрийн намын санал хуваалт, парламентад авч буй суудлын тооны зөрүү болон сонгуулийн тогтолцоо тогтмол өөрчлөгдөж байгаагаас үүдсэн бухимдал, тодорхойгүй байдлыг илэрхийлж байна. Бүлэг IV-т сонгуульд жилд хамгийн сүүлд зохион байгуулагддаг Ерөнхийлөгчийн сонгуулийн ирц иргэдийн сонгуулиас залхсан байдлаас үүдэн буурч байгаа тухай өгүүлэв. Гэхдээ Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөж байгаа нэр дэвшигчийн нэр хүндээс хамаарч сонгууль хэр өрсөлдөөнтэй болох хүлээлтээс ирц хамаарах магадлалтай байдаг. Орон нутгийн сонгуулийн ирц иргэдийн орон нутгийн засаглалыг ойлгох ойлголтоос ихээхэн хамаардаг ба хэт төвлөрсөн засаглалтай улсын хувьд тус сонгууль нь нөлөө багатай гэж иргэд үздэг тул орон нутгийн сонгуульд оролцож саналаа өгөхийг чухалчилдаггүй талаар Бүлэг V-д өгүүлэв. Нөгөө талаар сонгогчийн бүртгэлийн асуудал болон биечлэн санал өгөхөөс өөр санал өгөх сонголт байхгүйгээс ажил, сургуультай холбоотой улирлын чанартай шилжилт хөдөлгөөн нь орон нутгийн сонгуулийн ирцэд сөргөөр нөлөөлөх талтай.

Бүх төрлийн сонгуулийн ирц буурахад сонгогчийн боловсрол тааруу, сонгуулийн тогтолцоо, хууль дүрмийн байнгын өөрчлөлт, үүнтэй холбоотой ойлгомжгүй байдал, бухимдал, улс төрийн томоохон намуудын талаарх нийгмийн сөрөг ойлголт, сонгуулийн сурталчилгааны богино хугацаа зэрэг нийтлэг хүчин зүйлс нөлөөлж болно. Сонгогчдын оролцоо буурч байгаа нь төрд итгэх иргэдийн итгэл буурсан, сонгогчдосон албан тушаалтнуудын нийгэм дэх сөрөг дүрээс үүдэлтэй ба энэ нь сонгуулийн "легитим" байдлыг сорьж байна.

Зураг 1. УИХ, Ерөнхийлөгч болон Орон нутгийн сонгуулийн ирцийн харьцуулалт (Ерөнхийлөгчийн сонгуультай жилүүдийг хаалтад тэмдэглэв)



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо, 2021

Сонгуулийн тогтолцооны тогтворгүй байдал

III-р бүлгийн дүгнэлтээс үзвэл сонгуулийн тогтолцоо, холбогдох хууль, дүрэм журам байнга өөрчлөгдөж байгаа нь сонгуулийн хамгийн том сорилт юм. Өнгөрсөн 30 гаруй жилийн хугацаанд Монгол Улс УИХ-ын сонгуулийн тухай хуулиа таван удаа өөрчилж, гурван удаа нэмэлт, өөрчлөлт оруулж, дөрвөн өөр сонгуулийн тогтолцоог ашиглажээ. УИХ-ын сонгуульд ашиглагдаж байгаа тогтолцоог Орон нутгийн сонгуульд шууд ашигладаг талаар Бүлэг V-т тайлбарлав. Энэ мэтээр байнга өөрчлөх нь сонгогчдын боловсрол, улс төрийн намын институтчилэл, стратегид сөргөөр нөлөөлж, тогтолцоонд урьдчилан таамаглах боломжгүй, тодорхойгүй байдлыг бий болгож болзошгүй юм. Ийм тогтворгүй нөхцөл байдалд сонгуулийн үр дүнд дүн шинжилгээ хийх боломжгүй. Дурдсан хугацаанд Ерөнхийлөгчийн сонгууль харьцангуй тогтвортой, ойлгомжтой зохион байгуулагдаж ирсэн нь Ерөнхийлөгчийн Тамгын газрын эрх мэдэл, нөлөөллийг нэмэгдүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулсан байж болзошгүй талаар Бүлэг IV-д өгүүлэв.

Дээр дурдсан өөрчлөлтүүд УИХ-ын сонгууль бүрийн өмнө (заримдаа хэдхэн сарын өмнө) хийгдэж байсан. Олонх болсон нам, эвсэл сонгуулийн тогтолцооны талаарх нийтийн ашиг сонирхол, үнэт зүйлсийг чухалчлалгүй өөрсдийн дахин сонгогдох кампанит ажилд зориулан уг өөрчлөлтийг хийж ирсэн нь богино хугацааны, ашиг сонирхлын зөрчилтэй шийдвэр байсан. Ерөнхийдөө энэ тогтворгүй байдал нь засаг захиргааны байгууллагуудын "легитим" чанар буурахад нөлөөлж буй бас нэг хүчин зүйл юм.

Сонгуулийн үр дүн ба улс төрийн намуудын төлөвшил

Сонгуулийн түүхчилсэн үр дүнгээс харахад хоёр том нам, эсвэл тэдгээрийн эвслүүд буюу Монгол Ардын Нам (хуучнаар МАХН – хуваагдахаас өмнө) болон Ардчилсан нам (олон жижиг намуудын нэгдэл хэлбэрээр байгуулагдсан) сонгуульд давамгайлж байсныг харуулж байна. Өнгөрсөн хугацаанд МАН гол өрсөлдөгчөөсөө харьцангуй илүү амжилт гаргасан. УИХ-ын ээлжит найман сонгуулиас МАН/МАХН таван сонгуульд ялалт байгуулж, 2004 онд хамтарсан Засгийн газар байгуулж байсан ба ОНС-д ихэнх аймагт ялж, нийт найман Ерөнхийлөгчийн сонгуулийн дөрөвт нь амжилт гаргажээ.

Монголын хамгийн том улс төрийн ууган хүчний хувьд хамгийн олон гишүүнчлэлтэй, хөдөө орон нутагт байр сууриа бэхжүүлж чадсан зэрэг нь МАН/МАХН-ын гол давуу тал болдог. МАН-ын ялалтыг газарзүйн байдлаар нь Хүснэгт 1-ээс харж болох ба үүнээс МАН-ын "баталгаатай" ялалт байгуулдаг нэлээд олон аймаг бийг харж болохоор байна. Өнгөрсөн найман удаагийн парламентын сонгуулийн үр дүнг нэгтгэн үзвэл МАН/МАХН-аас нэр дэвшигчид Булган, Говь-Алтай, Төв, Увс аймагт 75-аас дээш хувийн суудал авч байсан бол найман удаагийн Ерөнхийлөгчийн сонгуулийн зургаад нь мөн дээрх аймгуудад ялалт байгуулж байжээ. Харин Ардчилсан нам (АН)-ын хувьд үүнтэй адил ялалт байгуулах өндөр магадлал бүхий давуу талтай аймаг, дүүрэг байхгүй байна. Газарзүйн эл давуу тал нь улс даяараа нэг тойрог болж санал өгдөг Ерөнхийлөгчийн сонгуулийн үр дүнд нөлөөлөөгүй байна. Энэ нь АН-ын Ерөнхийлөгчийн сонгууль дахь ялалтыг тодорхой хэмжээнд тайлбарлаж байна. Монголын сонгуулийн өнгөрсөн хугацааны үр дүнг харвал хоёр том намын өрсөлдөөн мэт харагдах боловч дата мэдээллийг шинжилбэл аль нэг намыг дэмждэг сонгогчдын хувь буурч буй нь харагдаж байна.

Хүснэгт 1. Парламентын болон Ерөнхийлөгчийн сонгуулийн үр дүн аймгаар¹

Аймаг/Дүүрэг	Ерөнхийлөгчийн сонгуульд ялалт байгуулсан намууд			Парламентын сонгуульд авсан суудлын тоо		
	МАН/МАХН	АН	Бусад	МАН/МАХН	АН	Бусад
Архангай	3	4	1	13	10	0
Баян-Өлгий	7	1	0	17	6	0
Баянхонгор	6	2	0	12	11	0
Булган	7	0	1	13	2	0
Говь-Алтай	7	1	0	13	0	1
Говьсүмбэр	7	0	1	7	0	0
Дархан-уул	4	3	1	15	7	1
Дорноговь	6	1	1	7	1	0
Дорнод	5	2	1	13	6	2
Дундговь	7	0	1	6	6	0
Завхан	6	2	0	13	7	1
Орхон	4	3	1	10	3	5
Өвөрхангай	7	1	0	18	10	0
Өмнөговь	6	1	1	8	7	0
Сүхбаатар	8	0	0	10	3	1
Сэлэнгэ	6	2	0	15	8	0
Төв	8	0	0	25	3	0
Увс	6	2	0	22	1	0
Ховд	5	3	0	18	5	0
Хөвсгөл	6	2	0	17	9	2
Хэнтий	7	0	1	17	5	3
Баянзүрх	4	4	0	17	10	2
Хан-уул	4	4	0	11	5	2
Сүхбаатар	4	4	0	19	8	0
Сонгинохайрхан	4	4	0	23	7	2
Чингэлтэй	4	4	0	13	8	1
Баянгол	4	4	0	13	11	2
Налайх	5	2	1	4	2	0
Багануур	5	3	0	4	0	0
Багахангай	6	2	0	3	1	0

Мөн Бүлэг III-аас УИХ-ын сонгуульд хоёр том намын авсан саналын дундаж хувь цаг хугацааны явцад бага зэрэг буурч харин сүүлийн 10 жилийн хугацаанд гуравдагч хүчний саналын хувь нэмэгдсэнийг харж болно. Гуравдагч хүчинд өгөх саналын хувь хэмжээ нэмэгдэж байгаа нь УИХ-д авсан суудлын тоо, эсвэл орон нутгийн сонгуульд ялалт байгуулсан гэдгээс илүү ямар сонгуулийн тогтолцоо сонгосноос шалтгаалж байж

¹ Сонгуулийн тойргийн өөрчлөлтөөс хамаараад Хүснэгт 1-д орсон мэдээллийг Ерөнхийлөгч болон УИХ-ын сонгуулиар харьцуулж харуулахад хүндрэлтэй байв. Тодруулбал, УИХ-ын сонгуулийн хувьд Дорноговь, Говьсүмбэрийг нэг тойрог болгосон, Улаанбаатар хотын сонгуулийн тойргийг жил бүр өөрчилдөг, тухайлбал алслагдсан Налайх, Багануур, Багахангай дүүргүүдийг цөөн хүн амтайгаас нь шалтгаалан нэг тойрог болгох, эргүүлэн салгах зэргээр тогтмол өөрчилж ирсэн гэх мэт.

болох юм. Монгол Улс “багц саналын” тогтолцоог хэд хэдэн удаа ашиглаж ирсэн бөгөөд тоон мэдээллээс харахад энэхүү тогтолцоо нь томоохон улс төрийн намуудад илт давуу байдлыг олгож байна. Учир нь тус тогтолцоонд санал ихээр гээгддэг ба тухайн гээгдсэн санал нь эцсийн дүндээ ялагдсан нэр дэвшигчдийн авсан санал байдаг. Сүүлийн хоёр удаагийн УИХ-ын сонгуульд ялагдсан нэр дэвшигчдийн авсан санал ялалт байгуулсан нэр дэвшигчдийн авсан нийт саналаас хэрхэн давсныг тус бүлгээс харж болно.

Сонгуулийн үр дүнг шинжлэн үзэхэд хоёр том нам болон жижиг намуудын хооронд эвсэл байгуулах нь үр дүнг тодорхойлохуйц ач холбогдолтой байна. АН нь ихэвчлэн эвсэл байгуулсны үр дүнд ялалт байгуулж байсан бол МАН болон МАХН хоёрын хуваагдал нь хэд хэдэн сонгуулийн үр дүнд нөлөөлсөн хамгийн чухал хүчин зүйлүүдийн нэг байсан. Харин МАН, МАХН хоёр эргэн нэгдэж, 2021 оны Ерөнхийлөгчийн сонгуульд оролцсон нь Монгол Улсын ардчиллын түүхэн дэх хамгийн илт давуу ялалт байгуулахад нөлөөлсөн. Улс төрийн намуудын нэгдэл, хуваагдал, эвсэл байгуулах шалтгаан нь тодорхой бодлогын болон нийтлэг үзэл баримтлал бус, илүү хэлцэл, хувийн шинж чанарт тулгуурлах нь бий. “Ашиг сонирхлын” үүднээс улс төрийн эвсэл байгуулж байгаа нь бодлогын нам хөгжихөд сөргөөр нөлөөлж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нөлөө бүхий улстөрчид нэр дэвшихийг эрмэлздэг нь улс төрийн намуудын төлөвшилд сөрөг нөлөө үзүүлдэг тухай Бүлэг IV-т дурджээ. Парламентын засаглалтай бусад оронтой харьцуулахад Монгол Улсын Ерөнхийлөгчид харьцангуй их эрх мэдэл олгогддог учир нөлөө бүхий улстөрчид улс төрийн замналынхаа оргил үед Ерөнхийлөгчийн сонгуульд намаасаа нэр дэвшихийн тулд бүхнийг хийдэг байна. Энэхүү хаалттай явагддаг нам доторх өрсөлдөөн нь намын эв нэгдлийг алдагдуулж, улс төрийн эвслийн бат бөх байдалд сөргөөр нөлөөлж байгаа нь ажиглагддаг.

Цаашдын төлөв

Ойр ойрхон өөрчлөлтүүд хийгдэж ирсэн Монгол Улсын сонгуулийн тогтолцоонд цаашид ч илүү их өөрчлөлтүүд орохоор байна. Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг тодорхой хэмжээнд хязгаарлаж, зургаан жилийн хугацаатай нэг удаа сонгогдох болгосноор УИХ-ын болон Ерөнхийлөгчийн сонгуулийн хоорондох хугацаанд ихээхэн өөрчлөлт оруулж байна. 2023 онд сонгуулийн тогтолцоонд дахин өөрчлөлт оруулахаар яригдаж байгаа бөгөөд үүнийг сонгуулийн шинэ хууль, эсвэл Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар хийх төлөвтэй байна. Энэхүү эмхэтгэл нь ирээдүйд чиглэсэн зөвлөмж болохоос илүү өнгөрсөн хугацаанд зохион байгуулагдсан сонгуулиудыг шинжилж үзсэн болно. Ирээдүйд ашиглах сонгуулийн тогтолцоог тодорхойлоход өнгөрсөн сонгуулиудад нөлөөлсөн хүчин зүйлс, нөхцөл байдал болон легитим байдал зэргийг харгалзан үзэх нь чухал. Аливаа өөрчлөлтийг хийх хамгийн чухал зүйл нь улс төр дэх тал бүрийн төлөөллийн оролцоог хангах бөгөөд ингэснээр тухайн өөрчлөлт нь тогтвортой хэрэгжинэ. Сонгуулийн тогтолцооны тогтвортой байдал нь улс төрийн намууд төлөвших, улс төрийн бодлого боловсронгуй болох, тогтолцооны талаарх сонгогчдын мэдлэг, боловсрол сайжрах, цаашлаад Монгол Улсын ардчилал улам бэхжих боломж бүрдүүлэх юм.

БҮЛЭГ II

СОНГУУЛИЙН НЭР ТОМЬЁНЫ ТАЙЛБАР, ОЙЛГОЛТ

Зохиогч:

Д.Бадамдаш, Э.Гэрэлт-Од, А.Бат-Оргил, А.Алтанзул

Сонгууль

Сонгууль гэж санал өгөх замаар улс төрийн шийдвэр гаргах үйл явцыг хэлнэ. Ардчилсан нийгэмд сонгууль нь төрийн албан тушаалд ажиллах өөрийн төлөөллийг сонгоход сонгогчдын оролцоог удирдах, нийгмийн зөвшилцлийг бий болгох механизм байдаг².

Сонгуулийн тогтолцоо

Сонгуулийн тогтолцоо гэж сонгогч хэдэн саналтай байх, саналаа хэнд өгөх, саналыг ямар аргаар парламентын суудалд хуваарилах зэргийг багтаасан арга, дүрмийг хэлдэг³. Сонгуулийн тогтолцоо нь дараах гурван гол үүргийг гүйцэтгэдэг. Нэгдүгээрт, сонгогчдын өгсөн саналд үндэслэн нам, нэр дэвшигчдийн суудлын тоог тогтоох, хоёрдугаарт, иргэд сонгосон төлөөлөгчидтэйгөө хариуцлага тооцох хэрэгсэл, гуравдугаарт, эрх мэдлийн төлөө өрсөлдөгчид сонгогчидтойгоо харьцах арга замыг сонгох хөшүүрэг болдог. Гэхдээ ихэнх судлаачид сонгуулийн тогтолцоо нь сонгуулийг хэрхэн зохион байгуулахыг тодорхойлсон ерөнхий ойлголт бөгөөд тойрог ямар байх, сонгогч саналаа яаж өгөх, намуудын кампанит ажлын стратеги ямар байх, нэр дэвшигч хэн байх, намын бодлого ямар байх, сонгогчдын саналыг хэрхэн татах, авсан саналыг парламентад хэрхэн хуваарилах зэрэг олон асуудлыг багтаасан ойлголт гэж тайлбарладаг. Тиймээс сонгуулийн тогтолцоо бол өргөн хүрээтэй, улс төрийн тогтолцоонд нөлөөлдөг чухал асуудал юм⁴.

Судлаач Райллигийн⁵ тодорхойлсноор сонгуулийн тогтолцоо нь “сонгуульд өгсөн аливаа саналыг парламент, эсвэл бусад албанд хэрхэн суудал болгохыг заасан журам, үйл ажиллагаа” юм. Сонгуулийн тогтолцоо нь институтийн дараах гурван чухал үүргийг гүйцэтгэдэг болохыг Райлли тэмдэглэжээ⁶:

1. Сонгуулийн тогтолцоо нь сонгогчдын саналыг хууль тогтоох байгууллагад суудал болгон хувиргах,
2. Сонгуулийн тогтолцоо нь сонгогдсон төлөөлөгчдөдөө хариуцлага тооцох,
3. Сонгуулийн тогтолцоо нь эрх мэдлийн төлөө өрсөлдөж байгаа хүмүүст өрсөлдөөний тактик боловсруулахад нь туслах.

² Э.Гэрэлт-Од. 2021. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцооны улс төр, эрх зүйн түүхэн шинжилгээ (1992-2020). судалгааны тайлангийн төсөл. хуудас 2.

³ Сонгуулийн систем Британника нэвтэрхий толь <https://www.britannica.com/topic/electoral-system> [22/12/2022]

⁴ Э.Гэрэлт-Од. 2021. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцооны улс төр, эрх зүйн түүхэн шинжилгээ (1992-2020). судалгааны тайлангийн төсөл. хуудас 2-3.

⁵ Райлли.Б. 2012. Монгол Улсад зориулсан сонгуулийн тогтолцооны хувилбарууд. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн зөвлөх үйлчилгээний тайлан

⁶ Райлли.Б. 2004. Дэлхий дахины давуу эрхтэй санал өгөлтийн тархалт: Австралийн институтийн империализм?. Австралийн Улс Төрийн Шинжлэх Ухааны сэтгүүл. 39(2). хуудас 253-266

Сонгуулийн тогтолцооны ангилал

Улс төрийн шинжлэх ухаанд ардчилсан сонгуулийн тогтолцоог үндсэн хоёр гол тогтолцоонд хуваан авч үздэг. Эдгээр нь ялалт байгуулж буй хувь хэмжээний ялгаанаас үл хамааран ялагч нь бүгдийг авдаг олонхын буюу мажоритар болон авсан саналын хувь хэмжээгээр улс төрийн намуудад суудал хуваарилдаг пропорциональ буюу хувь тэнцүүлсэн тогтолцоо юм. Энэхүү өргөн хүрээний ангилал дотроо сонгуулийн тогтолцоонуудыг олон хуваан авч үзэх ба сонгогчдын саналыг хэрхэн хууль тогтоох байгууллага дахь суудал болгож буйгаас нь шалтгаалан олонх, дийлэнхийн тогтолцоо-мажоритар (plurality/majority), хувь тэнцүүлэх тогтолцоо- пропорциональ систем (proportional- PR), холимог систем (mixed) болон бусад систем хэмээн дахин ангилна⁷. Хамгийн түгээмэл сонгуулийн тогтолцоонууд болон эдгээрийн хоорондын ялгаатай байдалд дараахыг багтаан үзэж болно:

1. Дийлэнх/олонхын тогтолцоо (Majoritarian system): Энэ тогтолцоо нь түгээмэл хэрэглэдэг таван хувилбартай. Үүнд олонхын (plurality) буюу нэр дэвшигчдээс хамгийн олон санал авсан хүн ялах дүрэмтэй харьцангуй олонхын (First past the post-FPTP), багц саналын (Block voting-BV), дийлэнх (majoritarian system) буюу үнэмлэхүй олонхын гэгддэг нийт хүчинтэй саналын талаас илүү буюу 50+1% хувийн санал авсан нэр дэвшигч ялах дүрэм үйлчилдэг хоёр шаттай тогтолцоо (Two round-TRS), алтернатив (Alternative vote-AV) болон намын багц санал (Party block vote-PBV) тогтолцоо тус тус багтана.
2. Хувь тэнцүүлэх тогтолцоо (Proportional system): Хувь тэнцүүлэх тогтолцооны зорилго нь намын авсан саналыг хууль тогтоох байгууллагын суудалд зориудаар хувь тэнцүүлэн хөрвүүлэхэд оршдог. Хувь тэнцүүлэх тогтолцооны үндсэн хоёр хувилбарт намын жагсаалт (List PR), шилжих дан санал (Single transporeble vote-STV) зэрэг тогтолцоо тус тус багтана. Дээрх бүх хувилбарт сонгуулийг улс - нэг тойргоор зохион байгуулдаг.
3. Холимог тогтолцоо (Mixed system): Холимог тогтолцоог дийлэнх/олонхын болон хувь тэнцүүлэх тогтолцооны аль алиных нь шинжүүдийг нэгтгэх оролдлого хэмээн ойлгож болно. Холимог тогтолцоо нь өөр өөр томъёололтой сонгуулийн хоёр тогтолцоог зэрэгцүүлсэн (Paralell system-PS) буюу сонгогчид хоёр, эсвэл үүнээс дээш тооны санал өгч, энэ нь сонгуулийн олонхын болон хувь тэнцүүлсэн хэсэгт тус тусад нь тооцогддог тогтолцоо болон холимог (Mixed Member Proportional-MMP) буюу сонгогч нь нэг мандаттай тойргийн нэр дэвшигчид санал өгч, хамаарах улс төрийн намд өгсөн саналын хувь хэмжээг мөн тооцон суудал хуваарилдаг тогтолцоо гэсэн хоёр хувилбартай.
4. Бусад: Сонгуулийн дийлэнх/олонхын болон хувь тэнцүүлэх аргуудаас өөр үл шилжих дан санал (Single non-transferable vote-SNTV), хязгаарлагдмал санал (Limited vote-LV), Борда санал (Borda count-BC) гэсэн аргуудыг багтаадаг.⁸

Стокхолм хотод байрладаг Ардчилал, Сонгуульд Дэмжлэг Үзүүлэх Олон улсын хүрээлэнгийн (АСДҮОУХ)⁹ үзсэнээр сонгуулийн тогтолцоо нь ардчилсан институтүүдийн легитим байдлыг тодорхойлдог. Ерөнхийдөө сонгуулийн тогтолцоо нь Засгийн газрыг

⁷ Сонгуулийн тогтолцоо (ACE төсөл) <https://aceproject.org/ace-en/topics/es/esd/esd01/esd01c/default> [22.12.2022]

⁸ Э.Гэрэлт-Од. 2021. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцооны улс төр, эрх зүйн түүхэн шинжилгээ (1992-2020). судалгааны тайлангийн төсөл. хуудас 3.


⁹ АСДҮОУХ. (Стокгольм) 2005. Сонгуулийн тогтолцооны загвар: АСДҮОУХ-ийн шинэ гарын авлага.

¹⁰ Мөн тэнд

солих, нийгмийн зөвшилцлийг удирдах арга хэмээн тооцогддог.¹⁰ Өнөөдөр дэлхий нийтэд үндсэн дөрвөн сонгуулийн тогтолцоо буйг Райлли¹¹ 1) олонх-дийлэнхийн тогтолцоо, 2) хагас-хувь тэнцүүлсэн тогтолцоо, 3) хувь тэнцүүлсэн төлөөллийн тогтолцоо, 4) холимог тогтолцоо хэмээн өргөн хүрээнд ангилан үзжээ.

Райлли¹² судлаачийн үзсэнээр хоёр бүлэгт хуваан үзэж болох олонх-дийлэнхийн таван хувилбар байна. Эхний бүлэгт олонхын хоёр тогтолцоо болох харьцангуй олонхын (First past the post-FPTP), багц саналын (Block voting-BV) тогтолцоо багтана. Хоёрдугаар бүлэгт хоёр шатлалтай тогтолцоо (two-round TRS), алтернатив (alternative) болон бусад нэмэлт сонголтын тогтолцоо багтдаг. Түүнчлэн хувь тэнцүүлсэн бүлэгт нээлттэй жагсаалт (Open list), хаалттай жагсаалт (Closed list), дан шилжих саналын (Single transferable vote- STV) тогтолцоо орно. Харин холимог тогтолцоонд холимог хувь тэнцүүлэх (Mixed member proportional-MMP) болон холимог мажоритар (Mixed member majoritarian- MMM) зэрэг хувилбарууд багтана.

Зураг 2. Сонгуулийн тогтолцооны ангилал



Эх сурвалж: Судлаач Райлли¹³ болон IIDEA¹⁴ байгууллагын гаргасан ангилал

Дэлхий нийтэд улс орнууд нь өөрийн улс төр, нийгмийн нөхцөл байдалд нийцүүлэн 200¹⁵ гаруй тогтолцоог ашигладаг. Доорх Зураг 3-т харуулсанчлан нийт орнуудын 46 хувь нь дийлэнх олонхын тогтолцоо, 36 хувь нь хувь тэнцүүлсэн тогтолцоо, 15 хувь нь холимог тогтолцоо, үлдсэн гурван хувь нь “бусад” хэмээх ангилалд хамаарах тогтолцоог ашиглаж байна. Дэлхийн 197 орныг хамруулан хийсэн өөр нэгэн судалгаагаар 70 улс (35 хувь) хувь тэнцүүлсэн тогтолцоог, 47 улс (24 хувь) харьцангуй олонхын (First past the post-FPTP) тогтолцоог ашиглаж¹⁶ буйн тоонд Канад, Нэгдсэн Вант Улс, Энэтхэг, АНУ зэрэг улс багтжээ. Багц саналын (Block voting-BV) тогтолцоог 15 улс ашигладаг бол ердөө есөн улс холимог тогтолцоог ашиглаж байна¹⁷.

¹¹ Райлли.Б. 2012. “Монгол Улсад зориулсан сонгуулийн тогтолцооны хувилбарууд”. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн зөвлөх үйлчилгээний тайлан

¹² Мөн тэнд.

¹³ Мөн тэнд.

¹⁴ АСДҮОУХ. (Стокгольм) 2005. Сонгуулийн тогтолцооны загвар: АСДҮОУХ -ийн шинэ гарын авлага.

¹⁵ Ж.Бямбадорж. 1998. “Сонгох эрх болон Монгол Улсын сонгуулийн тогтолцоог шинэчлэх нь”. Шинэ толь сэтгүүл. №28.

¹⁶ АСДҮОУХ. (Стокгольм) 2005. Сонгуулийн тогтолцооны загвар: АСДҮОУХ-ийн шинэ гарын авлага.

¹⁷ А.Бат-Оргил. 2021. Монгол Улсын сонгуулийн тогтолцоо: Харьцуулсан судалгаа, судалгааны тайлангийн төсөл. хуудас 7.

Зураг 3. Улс орнуудын ашиглаж буй сонгуулийн тогтолцоонууд¹⁸



Сонгуулийн тогтолцоо нь тухайн улс болон нөхцөл байдалд хамгийн сайн тохирч байх ёстой ч төгс тогтолцоо гэж үгүй. Тогтолцоо нэг бүр нь өөрийн гэсэн давуу болон сул талтай байж, эдгээр нь тухайн улсын улс төрийн өрсөлдөөний өрнөл болон үр дүнд нөлөөлж байдаг. Сонгуулийн тогтолцоог сонгохдоо тогтолцоо бүрийн онцлог шинж чанарыг улс орныхоо өвөрмөц нөхцөл байдал, улс төрийн соёлтой уялдуулан судлах шаардлагатай. Энэ чиглэлээр хийсэн судалгаагаар дийлэнх/олонхын болон хувь тэнцүүлсэн тогтолцооны давуу болон сул талыг дараах байдлаар тодорхойлжээ.

Хүснэгт 2. Дийлэнх/олонхын тогтолцооны давуу ба сул тал

Давуу тал	Сул тал
<ul style="list-style-type: none"> Энгийн, ойлгомжтой Засгийн газар тогтвортой ажилладаг Шууд сонгох боломжтой Хамаарах тойргийн сонгогчдын өмнө хариуцлага хүлээдэг Улс төрийн намуудын тоог бууруулдаг 	<ul style="list-style-type: none"> Санал гээгдэнэ Цөөн саналаар олонх болдог Саналын жингийн нөлөөлөл алдагддаг Популизмыг дэвэргэдэг Парламентын гишүүн тойргийн сонгогчдоос хараат Нутгархах/тойрогт хандсан сэтгэл зүй (орон нутагт танигдсан нэр дэвшигчийг сонгох хандлагатай) Намын сахилга, хариуцлага сулардаг

Хүснэгт 3. Хувь тэнцүүлсэн тогтолцооны давуу ба сул тал

Давуу тал	Сул тал
<ul style="list-style-type: none"> Санал гээгддэггүй Саналын төлөөлөл алдагдахгүй Улс төрийн хүчний зохистой харьцаа хангагддаг Парламентат ёс хөгжих Намуудын төлөвшилд сайнаар нөлөөлдөг Хариуцлага хүлээх субъект тодорхой Улс төрийн соёлын өндөр түвшин 	<ul style="list-style-type: none"> Хэт олон сул, жижиг нам бий болох Жижиг намууд парламентад орж ирэх Тогтворгүй Засгийн газар Бие даан нэр дэвшигчдэд халгаатай Улс төржих сэтгэл зүй нэмэгдэх Орон нутгийн төлөөлөл, ашиг сонирхлыг хангах чадвар сул Сонгогчоос гишүүнд хяналт тавих боломж сул

Сонгуулийн тогтолцоог сонгохдоо улс төрийн тогтолцооны олон төрлийн зарчмуудыг харгалзан үзэхийг судлаачид зөвлөдөг. Жишээ нь, судлаач Райлли сонгуулийн тогтолцоог төлөвлөхөд баримтлах хамгийн түгээмэл шалгууруудыг гаргаж ирсний дотор шударга төлөөлөл бий болгох; сонгуулийг хүртээмжтэй, утга учиртай болгох; эвлэрлийг бий болгох; тогтвортой, үр ашигтай Засгийн газар ажиллуулах боломжоор хангах; төрийг хариуцлагатай байлгах; сонгогдсон гишүүдийг хариуцлагатай байлгах, хариуцлага тооцох боломжийг нээх; улс төрийн хүчнүүдийг дэмжих; хууль тогтоох байгууллагад сөрөг хүчин, хяналтыг бий болгох; сонгуулийн үйл явцыг тогтвортой байлгах; болон “олон улсын стандартыг” харгалзах зэрэг шалгуурууд багтажээ.¹⁹ Судлаач Хоровицийн хувьд анхааралдаа авах зургаан зорилгыг тогтоосон нь санал болон суудлын хувийн тэнцвэрт байдал; сонгогчдын өмнө хүлээх хариуцлага; тогтвортой Засгийн газар; олонхоор баталгаажсан ялалт (Condorset winners); угсаатан болон шашин хоорондын эвлэрэл; цөөнхийн төлөөллийг дэмжих²⁰ зэргийг багтаажээ.

Аливаа улс орон өөрийн улс төрийн тогтолцоо, институтын төлөвшил, сонгогчдын боловсрол зэрэг асуудлыг сайтар судалж байж өөрт тохирсон сонгуулийн тогтолцоог сонгох учиртай. Учир нь ардчилал хөгжих, эсэх нь сонгуулийн тогтолцоогоо зөв сонгосон, эсэх, сонгуулийн хуулиа сайн боловсруулсан, эсэх, сонгуулиа хуулийн хүрээнд зохион байгуулж чадсан эсэхээс шууд хамаардаг. Өөрөөр хэлбэл, сонгуулийн ямар тогтолцоо сонгохоос шалтгаалж нам, намын систем, парламент, Засгийн газар, сонгогчид төлөвшдөг, улмаар ардчилал тодорхойлогддог ажээ.²¹

Сонгуулийн тогтолцоог сонгохдоо улс орны улс төр, эдийн засгийн суурьтай холбоотой чухал шийдвэр гаргахыг шаарддаг. Тухайн шийдвэрийг гаргахдаа харилцан эсрэг тэсрэг зорилтуудыг эрэмбэлснээр хамгийн зөв зохистой шийдвэрийг гаргадаг.²² Жишээ нь, аль нэг улс иргэдийн өгсөн саналыг зөвөөр тусгасан парламенттай болох хүсэлтэй бол хувь тэнцүүлсэн тогтолцоо тохиромжтой байдаг. Гэвч энэхүү тогтолцоо нь улс төрийн аль ч нам олонх болохгүй байх нөхцөл үүсгэж, үүний үр дүнд Засгийн газар ойр ойрхон солигдоход хүргэдэг тул Засгийн газрыг тогтвортой байлгах гэсэн зарчимтай зөрчилдөж болно. Тиймээс улс орнууд нь сонгуульд хамаарах өөрийн зорилгыг юун түрүүн эрэмбэлэн тогтоосны үндсэн дээр сонгуулийн тогтолцоогоо сонгох шаардлагатай.

Сонгуулийн тогтолцооны шинжилгээний нийтлэг хамрах хүрээ

Дэлхий даяар ашиглаж буй төрөл бүрийн сонгуулийн тогтолцооны нөлөөлөл, үр дүнг судалсан олон тооны судалгаа хийгджээ. Дараагийн бүлэгт эдгээр судалгаа, шинжилгээнд тулгуурлан Монголын сонгуулийн түүх, туршлага, үйл явцыг шинжиллээ. Дараагийн бүлгүүдэд өгүүлэх санаа, дүн шинжилгээг ойлгомжтой болгох зорилгоор доорх онолын нэр томъёоны тайлбарыг оруулав.

Дювержегийн хууль: Дювержегийн үзсэнээр²³ дийлэнх/олонхын тогтолцоо нь хоёр намын тогтолцоог үүсгэдэг гэж үзсэн ба үүнийг Дювержегийн хууль гэж нэрийддэг.

¹⁹ Рейнольд. Эндрю. Райлли. Бенжамин. Эллис. Эндрю. (Стокгольм) 2005, Сонгуулийн тогтолцооны загвар: АСДҮОУХ -ийн шинэ гарын авлага.

²⁰ Доналд Л Хоровиц. 2003. Сонгуулийн тогтолцоо болон эдгээрийн зорилго: шийдвэр гаргалтын суурь. <https://aceproject.org/ero-en/topics/electoral-systems/E6ElectoralSystemsHorowitz.pdf> [22/12/2022]

²¹ Э.Гэрэлт-Од. 2021. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцооны улс төр, эрх зүйн түүхэн шинжилгээ (1992-2020). Судалгааны тайлангийн төсөл. хуудас. 5.

²² АСДҮОУХ. (Стокгольм) 2005. Сонгуулийн тогтолцооны загвар: АСДҮОУХ -ийн шинэ гарын авлага.

²³ Дюверже.М. 1954. Улс төрийн намууд: Орчин үеийн улсууд дах намын бүтэц ба үйл ажиллагаа. Метуен & Компани.

Энэхүү тогтолцоонд сонгуульд ялсан тал нь засаглах эрхийг бүрэн авахад хүргэдэг ба үүнийг зарим тохиолдолд ялагч-бүгдийг-авдаг тогтолцоо гэдэг. Нөгөө талаар хувь тэнцүүлсэн тогтолцоо нь олон тооны намуудад цөөн тооны суудал хуваарилдаг тогтолцоо билээ. Үүний улмаас заримдаа аль ч нам хангалттай суудал авч чадаагүйгээс эвслийн Засгийн газар байгуулах боломжгүйд хүрч, энэ нь тогтворгүй байдлыг үүсгэдэг. Улмаар урт хугацаандаа энэ нь ардчилсан хариуцлагын зарчмыг сулруулдаг.²⁴ Хувь тэнцүүлсэн тогтолцоонд босго хувь нь парламент дахь намуудын тоог хязгаарлах, эсэхийг тодорхойлдог. Бьоркийн²⁵ үзсэнээр босго хувь өндөр буюу 5-8 байх үед парламентад төлөөлөл бүхий намын тоо хязгаартай байдаг аж. Эцэст нь холимог мажоритар тогтолцооноос улс төрийн намуудын төлөөлөлд үзүүлэх нөлөөлөл нь мажоритар болон хувь тэнцүүлсэн тогтолцооны дунд нь оршдог байна.²⁶

Үр ашигтай намын тоо (ENP), Сонгуулийн үр ашигтай намын тоо (ENEP)/ Парламентын үр ашигтай намын тоо (ENPP): Лааксо болон Таагепера²⁷ нарын боловсруулсан үр ашигтай намын тоон индекс нь Дювержегийн хууль болон сонгуулийн тогтолцоон дахь бусад ойлголтыг илүү тодруулж өгсөн. Улс төр судлаачид үр ашигтай намын тоон индексийг бүхий л улс төрийн намын тогтолцоонд хэдэн улс төрийн тоглогч бодитоор өрсөлдөж буйг харуулахын тулд ашигласан байдаг. Үр ашигтай намын тоон индексийг сонгуулийн үр ашигтай намын тоо (ENEP) болон парламентын үр ашигтай намын тоо (ENPP) тоон индекс гэж хоёр дэд хэсэгт хуваана. Сонгуулийн үр ашигтай намын тоон индекс нь сонгуульд яг хэдэн улс төрийн нам бодитоор өрсөлдөж буйг харуулдаг. Жишээ нь, саналын хуудсанд 10 ба түүнээс дээш нам бичигдсэн байсан ч сонгууль зөвхөн үр ашигтай цөөхөн намын хооронд явагддаг.

Үр ашигтай намын тоон индексийг доорх томъёогоор тооцдог.²⁸

Үр ашигтай намын тоо:

$$N_v = \frac{1}{\sum (P_v)^2} \quad P_v \text{ нь намын авсан саналын хувь хэмжээг илэрхийлнэ.}$$

Парламентын үр ашигтай намын тоо:

$$N_s = \frac{1}{\sum (P_s)^2} \quad P_s \text{ нь намын авсан суудлын хувь хэмжээг илэрхийлнэ.}$$

Сонгуулийн тогтолцооны зохист²⁹ харьцааны хэмжүүр (Measures of disproportionality in electoral systems): Улс төр судлаач Майкл Галлагер³⁰ “Парламент дахь намд хуваарилсан суудал болон тухайн намд өгсөн нийт саналын тоо хоёрын пропорциональ тэнцвэргүй байдал нь сонгуулийн тогтолцоог ойлгож, дүн шинжилгээ хийх суурь болно” хэмээн зохист харьцааны асуудлыг авч үзэхийг санал болгосон байдаг.

²⁴ Рейнольд, Эндрю. Райлли, Бенжамин. 1997. АСДҮОУХ, Улс төрийн тогтолцооны загварын гарын авлага №91.

²⁵ РА.Бьорк & С.Ж.Сеси, 2003. Редакц: Хэвлэл дэх Шинжлэх ухаан, улс төр ба хүчинхийлэл, нийтийн ашиг сонирхол дахь Сэтгэл судлалын шинжлэх ухаан, 4 i-iii.

²⁶ Рейнольд, Эндрю. Райлли, Бенжамин. 1997. АСДҮОУХ, Улс төрийн тогтолцооны загварын гарын авлага №91.

²⁷ Лааксо & Таагепера. 1979. Үр ашигтай намуудын тоо: Баруун Европын туршлага, хэрэглээ, харьцуулсан улс төрийн судалгаа. 12. хуудас 3-27.

²⁸ Лааксо & Таагепера. 1979. Үр ашигтай намуудын тоо: Баруун Европын туршлага, хэрэглээ, харьцуулсан улс төрийн судалгаа. 12. хуудас 3-27.

²⁹ Энэхүү нэр томъёо нь Монгол хэлэнд албан ёсоор орчуулагдаагүй бөгөөд судлаачид зохист харьцаа, зохисгүй харьцаа, хувь тэнцүүлсэн харьцаа гэх мэт өөр өөрөөр хэрэглэж байна.

³⁰ Майкл Галлагер. 1991. Пропорциональ, пропорциональ бус байдал болон сонгуулийн тогтолцоо судалгаа. 10 (1). хуудас 33-51

Түүний судалгаа нь цаашлаад Галлагерын зохист харьцааны бага квадратын индекс (Least square index) болж хөгжсөн. Хэрэв сонгуулийн зорилго нь сонгогчдын өгсөн саналыг парламент дахь суудал болгон хувиргах, аль болох төгс байдлаар тусгах явдал хэмээн хүлээн зөвшөөрвөл³¹ тухайн тогтолцоо уг зорилгод хэр сайн үйлчилж буйг ойлгоход энэхүү индекс нь тусална. Галлагерын³² сонгуулийн хувь тэнцүү байдлын харьцаа нь саналыг хэрхэн суудал болгон хувиргаж байгаа, сонгуулийн тогтолцооноос хамааран хэр хэмжээнд санал нь гээгдэж буйг харуулдаг. Тиймээс жишээ нь, улс төрийн нэг нам харьцангуй бага хувийн санал авч болох ба зохист харьцаа нь өндөр тохиолдолд эдгээр бага санал нь хэт олон тооны суудал болон хувирч парламентад олонх болоход хүргэх боломжтой.

Зохист харьцааны индексийг дараах томъёог ашиглан тооцно:

$$LS_q = \sqrt{\left(\sum_i (s_i - v_i)^2\right) / 2}$$

$S_i - V_i$ нь суудал болон авсан саналын хувь хэмжээний зөрүүг илэрхийлнэ.

Сонгуулийн зохист харьцааны индексийг тооцоход индексийн хувь хэмжээ өндөр байх тусам сонгуулийн зохист харьцаа өндөр байдаг.

Монгол Улсын сонгуулийн тогтолцоог ижил төстэй орнуудтай харьцуулсан дүн шинжилгээ

Монгол Улсын сонгуулийн талаар илүү нарийвчлан судлахын өмнө ижил төстэй улс орнуудтай харьцуулан судлах хэрэгтэй. Хүснэгт 4-т Монгол Улстай улс төр, эдийн засгийн нөхцөл байдлаараа ижил төстэй 25 орны сонгуулийн тогтолцоог харуулав. Энэхүү хүснэгтээс 13 улс хувь тэнцүүлсэн тогтолцоог, долоон улс холимог тогтолцоог, гурван улс харьцангуй олонхын, нэг улс буюу зөвхөн Австрали улс л алтернатив тогтолцоог ашиглаж буйг харж болно. 1990 онд ардчилсан тогтолцоонд шилжсэн Зүүн Европын улс орнууд үндсэндээ хувь тэнцүүлсэн болон холимог-хувь тэнцүүлсэн тогтолцоог сонгожээ. Ази-Номхон Далайн бүсийн ардчилсан улсууд нь холимог тогтолцоог илүү үзэж байна. Сүүлийн жилүүдэд сонгуулийг багц саналын (Block voting) тогтолцоогоор зохион байгуулснаараа Монгол Улс бусад улсуудаас ялгарч байна. 2012 оны сонгуульд Монгол Улсын ашигласан дийлэнх олонхын тогтолцоо нь энэхүү жагсаалтад оруулж харьцуулах боломжгүй тохиолдол юм.

³¹ Б.Райлли. 2007. Сонгуулийн болон улс төрийн шинэчлэл. Р.Н.Маклеод & А.Макинтайр нарын хянан тохиолдуулсан, Индонез:Ардчилал ба сайн засаглалын амлалт. Зүүн өмнөд судлалын институт, Сингапур. хуудас 41-54

³² Майкл Галлагер. 1991. Пропорциональ, пропорциональ бус байдал болон сонгуулийн тогтолцоо судалгаа. 10 (1), хуудас 33-51

Хүснэгт 4. Улс орнуудын сонгуулийн тогтолцооны судалгаа

Улс орнууд (хоёр танхимтай = +)	Сонгуулийн тогтолцоо	Саналын босго (%)	Нэг тойрогт хамаарах суудлын дундаж тоо	Парламент дахь нийт суудал	Нээлттэй жагсаалт ашигладаг эсэх	Жендерийн квот (%)
Албани	Холимог Хувь тэнцүүлсэн	3	11.7	140		30
Армени	Хувь тэнцүүлсэн	5	10.2	132	+	25
Азербайжан	Харьцангуй олонхын (FPTP)	-	1	125		
Беларусь (+)	Харьцангуй олонхын (FPTP)	-	1	110		
Босни-Герцоговина (+)	Хувь тэнцүүлсэн	3	21	42	+	40
Болгар	Хувь тэнцүүлсэн	4	7.7	240		
Хорват	Хувь тэнцүүлсэн	5	14	150	+	40
Чех (+)	Хувь тэнцүүлсэн	5	14.3	200	+	
Эстони	Хувь тэнцүүлсэн	5	8.4	101	+	
Унгар	Холимог Харьцангуй олонхын (FPTP) - DH	5	1-93	199		
Киргизстан	Хувь тэнцүүлсэн	7	120	120		
Латви	Хувь тэнцүүлсэн	5	25	100	+	
Литва	Холимог - Хоёр шаттай- хувь нийлүүлсэн	5	1-70	141	+	
Молдова	Холимог Харьцангуй олонхын (FPTP) -LR	5	1-50	101		40
Монгол	Намын багц санал	-	2.6	76		20
Польш (+)	Хувь тэнцүүлсэн	5	21.9	460	+	35
Румын (+)	Хувь тэнцүүлсэн	5	7.3	329		
Серби	Хувь тэнцүүлсэн	3	250	250		30
Словак	Хувь тэнцүүлсэн	5	150	150	+	
Словени (+)	Хувь тэнцүүлсэн	4	8	90	+	35
Украйн	Холимог Харьцангуй олонхын (FPTP) - LR	5	1-225	450		
Өмнөд Солонгос	Холимог (хувь тэнцүүлсэн LR (Largest Remainder)+ Харьцангуй олонхын (FPTP)	3		300		Сайн дурын
Малайз	Харьцангуй олонхын (FPTP)	-	1	222	+	-
Австрали (+)	Алтернатив	-		151		Сайн дурын
Шинэ Зеланд	Холимог (MMP =FTPT)	5	1	120		Сайн дурын

Эх сурвалж: Борманн, Голдер (2013); АСДҮОУХ (2020); Касал Бертоа (2020)

Минтромын³³ боловсруулсан харьцуулсан чанарын судалгааны арга зүйг ашиглан сонгуулийн тогтолцоо хоорондын ижил төстэй болон ялгаатай талыг тодорхойлж болно. Монгол Улстай харьцуулахаар сонгуулийн тогтолцоо, газар нутгийн байршилд үндэслэн төлөөлөл болгон дөрвөн улсыг сонгосон. Үүнд пост коммунист Унгар (холимог), Польш (хувь тэнцүүлсэн), мөн Ази Номхон далайн бүсийг төлөөлөх Австрали (алтернатив), Малайз (харьцангуй олонх) зэрэг улс багтав.

Хүснэгт 5. Институтийн харьцуулсан шинжилгээ

Харьцуулж буй орнууд	Холбоотой институтийн дизайн	Ажиглагдсан практикууд	Ажиглагдсан үр дүнгүүд
Монгол	Багц санал (Block voting)	<ul style="list-style-type: none"> УИХ нь нэг танхимтай, 76 гишүүнтэй; УИХ-ын 2020 оны сонгууль нь багц саналын (Block voting) тогтолцоогоор явагдсан (дийлэнхийн тогтолцоо). 1992 оноос хойш сонгуулийн 4 өөр тогтолцоог ашигласан (харьцангуй олонх- FPTP, хоёр шатлалтай тогтолцоо-TRS, холимог- MMM, багц санал- Block Voting) 1992 оноос хойш нийт 8 удаагийн сонгууль зохион байгуулснаас МАН зургаан удаа олонх (үүний дөрөвт нь үнэмлэхүй олонх) болж, АН нэг удаа ялалт байгуулсан (энгийн олонхоор). 2004, 2008 болон 2012 оны сонгуулийн дараа эвслийн Засгийн газар байгуулагдсан. 	<ul style="list-style-type: none"> Парламентын үр ашигтай намын тоо 1.8, сонгуулийн үр ашигтай намын тоо 2.9 буюу хэт төвлөрсөн. Зохист харьцааны индекс (дундаж) 1992 оноос хойш 18.6. 1990- 2019 онд намын тогтолцооны төлөвшлийн индекс 89.1.³⁴ Нэг нам давамгайлах тогтолцоотой.
Унгар	Холимог (Mixed Member Proportional)	<ul style="list-style-type: none"> 2012 онд Үндэсний ассамблейн 386 гишүүнийг дараах байдлаар сонгосон: 176 гишүүнийг нэг мандаттай тойргоос хоёр шатлалт сонгуулиар; 146 гишүүнийг хувь тэнцүүлсэн тогтолцоогоор 5%-ийн босготой (MMP) сонгосон. 2012 онд хоёр шатлалт тогтолцоог (two- round) харьцангуй олонхын (FPTP) тогтолцоо болж өөрчилсөн. 1990 оноос хойш тус улсад 8 удаагийн сонгууль зохион байгуулагдсан ба үүний нэгээс бусад бүх сонгуулийн дараа эвслийн Засгийн газар байгуулагдан ажилласан. Фидес нам, Унгарын социалист нам болон Ардчилсан форум намууд голлон өрсөлддөг. 	<ul style="list-style-type: none"> Парламентын үр ашигтай намын тоо 2.6 (1990- 2020), сонгуулийн үр ашигтай намын тоо 4.1.³⁵ Зохист харьцааны индекс (дундаж) дээрх хугацаанд 12.2.³⁶ Намын тогтолцооны хувьд хоёр шатлалт блок тогтолцоотой ба 1990 оноос хойш индекс нь 88.6.

³³ М.Минтром. 2011. Орчин үеийн бодлогын дүн шинжилгээ. Оксфорд Их Сургуулийн хэвлэл

³⁴ Фернандо Касал Бертоа. 2020. Намын тогтолцооны уналт: Европ дахь намын холбоо, засаглалын хувилбарууд ба ардчилал, Оксфорд Их Сургуулийн хэвлэл

³⁵ Who Governs Europe, 2020. <https://whogoverns.eu/>, [22/12/2022]

³⁶ Мөн тэнд.

Польш	Хувь тэнцүүлсэн	<ul style="list-style-type: none"> • Хоёр танхимт: Доод танхимын 460 гишүүнийг хувь тэнцүүлсэн- нээлттэй жагсаалтаас (5% босго, ДХондт арга (D'Hondt method)), харин дээд танхимын гишүүдийг харьцангуй олонхын (FPTP) тогтолцоог ашиглан сонгосон. • 1991- 2019 оны хооронд 8 удаагийн парламентын сонгууль зохион байгуулсан ба долоон сонгууль дээр аль ч улс төрийн нам олонх болоогүй тул эвслийн Засгийн газар байгуулсан. 	<ul style="list-style-type: none"> • Парламентын үр ашигтай намын тоо 4.1 (1991- 2019), сонгуулийн үр ашигтай намын тоо 5.9.³⁷ • Зохист харьцааны индекс (дундаж) дээрх хугацаанд 8.3.³⁸ • Намын тогтолцооны хувьд төлөвшиж, институтчилэгдсэн индекс нь 82.3 (1991-2019). • Олон туйлт намын тогтолцоо.
Малайз	Харьцангуй олонх (FPTP)	<ul style="list-style-type: none"> • 222 танхимын гишүүнийг харьцангуй олонхын (FPTP) тогтолцоо ашиглан сонгодог. • Үндэсний фронт (Барисан) нам 2018 оныг хүртэл эрх барьсан ба 2018 оноос Бакатан харапан буюу Итгэл найдварын эвсэл сонгуульд ялалт байгуулсан. 	<ul style="list-style-type: none"> • 2008 оноос хойш сонгуулийн үр ашигтай намын тоо 6, парламентын үр ашигтай намын тоо 5.4.³⁹ • 2008 - 2018 онд зохист харьцааны индекс 9.3.⁴⁰
Австрали	Алтернатив (Alternative voting) ⁴¹	<ul style="list-style-type: none"> • Парламент нь 2 танхимтай ба доод танхимын 151 гишүүнийг алтернатив тогтолцоогоор, дээд танхимын 76 гишүүнийг шилжих дан саналын аргаар (single transferable voting) сонгодог. • 1990 оноос хойш Австралийн Хөдөлмөрийн Нам ба Либерал Нам, Үндэсний Намын Эвсэл засгийн газар байгуулж ирсэн (Хөдөлмөрийн Нам 4 удаа; Эвсэл 7 удаа). 2010 онд Хөдөлмөрийн Нам нь бие даасан гурван гишүүн, Ногоон намын нэг гишүүний хамтаар Засгийн газар байгуулсан. 	<ul style="list-style-type: none"> • 1990- 2020 онд сонгуулийн үр ашигтай намын тоо 3.6, парламентын үр ашигтай намын тоо 2.7.⁴² • Дундаж зохист харьцааны индекс 10.⁴³ • 1x1+1 намын тогтолцоо бий болсон.

³⁷ Мөн тэнд.

³⁸ Мөн тэнд.

³⁹ М. Галлагер. 2019. Сонгуулийн индексийн өгөгдлийн барц. https://www.tcd.ie/Political_Science/people/michael_gallagher/EISystems/index.php [22/12/2022]

⁴⁰ Мөн тэнд.

⁴¹ Алтернатив тогтолцоо нь мажоритар тогтолцооны нэг хувилбар. Нэр дэвшигч нь 50% + 1 саналаар сонгогдох тул тогтолцоо нь сонгуулийн болон гишүүний легитим байдлыг сайжруулж өгдөг. Энэхүү тогтолцоонд сонгогчид нь өөрийн сонголтыг 1, 2 болон 3 дахь сонголт хэмээн хийдэг. Хэрэв нэр дэвшигчийн аль нь ч 50% + 1 санал авахгүй бол 2 болон 3 дугаар саналуудыг олонхын санал авах хүртэл нь тоолно. Ренвикийн (Renwick, 2011) тодорхойлсон алтернатив тогтолцоо нь саналын алтернатив хувилбарыг нэмэгдүүлдэг ч тактикийн сонголтыг бууруулдаг. Австралиас гадна Папуа Шинэ Гвиней болон Фижи улсууд энэ тогтолцоог ашигладаг. 2000 онд Босни улсад орон нутгийн сонгуульд энэ тогтолцоог ашигласан. Мөн АНУ-ын хэд хэдэн муж энэ тогтолцоог ашиглаж эхэлсэн нь их анхаарал татаж байна (Reilly, 2004). Жишээ нь, Сан-Францискод энэ системийг 2002 онд ашиглажээ.

⁴² М. Галлагер. 2019. Сонгуулийн индексийн өгөгдлийн барц. https://www.tcd.ie/Political_Science/people/michael_gallagher/EISystems/index.php [22/12/2022]

⁴³ Мөн тэнд.

Харьцуулан судлахаар сонгон авсан улсуудад үүсэж буй үр дүнг судлахад тэдний ашиглаж буй таван сонгуулийн тогтолцоо нь дараах дүгнэлтэд хүргэж байна. Үүнд:

- Польш улсад хэрэглэсэн хувь тэнцүүлсэн тогтолцоо нь намын хагаралд хүргэсний зэрэгцээ хэт олон тооны улс төрийн нам өрсөлдөж буйн улмаас байнга эвслийн Засгийн газар байгуулахад хүргэсэн. Хувь тэнцүүлсэн тогтолцоо ашигласнаар санал гээгдэх нь бага байх хандлагатай байна.
- Унгар улсад холимог хувь тэнцүүлсэн тогтолцоо ашигладаг ба парламентын үр ашигтай намын индекс 2.6, сонгуулийн үр дүнтэй намын индекс 4.1 байгаа нь намуудын өрсөлдөөн харьцангуй эрүүл гэдгийг харуулж байна. Гэвч зохист харьцааны индекс нь харьцангуй өндөр байна.
- Малайз нь Монгол Улс 2016 онд ашигласантай нэгэн адил харьцангуй олонхын (FPTP) тогтолцоог ашигладаг. Энэ нь бусад нам нь суудал авдаг ч нэг нам давамгайлахад хүргэж байна. Монгол Улсаас ялгаатай нь Малайзын парламентад харьцангуй олон тооны намын төлөөлөл байдаг.
- Австралийн алтернатив сонгуулийн тогтолцоо нь өрсөлдөөнийг 3-4 намаар хязгаарлаж, эдгээрээс 2-3 нь парламентад суудал авах боломж бүрдүүлж байна. Зохист харьцаа нь дунджаар 10 байгаа нь харьцуулан судалсан орнуудын дундажтай ойролцоо байна.

Сонгуулийн тогтолцоо нь намуудын хагарал, хуваагдлыг бий болгох ч нөгөө талаар улс төрийн намын хөгжил төлөвшил, институтчилэгдэх явцыг дэмждэг байх ёстой. Гэвч хэт их хуваагдал үүсгэх нь экстремист улс төрийг өдөөж, Засгийн газрыг тогтворгүй байхад хүргэдэг.⁴⁴ Үүний зэрэгцээ сонгуулийн тогтолцоонд баримтлах тусгайлсан дүрэм журам, үнэт зүйлс нь тухайн улсын өвөрмөц түүх, улс төрийн соёлтой уялдан нийцэж байх ёстой ба уялдан нийцүүлээгүй сонгуулийн тогтолцоо нь улс төр, засаглалын таагүй үр дүнд хүргэх боломжтойг бид ойлгож эхэлж байна.

Энэ бүлэгт багтсан ойлголт болон харьцуулсан судалгаа нь дараагийн бүлэгт Монгол Улсын парламентын сонгуулийн талаар илүү нарийвчилсан дүн шинжилгээ хийхэд суурь үндэслэл болно.

⁴⁴ Фернандо Касал Бертоа. 2020. Намын тогтолцооны уналт: Европ дахь намын холбоо, засаглалын хувилбарууд ба ардчилал. Оксфорд Их Сургуулийн хэвлэл

БҮЛЭГ III

МОНГОЛ УЛС ДАХЬ ПАРЛАМЕНТЫН СОНГУУЛЬ

Зохиогч:

Д.Бадамдаш, Марк Кэйниг, Э.Гэрэлт-Од, А.Бат-Оргил, А.Алтанзул

Монгол Улс 1990 онд нэг намтай авторитар улс төрийн тогтолцооноос олон намтай, хүний эрхийг хүндэтгэсэн, чөлөөт ардчилсан сонгуультай, нээлттэй улс төрийн тогтолцоог сонгоод даруй 30 жил болжээ. Шинэ Үндсэн хуулийг 1992 онд баталснаас хойш Монголд УИХ-ын сонгуулийг найман удаа зохион байгуулж, үүний үр дүнд нэг танхимт парламент болох УИХ-ыг найман удаа эмхлэн байгуулсан. Ихэнх ажиглагчийн зүгээс эдгээр сонгуулиудыг ерөнхийдөө чөлөөт, ардчилсан сонгууль болсон хэмээн үздэг.


Эдгээр сонгуульд МАХН/МАН нийт таван удаа, АН-ын тэргүүлсэн эвсэл хоёр удаа ялж, нэг удаа буюу 2004 онд эвслийн/эв нэгдлийн Засгийн газар байгуулагдаж байжээ. Монгол Улс нь эдгээр сонгуулийг амжилттай удирдан зохион байгуулж, энэ хугацаанд бүрдсэн бүхий л парламент нь бүрэн эрхийн дөрвөн жилийн хугацаагаа бүрэн дуусгаж, эрх мэдлийг тайван замаар шилжүүлэн өгчээ. Гэвч үүний зэрэгцээ сонгуульд оролцох сонгогчдын ирц тогтмол буурч, парламентад итгэх олон нийтийн итгэл суларч буй нь парламентын институтийн легитим байдалд илүү их сорилт учруулж байна. Эдгээр сорилтын эх үүсвэр нь бүхэлдээ бус ч ямар нэгэн байдлаар сонгож авсан сонгуулийн тогтолцоо, үүний тогтвортой бус байдалтай хамааралтай байна. Монгол Улс нь бараг сонгуулийн бүхий л мөчлөг дээр өөрийн сонгуулийн хуульд өөрчлөлт оруулж ирсэн ба ихэнх сонгуулийг дийлэнх/олонхын тогтолцоог ашиглан явуулсан ч (нэг удаа 2012 онд холимог тогтолцоог ашигласнаас бусдаар) тогтолцооны доторх нарийн зохицуулалтууд байнга өөрчлөгдөж ирснээр таамаглах боломжгүй байдлыг ихээр нэмэгдүүлж, тухайн сонгуулийн үйл явцад итгэх иргэдийн итгэлд эргэлзээ төрүүлэх болжээ. Мөн тогтолцоонд зохист харьцаа ихээр алдагдаж буйг харж болох ба тодорхой нэг намын авсан саналын хувь хэмжээ болон авсан суудлын тооны зөрүүгээр энэ нөхцөл тодорхойлогдоно. Монгол Улсад өмнө нь ашиглаж байсан сонгуулийн өөр өөр тогтолцоо ба эдгээрийн улс төрийн нам, улс төрийн өрсөлдөөн болон засаглалд үзүүлж буй нөлөөллийг нухацтайгаар шинжилж үзэх нь цаашид ашиглах сонгуулийн тогтолцоог сонгоход чухал ач холбогдолтой.

Сонгуулийн тогтолцооны тогтворгүй байдлын үр дагаврын дүн шинжилгээ

Монгол Улсын парламентын сонгуульд дүн шинжилгээ хийхэд тогтолцооны тогтворгүй байдал нь хүндрэл учруулж байна. Монгол Улс нь өөрийн парламентын сонгуулийн тогтолцоог нийт долоон удаа өөрчилсөн ба ялангуяа 1992, 1996, 2005, 2011, 2015, 2016 болон 2019 онд УИХ-ын сонгуулийн өмнө өөрчилжээ. Эдгээр өөрчлөлтийн тавыг нь бусад хуулийн өөрчлөлтөөр (эдгээрийн зарим нь Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр), хоёрыг нь сонгуулийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр хийсэн байна. Эдгээр бүхий л өөрчлөлтийг сонгуулиас өмнө хийж, үүнийг эрх баригч нам “сонгуулийн хуулийг

сайжруулах” шаардлагатай гэсэн үндэслэлээр зөвтгөж иржээ.⁴⁵ УИХ-ын зүгээс тухайн хийсэн нэмэлт өөрчлөлтүүдийг ирэх сонгуульд өрсөлдөхөөр төлөвлөж буй гишүүд оролцон хийсэн байдаг. Энэхүү хууль тогтоох үйл явцыг тухайн үеийн улс төрийн байдал болон Монгол Улсын сонгуулийн тогтолцоонд ямар зарчим, үнэт зүйлсийг баримтлах гэхээс илүүтэйгээр эрх баригч намд ашигтай байдлыг тооцсоны үндсэн дээр хийсэн өөрчлөлт хэмээн үзэж болно. Зураг 4 нь шинээр батлан гаргасан сонгуулийн хуулиуд, нэмэлт өөрчлөлтүүдийг багц саналын, харьцангуй олонхын болон холимог буюу зэрэгцүүлсэн систем хооронд шилжилт хийж байсан түүхийг харуулж байна.

Зураг 4. УИХ-ын сонгуулийн хууль, сонгуулийн тогтолцоонд хийгдсэн өөрчлөлтүүд



Эх сурвалж: Э.Гэрэлт-Од, УИХ-ын сонгуулийн тогтолцооны улс төр, эрх зүйн түүхэн шинжилгээ 1992-2020

Сонгуулийн хууль болон тогтолцоонд хийгдсэн эдгээр өөрчлөлтийг эргэн харвал Монгол Улс нь харьцангуй олонхын тогтолцоог 4 удаа (нэг тойрог нэг мандат) 1996, 2000, 2004 болон 2016 онд, багц саналын тогтолцоог (олон мандаттай жижиг тойрог) гурван удаа 1992, 2008 болон 2020 онд, холимог зэрэгцүүлсэн тогтолцоог нэг удаа 2012 онд ашиглажээ. 2012 оны сонгуулиас бусад оны сонгуульд мажоритар буюу дийлэнх/олонхын тогтолцоог ашигласан гэж зарим судлаач үздэг.⁴⁶ Гэвч ихэнх стандарт тодорхойлолтын дагуу 1996, 2000 болон 2004 онд ашигласан тогтолцоог л мажоритар

⁴⁵ Дараах хууль тогтоомж, нэмэлт өөрчлөлтүүд багтсан:

1. УИХ-аас Сонгуулийн тухай анхны хуулийг 1992 оны дөрөвдүгээр сарын 4-нд баталсан. Хуулийн 8.1 дүгээр зүйлд УИХ-ын 76 гишүүнийг олон мандаттай тойргоос сонгоно гэж заасан. Энэ нь сонгуулийн дийлэнх/олонхын тогтолцооны (Block voting) хувилбар юм. Хожим 1996 онд ээлжит сонгуулиас хоёр сарын өмнө уг хуулийн 8.1 дүгээр зүйлийг “сонгуулийг нэг мандат бүхий тойргоор зохион байгуулж явуулна” гэж өөрчилсөн нь сонгуулийн жижгэрүүлсэн нэг тойрог, нэг мандаттай (FPTP) тогтолцоо юм. Энэ тогтолцоог 1996, 2000, 2004 онд хэрэглэсэн байдаг.
2. Сонгуулийн тухай 2 дахь хуулийг УИХ 2005 оны 12 сарын 29-нд баталсан. Хуулийн 4.2 дугаар зүйлд “УИХ-ын 76 гишүүнийг олон мандаттай тойргоос сонгоно”. 28.1 дүгээр зүйлд нь “Нам, эвсэл нь олон мандаттай тойрогт тухайн тойрогт ногдох мандатын тооноос илүүгүй хүний нэрийг дэвшүүлнэ” гэж заасан. Энэ нь 1992 онд хэрэглэсэнтэй ижил дийлэнх/олонхын тогтолцооны (Block voting) хувилбар бөгөөд Монгол Улс сонгуулийн тогтолцооны шинэтгэлээс ухарсан үйлдэл байсан.
3. Гурав дахь хуулийг УИХ 2011 оны 12 сарын 15-нд баталсан. Хуулийн 4.8 дугаар зүйлд “Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу УИХ-д 76 гишүүнийг сонгоно”, 4.9 дүгээр зүйлд нь “Энэ хуульд заасан нэрийн жагсаалтын эхний 48-аас илүүгүй нэр дэвшигчийг сонгуулийн 26 тойргоос, 28-аас илүүгүй нэр дэвшигчийг улс төрийн намын жагсаалтаас тус тус сонгоно” гэж заажээ. Сонгуулийн энэ тогтолцоо нь дийлэнх/олонхын болон хувь тэнцүүлсэн тогтолцоог зэрэгцүүлэн (Parallel system) хэрэглэсэн анхны бөгөөд сүүлчийн тохиолдол байсан.
4. Дөрөв дэх удаагийн хуулийг 2015 оны 12 сарын 25-нд баталсан. Энэ хууль нь УИХ, Ерөнхийлөгч болон Орон нутгийн сонгуулийг нэг хуулиар зохицуулах оролдлого байсан бөгөөд сонгуулийн тогтолцооны хувьд өмнөх хуультай ижил 48/28 гэсэн холимог тогтолцоог дахин баталсан. Гэвч Үндсэн хуулийн Цэц 2016 оны дөрөвдүгээр сарын 22-ны 05-р тогтоолоор Сонгуулийн хууль Үндсэн хууль зөрчсөн гэж үзсэн тул УИХ уг тогтоолыг 2016 оны тавдугаар сарын 5-нд хэлэлцээд ээлжит сонгуулиас хоёр сарын өмнө хуулийн 7.1 дэх заалтыг “Сонгууль нь олонхын /мажоритар/ тогтолцоотой байна” гэж өөрчилсөн.
5. 5 дахь хуулийн УИХ 2019 оны 12 сарын 20-нд баталсан. Хуулийн 4.3 дугаар зүйлд “УИХ-ын 76 гишүүнийг олон мандаттай тойргоос сонгоно” гэж заасан нь мөн л 1992, 2008 онд хэрэглэсэн дийлэнх/олонхын тогтолцооны олон мандатын том тойргийн (Block voting) хувилбарыг дахин хуульчилжээ.

⁴⁶ А.Бат-Оргил. 2021. Монгол Улсын сонгуулийн тогтолцоо: Харьцуулсан судалгаа, судалгааны тайлангийн төсөл.

буюу дийлэнхийн хэмээн тодорхойлж болох юм. Эдгээр сонгуулиар нэр дэвшигч нь сонгуульд ялахын тулд 50% + 1 санал авч байсан нь мажоритар тогтолцооны гол шинж. Бусад оны сонгуулиудын хувьд сонгуулийн хуулиар аль нэг нэр дэвшигчийг 50% + 1 санал аваагүй байсан ч хоёр дахь шатны санал хураалт явагдахгүй байхаар заасан нь харьцангуй олонхын системд хамаарна.⁴⁷ Сонгуулийн тогтолцооны дээрх ангиллууд дээр судлаач бүр санал нэгддэггүй ба тодорхойлолтууд нь өөр, өөр байх нь бий.

Монголын парламентын сонгуулийн түүхэнд 2012 оны сонгууль нь бусад сонгуулиудаас өөр байсан. Тухайн сонгуульд холимог тогтолцоог ашиглан, УИХ-ын 76 гишүүний 48-ыг 26 томсгосон тойргоос, 28-ыг нь Монгол Улсыг нэг тойрогт тооцож, улс төрийн намын авсан саналтай хувь тэнцүүлэн намын жагсаалтаас сонгосон. Энэ нь нийт суудлын 63 хувийг мажоритар тогтолцоогоор, 37 хувийг нь хувь тэнцүүлсэн намын жагсаалтын тогтолцоогоор хослуулан холимог тогтолцоо байдлаар хэрэгжүүлжээ. 2012 оны сонгуулийн үр дүнгээс үзвэл жижиг намуудын төлөөлөл нэмэгдсэн, зохист харьцаа нь багаас дунд түвшинд (гэвч 2004 болон 2008 оны харьцаанаас өндөр)⁴⁸ хүрсний зэрэгцээ харьцангуй тогтворгүй Засгийн газар бүрджээ. Үүнд тулгуурлан авч үзвэл энэхүү сонгууль нь тэнцвэртэй холимог тогтолцоо бус, харин илүү хувь тэнцүүлсэн тогтолцоотой ижил төстэй үр дүнг гаргажээ. Өөрөөр хэлбэл, хоёр тогтолцооны давуу болон сул талуудыг тэнцвэржүүлээгүй байна.⁴⁹ Бид зөвхөн нэг л удаа ашигласан сонгуулийн тогтолцооны талаар дүгнэлт гаргахдаа болгоомжтой хандах ёстой. Учир нь хангалттай өгөгдөл, мэдээлэл байхгүй тул тухайн сонгуулийн тогтолцооны үзүүлж буй нөлөөллийг тухайн үеийн улс төрийн болон цаг үеийн байдлаас ялган авч үзэх шаардлагатай.

Тухайн үед сонгуулийн холимог тогтолцоог сонгон авсан нэг шалтгаан нь 2008 оны УИХ-ын сонгуулийн үр дүнг зарласны дараах олон нийтийн эсэргүүцэл, үймээн самуунд хүч хэрэглэсэн үйлдэл байв (7 сарын 1-ний явдал хэмээн нэрлэж буй).⁵⁰ 2008 онд байгуулагдсан парламент нь эвслийн эсвэл эв нэгдлийн Засгийн газар байгуулах замаар хагарал, зөрчилдөөнийг шийдэх оролдлого хийсэн байна. МАХН (одоогийн МАН) нь стандарт бус Засгийн газар байгуулж, бүрэлдэхүүнд нь АН-ыг багтаан, улмаар эдгээр хоёр гол улс төрийн нам сонгуулийн холимог тогтолцоог цаашид ашиглах зөвшилцөлд хүрсэн. Ийнхүү өөрчлөлт хийх болсны цаад зорилго нь багц саналын тогтолцоог солих; санал гээгдэхээс сэргийлэх; улс төрийн намуудын төлөвшлийг сайжруулах; сонгуулийг мөнгөний нөлөөллөөс салгах; эмэгтэйчүүдийн оролцоо, төлөөллийг нэмэгдүүлэх байсан хэмээн тухайн үед дурджээ.⁵¹ Бодит байдал дээр энэхүү тогтолцоо нь эмэгтэйчүүдийн төлөөллийг хангах чиглэлд амжилт олж, нийт 11 эмэгтэй УИХ-ын гишүүнээр сонгогдсоны зэрэгцээ гадаадад амьдарч буй Монгол Улсын иргэд анх удаа санал өгсөн байна.

Энэхүү тогтолцоог ганцхан удаа л ашиглаж, 2016 оны сонгуулийн өмнө УИХ нь сонгуулийн тогтолцоог дахин өөрчлөхдөө ямар нэгэн үндэслэлгүйгээр шийдвэр гаргасныг улс төрийн зорилго бүхий шийдвэр хэмээн үзэж болно.⁵² Монгол Улс дахин холимог тогтолцоог ашиглаагүй ба 2016 онд харьцангуй олонхын (FPTP) тогтолцоог, 2020 онд буцаад багц

⁴⁷ Мөн тэнд.

⁴⁸ А.Бат-Оргил. 2021. Монгол Улсын сонгуулийн тогтолцоо: Харьцуулсан судалгаа, судалгааны тайлангийн төсөл, хуудас. 12-13.

⁴⁹ РМаскариник. 2019. "2012 оны Монгол Улсын Сонгуулийн саналын хуудасны хуваалт ба саналаа бодлогоор болон хувийн үзэмжээр өгөх нь" Коммунист, пост-коммунист судлал, 52(3):235-245. ISSN 0967-067X.

⁵⁰ А.Олейник. 2012. "Институтийн гадуурхал нь тогтвортой бус байдлын шалгаан: Монголын 2008 оны 7 сарын 1-ны өдрийн нийтийн үймээн самуун". Төв Азийн Судалгаа 31(2) хуудас 153-174.

⁵¹ РМаскариник. 2019. Эмэгтэйчүүдийн улс төрийн эрхийн гарын авлага. хуудас 209.

⁵² С.Радченко. М.Жаргалсайхан. 2017. Монголын 2016-2017 оны сонгуулийн мөчлөг: Ялсан намын ивээл". Азийн Судалгаа. 57(6). хуудас 1032-1057.

саналын (Block voting) тогтолцоог ашиглажээ. Эдгээр хоёр сонгуулиар МАН үнэмлэхүй ялалт байгуулж зохист харьцаа ихээр алдагдсан.

Энэхүү тогтвортой бус байдал нь олон талаар Монгол Улсын парламентын сонгуулийн шинж чанарыг тодорхойлж байна. Тогтворгүй байдлаас хамаарч таамаглах боломжгүй нөхцөл байдал, уур бухимдлыг улс төрийн намуудад ч, сонгогчдод ч бий болгож байна. Монгол Улсын парламентын сонгуулиас бидний ажиглаж болох өөр нэгэн тодорхой чиг хандлага нь сонгуулийн үр дүнгийн төлөөлөх байдлыг нийтэд нь бууруулж буй явдал юм. Ялангуяа сонгогчдын ирц буурах, зохист харьцаа алдагдах, ялалт байгуулаагүй нэр дэвшигчдийн авсан нийт саналын тоо нь ялалт байгуулан, сонгогдсон гишүүдийн авсан саналын тооноос өндөр байх зэргийг үүнээс харж болно. Дээрх бүгд нь парламентын легитим байдлын хямралд түлхэц болсоор байна. Үүнийг олон нийтийн санал бодлыг тандан судлах олон судалгаанаас жишээ нь, 2022 онд хийгдсэн судалгаагаар оролцогчдын 62 хувь нь УИХ-ын талаар сөрөг болон маш сөрөг сэтгэгдэлтэй, 67 хувь нь улс төрийн намуудын талаар сөрөг болон маш сөрөг сэтгэгдэлтэй байснаас харж болно. Ерөнхийлөгч болон Засгийн газрын хэрэг эрхлэх газрын талаарх сөрөг сэтгэгдэл дээрх үзүүлэлттэй харьцуулахад бага байжээ.⁵³ Энэхүү чиг хандлага болон сонгогчдын ирц буурч буй, зохист харьцаа алдагдаж байгаа тухайд хийсэн илүү дэлгэрэнгүй дүн шинжилгээг цааш шинжлэн үзнэ.

Сонгогчдын ирц: Анхны ардчилсан сонгуулиар (1992 болон 1996 он) 90 гаруй хувьтай байсан ирц сүүлийн гурван сонгуулийн хугацаанд 67-74 хувь болж буурсан тодорхой чиг хандлага харагдаж байна. Доорх Хүснэгт 6-д энэхүү тоог дэлгэрэнгүйгээр харуулсан. Үүнээс бид УИХ-ын сонгуулийн ирц нь орон нутгийн болон Ерөнхийлөгчийн сонгуулийн ирцтэй харьцуулбал өндөр хэдий ч бүхий л гурван төрлийн сонгуулийн тухайд ирц буурсаар байгаа үндсэн чиг хандлагыг ажиглаж болно.⁵⁴

Хүснэгт 6. Сонгогчдын ирц⁵⁵

#	Сонгууль	Сонгуулийн насны иргэдийн тоо	Сонгогчдын нэрсийн жагсаалтад бүртгэлтэй сонгогчдын тоо	Ирц
1.	1992	1,202,704	1,085,129	95.6%
2.	1996	1,218,549	1,147,260	92.1%
3.	2000	1,364,862	1,247,033	82.4%
4.	2004	1,472,372	1,279,516	82.2%
5.	2008	1,607,825	1,542,617	76.46%
6.	2012	1,882,035	1,840,824	67.28%
7.	2016	1,998,823	1,911,047	73.58%
8.	2020		2,003,969	73,6%

Сонгогчдын ирц буурч байгаа шалтгаан нь сонгуулийн тогтолцоо байнга өөрчлөгдсөнөөр тогтолцоонд итгэх сонгогчдын итгэл буурч, сонгуульд оролцох сонирхол багасаж байгаатай холбоотой.⁵⁶ Сонгогчдын ирц олон улсад ч буурч буй нь ажиглагдаж байна.

⁵³ Асуулга судалгааны төв, Бүгд Найрамдахчуудын Олон Улсын Хүрээлэн. "Олон нийтийн санал бодлын тандан судалгаа: Монгол улсын иргэд". 2022 оны 3-4 дүгээр сар [22/12/2022]

⁵⁴ Азийн сан. 2023. Монгол Улсын сонгууль (1992-2021) эмхэтгэл. Бүлэг I

⁵⁵ СЕХ. 2017. УИХ-ын сонгуулийн үр дүн (1992-2016). хуудас.6 https://gec.govmn/uploads/lh_huraliin_songuuli-2022.03.22.pdf [22/12/2022]

⁵⁶ ЭГэрэлт-Од. 2021. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцооны улс төр, эрх зүйн түүхэн шинжилгээ (1992-2020). Судалгааны тайлангийн төсөл. хуудас 126.

АСДҮОУХ-ийн судалгаагаар дэлхий нийтэд 1990-ээд онд 80 хувьтай байсан сонгогчдын ирц 2011-2015 онд 66 хувь болж буурсан нь тогтоогдсон.⁵⁷ Монгол Улс нь ардчилсан тогтолцоонд шилжээд удаагүй ч сонгогчдын оролцоо огцом буурч буй нь ардчиллын эхний жилүүдэд сонгогчид илүү идэвхтэй байж, одоо олон улсын чиг хандлагатай ойролцоо шатанд явж буй хэмээн үзэж болно.

Сонгогчдын бүртгэл, нэрийн жагсаалт болон үүнтэй холбоотой маргаан их гарч байгаа нь сонгогчдын ирц буурахад нөлөөлж буй өөр нэгэн хүчин зүйл юм. Учир нь сонгууль бүрд сонгогчийн нэрийн жагсаалтыг шинээр гаргадаг ба уг жагсаалтаас хуулийн дагуу хасагдсан иргэдийн тоо, гадаадад амьдарч буй иргэдийн тоо ил тод биш байсаар байна.⁵⁸ Гадаадад амьдарч байгаа Монгол иргэд сонгуульд саналаа өгөх боломжгүй хэвээр байна. Эдгээр бүлэг сонгогчид зөвхөн 2012 оны УИХ-ын сонгуульд л санал өгөх боломжтой байсан ба 39 улсаас 2,779 сонгогч санал өгсөн байдаг.⁵⁹ Хүснэгт 6-гаас бид сонгогчдын нэрийн жагсаалтад багтаагүй нийт сонгогчдын хувь хэмжээ нь нэг л тохиолдолд 10 орчим хувиар нэмэгдсэн (2004 онд сонгуулийн насанд хүрсэн иргэдийн 87 хувь нь бүртгэгдсэн)-ийг харж болно. Хөдөө орон нутгаас хот суурин газарт шилжин суурьших иргэдийн хөдөлгөөн ихсэж, иргэдийн бүртгэл шинэчлэгдээгүйгээс бүртгэлийн асуудал үүсэж, цаашлаад сонгуулийн ирцэд нөлөөлж байна. Тэдний олонх нь өөрийн бүртгэлтэй орон нутагт эргэн очиж, санал өгөх боломжгүй байсан, эсвэл өгөхгүй байхаар шийджээ.⁶⁰

Сонгогчдын ирцэд хүн ам зүйн хүчин зүйлс мөн нөлөөлж байна. Монгол Улсын хүн ам дахь 18-40 насны буюу залуусын эзлэх хувь өндөр ч тэдний сонгуулийн оролцоо бага байна.⁶¹ Зориг сангийн Залуу сонгогчдын судалгаанд оролцсон нийт 480 оролцогчоос 227 нь 2016 оны сонгуульд оролцоогүй гэж хариулсан байна. Тэдгээрийн 36 хувь нь саналаа өгөх боломжгүй, завгүй байсан гэж хариулсан бол 31 хувь нь итгэл хүлээхээр нэр дэвшигч байгаагүй, 28 хувь нь хэн ч сонгогдсон ялгаагүй хэмээн хариулжээ.⁶²

Зохист харьцаа болон гээгдсэн саналууд: Монгол Улсын парламентын сонгуульд “санал гээгдэх” (сонгогдоогүй нэр дэвшигчид өгсөн санал), улс төрийн намуудын авсан саналын хувь болон тэдгээрийн парламентад эзлэх суудлын зөрүү (зохист харьцаа) нэмэгдэх хандлага ажиглагдаж байна. Энэ нь мажоритар тогтолцооны улмаас ирээдүйд гарч ирж болох үр дагаврууд юм.

Доорх Зураг 5-д 2012 оноос эхлэн сонгуулийн тогтолцоонд “санал гээгдэх” нь хэрхэн нэмэгдэж ирснийг харуулсан ба ялалт байгуулаагүй нэр дэвшигчдийн авсан нийт саналын тоо нь ялалт байгуулсан нэр дэвшигчдэд өгсөн саналын тооноос илүү гарч эхэлснийг харж болно. 1992 - 2004 онд явагдсан сонгуулийн үр дүнд УИХ нь ялалт байгуулсан нэр дэвшигчид өгсөн нийт саналын 54.79 хувиар байгуулагдаж байжээ.

⁵⁷ А.Солижонов. 2016. АСДҮОУХ, <https://www.idea.int/sites/default/files/publications/voter-turnout-trends-around-the-world.pdf> , [22/12/2022]

⁵⁸ Э.Гэрэлт-Од, 2021. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцооны улс төр, эрх зүйн түүхэн шинжилгээ (1992-2020) судалгааны тайлангийн төсөл, хуудас.12

⁵⁹ СЕХ. 2017. УИХ-ын сонгуулийн үр дүн (1992-2016). <https://gec.gov.mn/> [22/12/2022]


⁶⁰ Ч.Тамир. 2004. Монгол сонгогчийн зан үйл, тодорхой хэв шинж, шилжих хөдөлгөөн тайлан.

⁶¹ ҮСХ. 2016. УИХ-ын сонгуулийн санал хураалтад хийсэн дүн шинжилгээ. <http://1212.mn/> [22/12/2022]

⁶² Зориг сан. 2020. Залуу сонгогчдын судалгаа. хуудас 24-25

Үүнээс хойших дөрвөн сонгуульд ялалт байгуулсан нэр дэвшигчид өгсөн дундаж санал 45.74 хувь хүртэл буурсан байна.⁶³ Энэ нь Монгол Улсад нэг тойрогт хамгийн олон санал авсан нь ялагч болдог мажоритар тогтолцоо ашиглаж, бусад нэр дэвшигчдэд өгсөн санал нь “гээгдэж” буйг харуулж байна. Мөн энэ нь хөдөө, орон нутгаас хот суурин газарт шилжих хөдөлгөөн, хот суурин газруудын хүн амын УИХ дахь төлөөлөл (нэг хүнд ногдох) буурч буйг харуулж байна. Хот суурин газрын тойргийн үнэмлэхүй өндөр санал гэдэг нь хүн ам цөөнтэй тойрогт ялалт байгуулж буй нэр дэвшигчийн авсан санал хот суурин газрын ялагдсан нэр дэвшигчийн саналаас бага байгааг хэлнэ.

Зураг 5. Сонгогчдын санал УИХ-д тусгалаа олсон байдал



Ийнхүү легитим байдал буурч байгаа нь сонгуулийн тогтолцоо дахь зохист харьцаа ихээр алдагдаж байгаатай таарч байна. Энэ нь шинэ үзэгдэл бус боловч сүүлийн хоёр сонгууль дээр (2016 болон 2020) илүү тод ажиглагдаж, анхаарал татаж буй асуудал билээ.

МАН ялалт байгуулсан сонгуулиудын зохист харьцаа өндөр болж байгааг болон хэдийгээр зарим сонгуульд үнэмлэхүй ялалт байгуулсан ч нийт авсан саналын хувь нь 58-аас хэтрэхгүй байгааг Хүснэгт 7-д харуулав. Сүүлийн сонгуулиудад МАН нийт авсан саналын багахан хувиар үнэмлэхүй ялалт байгуулж байжээ (2016 онд 46.5%, 2020 онд 46.6%). Дээрх зохист харьцаа АН олонх болсон сонгуулиудад алдагдаж байсан ч саналын хувь хэмжээ болон суудлын тоо хоорондын зөрүү нь харьцангуй бага байжээ. Бүх сонгуулийн жилийг авч үзвэл МАН авсан саналтай нь харьцуулахад УИХ-д дунджаар 20.36 хувиар илүү суудал авсан бол АН 6.65 хувиар, бусад намууд 14 хувиар бага суудал авчээ. Эдгээр үзүүлэлт нь мажоритар тогтолцоонд жижиг намууд сорилттой тулгарч, сонгогчдын санал ихээр гээгддэг болохыг батлан харуулж байна.


⁶³ Э.Гэрэлт-Од. 2021. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцооны улс төр, эрх зүйн түүхэн шинжилгээ (1992-2020), судалгааны тайлангийн төсөл

Хүснэгт 7. Саналын хувь болон суудлын зөрүүтэй байдал

Сон- гуулийн жил	МАН			АН			Бусад намууд, бие даан нэр дэвшигчид					
	Санал	УИХ дахь суудал	Зөрүү	Санал	УИХ дахь суудал	Зөрүү	Санал	УИХ дахь суудал	Зөрүү			
1992	57.10%	70	92.10%	35	31.10%	5	6.60%	-24.5	11.80%	1	1.30%	-10.5
1996	39.90%	25	32.90%	-7	45.70%	50	65.80%	20.1	14.40%	1	1.30%	-13.1
2000	51.50%	72	94.70%	43.2	24.10%	1	1.30%	-22.8	24.40%	3	3.90%	-20.5
2004	48.80%	36	47.40%	-1.4	44.80%	36	47.40%	2.6	6.40%	4	5.30%	-1.1
2008	43.00%	45	59.20%	16.2	39.20%	28	36.80%	-2.4	17.70%	3	3.90%	-13.8
2012	31.30%	26	34.20%	2.9	35.32%	34	44.70%	9.38	33.37%	15	19.70%	-13.67
2016	46.50%	65	85.50%	39	34.20%	9	11.80%	-22.4	19.30%	2	2.60%	-16.7
2020	46.60%	62	81.60%	35	27.70%	11	14.50%	-13.2	25.65%	3	3.90%	-21.75
Дундаж зөрүү			20.36	Дундаж зөрүү			-6.65	Дундаж зөрүү			-13.89	

Доорх Зураг 6-аас харахад 1992-2020 онд явагдсан УИХ-ын найман удаагийн сонгуулийн дунджаар зохист харьцааны индекс 18.6 хувьтай байжээ. Бусад пост-коммунист оронд энэхүү харьцаа нь дунджаар 5-7 хувийн хооронд хэлбэлздэг.⁶⁴

Зураг 6. Монголын сонгуулийн зохист харьцааны индекс (1992-2020)⁶⁵



Эх сурвалж: Сонгуулийн ерөнхий хороо 2020

Монгол Улс 2000 онд хоёр шатлалт мажоритар тогтолцоог ашигласан ба тус хугацаанд зохист харьцааны индекс нь 32.4 хувьтай байжээ (Зураг 6). 2004 оны сонгуульд мөн дээрх тогтолцоог ашигласан ч зохист харьцааны индекс нь 0.7 хувь болж буурсан нь санал гээгдээгүй болохыг харуулж байна. 2004, 2008 болон 2012 онд зохист харьцааны индекс нь мөн доогуур байжээ. Сонгуулийн тогтолцоо ба улс төрийн намын тогтолцооны харилцан нөлөөлөл нь энэхүү өөрчлөлтийн нэг шалтгаан юм.

⁶⁴ А.Бат-Оргил. 2021. Монгол Улсын сонгуулийн тогтолцоо: Харьцуулсан судалгаа, судалгааны тайлангийн төсөл.

⁶⁵ Мөн тэнд.

2004 болон 2008 он нь эвслийн Засгийн газар байгуулагдсан үе юм. Гэсэн хэдий ч энэ эвслийн үе нь хамтын ажиллагаа, зөвшилцлөөс илүүтэй нам хоорондын хуйвалдаан байсан гэгдэх нь бий.⁶⁶ Эвсэл доторх эрх мэдлийн төвлөрөл нь суудлын хувьд бус, саналын хувьд гуравдагч улс төрийн хүчинд үзүүлэх дэмжлэг буурахад хүргэсэн байж болох юм. Ерөнхийдөө жижиг намууд болон бие даан нэр дэвшигчид нь зохист харьцааг бүрдүүлдэг.

2012 оны сонгуулийг холимог тогтолцоогоор зохион байгуулснаар сонирхолтой үр дүн гарсан. УИХ-ын 76 суудлаас 28-ыг нь хувь тэнцүүлсэн намын жагсаалтаас сонгосон нь зохист харьцааны алдагдал бага байхад нөлөөлжээ.⁶⁷ Тус сонгуулийн тогтолцооны үр дүнд жижиг намын нэр дэвшигч болон бие даагч нийт 15 хүн ялалт байгуулж, парламентад жижиг намын төлөөлөл хангагдсаныг харж болно. Харин бусад долоон сонгуулиар (бүгд мажоритар, харьцангуй олонхын тогтолцоотой) УИХ-д сонгогдсон гуравдагч хүчин болон бие даагчдын дундаж тоо 2.4 байжээ.

УИХ-ын сонгуулийн үр дүнд ажиглагдаж буй чиг хандлага

Ардчилсан Монгол Улсад явагдсан нийт найман удаагийн сонгуулиас МАХН/МАН нийт таван сонгуульд, МАН/АН-ын эвсэл нэг сонгуульд, АН болон АН-тай холбоотой эвсэл гурван сонгуульд ялалт байгуулжээ. Нийт сонгуулийн тэн хагаст нь МАХН/МАН үнэмлэхүй ялалт байгуулсан (1992, 2000, 2016, 2020 онуудад) ба бүхий л тохиолдолд МАН нь УИХ-ын суудлын 80 гаруй хувийг эзэлсэн ч нийт саналын 57.1 хувийг л авч байжээ.

Хүснэгт 8. Улс төрийн намууд болон бие даан нэр дэвшигчдийн УИХ дахь суудлын тоо⁶⁸

#	Сонгуулийн жилүүд	МАН	АН	Бусад намууд	Бие даан нэр дэвшигчид	Нийт
1	1992	70	4	1	1	76
2	1996	25	50		1	76
3	2000	72	1	2	1	76
4	2004	37	35	1	3	76
5	2008	45	28	2	1	76
6	2012	26	34	13	3	76
7	2016	65	9	2	1	76
8	2020	62	11	2	1	76


Харин улс төрийн намуудын авсан саналыг харьцуулан үзвэл энэхүү давамгайлал нь тийм ч том зөрүүн дээр үүсээгүй болох нь харагдаж байна. 2008 оноос хойш сонгогчдын улс төрийн хоёр том хүчинд өгөх нийт саналын хувь буурсан нь бусад намын санал нэмэгдэхэд хүргэсэн. Гэвч ашиглаж буй сонгуулийн тогтолцоо нь (2012 онд холимог тогтолцоог ашигласнаас бусад тохиолдолд) жижиг намуудын УИХ-д суудалтай болох боломжийг хязгаарласаар байна. Энэ нь олонх/дийлэнхийн тогтолцоо хэрхэн хоёр намын системийг бүрдүүлдэг болохыг тайлбарладаг Дювержегийн хуультай бүрэн нийцэж байна.

⁶⁶ С.Радченко. М.Жаргалсайхан. 2017. Монголын 2016-2017 оны сонгуулийн мөчлөг: Ялсан намын ивээл". Азийн судалгаа. 57(6). хуудас 1032-1057.

⁶⁷ А.Бат-Оргил. 2021. Монгол Улсын сонгуулийн тогтолцоо: Харьцуулсан судалгаа, судалгааны тайлангийн төсөл.

⁶⁸ Мөн тэнд.

Зураг 7. УИХ-ын сонгуульд улс төрийн намуудын авсан саналын хувь хэмжээ (1992-2020)



Монголын улс төрийн хоёр том хүчинд өгч буй саналын хувь харьцангуй буурсан нь УИХ-ын сонгуульд АН-аас илүү МАН-ын авах дэмжлэг буурч, гуравдагч хүчин болон бие даан нэр дэвшигчийн авах саналын хувь нэмэгдэхэд хүргэж байна. Гэсэн хэдий ч сонгуулийн тогтолцоо нь энэхүү авсан саналтайгаа дүйцэхүйц суудал авахад ихээхэн саад учруулж байна. Хуваарилагдсан суудлын тухайд авч үзэхэд Монголын сонгогчдын дундах энэхүү динамикийг ялгаж харахад хүндрэлтэй байдаг.

Энэхүү динамик хөдөлгөөнийг олон нийтийн санал бодол илүү тодруулан харуулж болох юм. Сант Марал сангаас гаргасан санал асуулгын дүнгээс харахад 1998 онд нийт оролцогчдын 93.6 хувь нь “хамгийн шилдэг” гэж үзсэн нэг намыг нэрлэж байсан бол 2016 онд зөвхөн 36.9 хувь нь нэг улс төрийн намд “илүү ханддаг” хэмээн хариулж байжээ.⁶⁹

Хүснэгт 9. УИХ-ын эхний 4 сонгууль болон сүүлийн 4 сонгуульд улс төрийн намуудын авсан саналыг харьцуулсан нь

Улс төрийн нам	Авсан саналын дундаж хувь, 1992-2004	Авсан саналын дундаж хувь, 2008-2020	Зөрүү
МАХН/МАН	49.33	41.9	-7.43
АН	36.43	34.1	-2.33
Бусад намууд болон нэр дэвшигчид	14.25	24	+9.75

МАН болон АН нь өөр өөр түүх, бүтэц бүхий улс төрийн намууд ба эдгээр нь парламентын сонгуулийн дүнд нөлөөлж байдаг. МАН нь илүү урт хугацааны түүхтэй бөгөөд улсын хэмжээнд, ялангуяа хот суурин газраас алслагдсан хэсгүүдэд ч өөрийн салбар нэгжийг бий болгож чадсан нам юм. АН нь харьцангуй сүүлд байгуулагдсан ба сонгуулийн тогтолцооноос үүдэн хэд хэдэн улс төрийн намуудын нэгдэл буюу Дювержегийн хуулийг харуулах төгс жишээ юм.⁷⁰ Ялангуяа АН нь нийт 12 намын нэгдэл ба үүнд 1990 оны сонгуулийн дараа Чөлөөт хөдөлмөрийн нам болон Бүгд найрамдах намуудын нэгдлийн үр дүнд бий болсон Нэгдсэн нам багтсан байдаг. 1992 оны сонгуулийн дараа Монголын

⁶⁹ Л.Сумати, Вернер Пролл, Ц.Сэргэлэн, 2018. Сонгогчдын дуу хоолой. Боть II. Хуудас. 46

⁷⁰ Э.Гэрэлт-Од. 2021. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцооны улс төр, эрх зүйн түүхэн шинжилгээ (1992-2020). судалгааны тайлангийн төсөл.

ардчилсан нам, Нэгдсэн нам, Монголын Сэргэн мандалтын нам, Үндэсний дэвшлийн намууд нэгдэж, Үндэсний ардчилсан нам байгуулагдсан. 2000 оны сонгуулийн дараа Монголын Үндэсний Ардчилсан Нам, Монголын социал демократ нам, Монголын Шашинтны нам, Монголын Үндэсний сэргэн мандлын нам, Монголын ардчилсан нам болон Монголын уламжлалын нэгдсэн нам нэгдэн АН-ыг байгуулсан.⁷¹ Эдгээр улс төрийн намын нэгдэл бүр нь томоохон намуудыг системтэйгээр дэмждэг, нэгдэл үүсгэснээр улс төрийн хүчирхэг стратеги бий болдог зэрэг сонгуулийн тогтолцооны бодит байдлаас үүдэлтэй байв. 2012 оны сонгуулийн өмнө хуваагдсан МАХН болон МАН жишээ нь, энэхүү чиг хандлагыг мөн илтгэж байна. Энэхүү хуваагдлаас үүдэн МАН сонгуульд өөрийн түүхэн дэх хамгийн муу үр дүнг үзүүлсэн бөгөөд УИХ-ын сонгуульд тус намыг дэмждэг байсан сонгогчдын итгэл бүрэн хэмжээнд эргэн сэргээгүй байна. Гэвч МАХН нь бие даасан намын хувьд дорвитой хүчээ авч чадалгүй 2020 оны УИХ-ын сонгуулийн дараа МАН-тай эргэн нэгдсэн.

АН болон бусад намын өндөр амжилт гаргасан шалтгаан нь сонгуулийн тогтолцооны шинэчлэлтэй холбогдож байгаа юм. АН-ын хувьд 1996, 2004 болон 2012 оны сонгуулиудад харьцангуй амжилттай оролцсон. Тухайн жилүүдэд сонгуулийг харьцангуй олонхын болон холимог тогтолцоогоор зохион байгуулсан ба АН нь парламентын суудлын олонхыг авахын тулд бусад намтай эвсэл байгуулан оролцож байжээ.⁷²

Мэдээж нэр дэвшигчийн сонголт болон түүний нэр хүнд нь сонгуулийн амжилтад нөлөө үзүүлдэг. Орон нутаг болон үндэсний хэмжээнд нэр хүндээрээ танигдсан олны танил улс төрчид намаасаа гарч бие даан нэр дэвшсэнээр амжилтад хүрсэн жишээнүүд бий.⁷³ Нэр дэвшигчдийн сонголтын үзүүлж буй нөлөөллийн талаарх дүн шинжилгээ сайн хийгдээгүй ба сонгуулийн тогтолцоо тогтмол өөрчлөгддөг нь энэ төрлийн шинжилгээ хийхэд хүндрэл үүсгэж байна.

Сонгуулийн санхүүжилт – байнга нэмэгдэж ирсэн авч хангалттай ил тод бус

Монгол Улсын сонгуульд ихээхэн үүрэг гүйцэтгэж буй өөр нэгэн өсөн нэмэгдэж буй хүчин зүйл нь сонгуулийн зардал нэмэгдэж буй явдал. Жишээ нь, улс төрийн нам, эвслүүд 1992 оны сонгуульд 137 сая, 1996 оны сонгуульд 209 сая, 2000 оны сонгуульд 1.841 сая, 2004 оны сонгуульд 1.558 сая, 2008 оны сонгуульд 7.9 тэрбум, 2012 оны сонгуульд 36.8 тэрбум, 2016 оны сонгуульд 34.4 тэрбум, 2020 оны сонгуульд 67.2 тэрбум төгрөгийг буюу нийт 75.4 тэрбум төгрөгийг зарцуулжээ.⁷⁴


⁷¹ Удо Баркман. 2005. Монголын улс төрийн намууд болон ардчилсан үйл явц: Зүүн Азийн орчин үеийн улс төрийн тухай ойлголт. Ред. Кристиан Шафферер. Нью-Йорк: Нова хэвлэл. 37–63.

⁷² А.Бат-Оргил. 2021. Монгол Улсын сонгуулийн тогтолцоо: Харьцуулсан судалгаа, Судалгааны тайлангийн төсөл.

⁷³ Жишээ болгон Сонгогчдын дуу хоолой судалгаанаас үзнэ үү. Хуудас 47-д 2004 оны сонгуульд бие даан нэр дэвшиж ялалт байгуулсан АН-ын гурван гишүүний жишээг дурдсан.

⁷⁴ Э.Гэрэлт-Од. 2021. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцооны улс төр, эрх зүйн түүхэн шинжилгээ (1992-2020). Судалгааны тайлангийн төсөл.

Зураг 8. Сонгуулийн кампанит ажлын зардал 1992-2020



УИХ-аас 2008 оноос хойш нэг тойрогт зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоохоор оролдож ирсэн ч энэ нь бодит байдал дээр сонгуулийн зардлыг бууруулж чадаагүй байна. Ялангуяа 1992, 2008 болон 2020 онд олон мандаттай жижиг тойргийн тогтолцоо ашигласан үед сонгуулийн зардал их хэмжээгээр өсжээ. Түүнчлэн энэхүү тайлагнасан зардал нь бодит зардлыг бүрэн тусгаагүй хэмээн олон талууд үздэг. Улс төрийн намууд болон нэр дэвшигчдийн санхүүжилт ил тод бус байх тусам сонгуулийн бодит зардлыг тооцон гаргах боломжгүй юм. Түүнчлэн сонгуульд зарцуулсан мөнгө нь сонгуулийн дүнд нөлөөлж буйг ажиглаж болох ба 2020 оны сонгуульд ялалт байгуулсан нэр дэвшигч бусад нэр дэвшигчээс дунджаар 3.6 дахин их мөнгө зарцуулснаас харж болно.⁷⁵ 2012 оноос хойших дээрх гэнэтийн өсөлт нь сонгуулийн зардлыг нээлттэй, ил тод тайлагнах болсон (дутуу тайлагнах магадлал хэвээр байгаа) болон улс төрийн соёл, стратегийн хувьсал, сонгуулийн тогтолцооны төрөл зэргээс шалтгаалсан байж болно. Сонгуулийн тогтолцоо нь сонгуулийн кампанит ажлын зардалд хэрхэн нөлөөлдөг талаар олон янзын онол, ойлголтууд байдаг. Монгол Улсын хувьд хамгийн анхаарал татаж буй нэг зүйл бол нам доторх өрсөлдөөн нь сонгуулийн кампанит ажлын зардлыг ихэсгэхэд нөлөөлж буй явдал юм.⁷⁶ Тиймээс нэр дэвших хүсэлтэй намын гишүүдийн хоорондын өрсөлдөөн нь зарлагыг нэмэгдүүлэхэд түлхэц болж болдог.

Дүгнэлт

Өнгөрөгч 30 жилийн хугацаанд Монгол Улс нь парламентын сонгуулийн тухай хуулиа таван удаа шинэчилж, улмаар тухайн хуулиудад гурван удаа нэмэлт өөрчлөлт оруулаад байна. Эдгээр найман удаагийн өөрчлөлтөөр сонгуулийн дөрвөн өөр тогтолцоог туршин үзэж, өөрчлөлт хийх болгондоо олон хэлбэрийг сонгож иржээ. Үүнээс улбаалан сонгуулийн тогтолцооны тогтворгүй байдалд хүргэж, энэ нь улс төрийн соёл, өрсөлдөөнд нөлөөлж, эдгээрийн зарим нөлөө нь иргэний боловсрол, тогтолцоонд итгэх олон нийтийн итгэлд сөрөг нөлөө үзүүлж иржээ. Түүнчлэн эрх баригч улс төрийн нам нь сонгуулиас хэдхэн сарын өмнө сонгуулийн хуульд өөрчлөлт оруулж, парламент нь дахин сонгогдох боломж эрэлхийлэн дүрэм, журамд өөрчлөлт оруулах болсон нь ашиг сонирхлын зөрчлийг үүсгэж байна.


УИХ-ын сонгуулийн тогтвортой бус орчин нь чиг хандлагад хийх дүн шинжилгээг улам ээдрээт байдалд хөтөлж буйн зэрэгцээ мажоритар/харьцангуй олонхын (FPTP)

⁷⁵ Б.Ану, 2020. УИХ-д сонгогдсон 75 гишүүн бусад нэр дэвшигчээс 3.6 дахин их мөнгийг сонгуульд зарцуулжээ. <https://ikon.mn/n/1zyx> [22/12/2022]

⁷⁶ Ж. Жонсон, 2017. Эрик С. Херрон ба бусад зохиогчдын "Оксфорд их сургуулийн сонгуулийн тогтолцооны гарын авлага"-т багтсан "Сонгуулийн тогтолцоо ба кампанит ажлын санхүүжилт". (Оксфорд академи)

тогтолцооноос өрсөлдөгч улс төрийн намуудын тоонд үзүүлж буй нөлөөллийг харж эхлэх боломжтой. Өрсөлдөөн ихтэй ч парламентын үр ашигтай намуудын индексээс (ENPP) үзвэл сүүлийн сонгуулийн мөчлөг дээр энэхүү утга нь 2-оос доош болж буурсныг доорх Зураг 9-өөс харах боломжтой.⁷⁷ Үүнээс үзэхэд 3-4 улс төрийн нам л суудлын төлөө өрсөлддөг ч сүүлийн чиг хандлагаас харвал зөвхөн нэг нь л олонх болох хандлагатай байна. Хэрэв энэ чиг хандлага хэвээр үргэлжилбэл ялалт байгуулсан намын авч буй саналын хувь хэмжээ нь 50 хувиас дээш гарсан хоёр тохиолдлоос (1992 болон 2000 онд) бусдаар хэвээр үргэлжлэх юм.

Зураг 9. Монгол Улс дахь үр ашигтай намын тоо



ENEP = Сонгуулийн үр ашигтай намын тоо; ENPP = Парламентын үр ашигтай намын тоо. Эх сурвалж: Сонгуулийн ерөнхий хорооны мэдээлэлд үндэслэв (2020)

Санал болон суудлын зохист бус харьцаа, санал гээгдэж буй зэрэг асуудал нь сонгуулийн "легитим" чанар муудах нөхцөл байдалд хөтөлж байна. Энэхүү нөхцөл байдалд хүргэхэд хувь нэмэр оруулсан, Монгол Улсад ашиглаж буй багц саналын тогтолцоог харьцуулан судлахуйц ижил төстэй, ардчилсан орон байхгүй тул энэхүү тогтолцооны хязгаарлалттай талууд нь боломжит үр өгөөжөөс илүү байх боломжтой юм. Сонгогчдын оролцоо буурч, улс төрийн намуудад итгэх олон нийтийн итгэл суларч доод хэмжээндээ хүрч буйн⁷⁸ зэрэгцээ сонгуулийн санхүүжилтээ хэрхэн зарцуулж буй талаарх асуулт ихээхэн тавигдах болжээ.⁷⁹ Эдгээр бүхий л чиг хандлага нь Монгол Улсад тохирох сонгуулийн загвар, тухайн тогтолцооны тогтвортой байдлыг цаашид хэрхэн нэмэгдүүлэх талаар анхааралтай судлан үзэхийг шаардаж буй юм. Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр сонгуулийн хуулийг өөрчлөх цаг хугацаанд хязгаарлалт (сонгууль болохоос нэг жилийн өмнө) тавих хэлбэрээр энэхүү хэрэгцээг хүлээн зөвшөөрсөн ч хангалттай хэмжээнд хяналт болж чадах эсэх нь одоогоор тодорхойгүй байна.⁸⁰

⁷⁷ А.Бат-Оргил. 2021. Монгол Улсын сонгуулийн тогтолцоо: Харьцуулсан судалгаа. Судалгааны тайлангийн төсөл. Хуудас. 10

⁷⁸ Асуулга судалгааны төв, Бүгд Найрамдахчуудын Олон Улсын Хүрээлэн. "Олон нийтийн санал бодлын тандан судалгаа: Монгол Улсын иргэд". 2022 оны 3-4 дүгээр сар [22/12/2022]

⁷⁹ Э. Гэрэлт-Од. 2021. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцооны улс төр, эрх зүйн түүхэн шинжилгээ 1992-2020. Судалгааны тайлангийн төсөл. Хуудас 16.

⁸⁰ 1992 оны Монгол Улсын Үндсэн Хууль. <https://cli.num.edu.mn/content/pdf/research-1.pdf> [22/12/2022] (Заалт 21.4-т 2019 оны 11 сарын 14-нд нэмэлт, өөрчлөлт оруулсан) <https://www.legalinfo.mn/law/details/367> [22/12/2022]

Энэ нь Монгол Улсад шинээр хэлэлцэж эхэлж буй сэдэв бус юм. Монголд хийгдэж болох реформын талаарх олон нийтийн яриа хэлэлцүүлэг, академик судалгаа олон жилийн турш өрнөж байна. Мөн хувь тэнцүүлсэн тогтолцооны зарим элементийг сонгуульд оруулж ирэх талаарх санааг ч олон жил хэлэлцэж байна. 1998 онд тухайн үеийн УИХ-ын дэд дарга Ж.Бямбадорж (МАН) олон нийтэд хандан “Нэг тойрог-нэг мандат” (Харьцангуй олонх) тогтолцоо нь сонгогчдын хүсэл эрмэлзлийг тусгахгүй, улс төрийн намуудын үүрэг ролийг бууруулж буй тул улс даяар нэг тойрог болох хувь тэнцүүлсэн тогтолцоог хэрэглэхийг санал болгож байжээ.⁸¹ 2005 онд УИХ-аас хийсэн судалгаагаар хувь тэнцүүлсэн тогтолцоог илүү тусгасан тогтолцоо нь Монгол Улсад сайн тохирох талаар дүгнэлт гаргаж байжээ.⁸² Хувь тэнцүүлсэн тогтолцооны элементүүдийг түлхүү шингээж өгөх хэмээх энэхүү зөвлөмжийг⁸³ 2005 онд баталсан УИХ-ын сонгуулийн тухай хуульд бодитоор тусгаагүй.⁸⁴ Түүнчлэн 2019 онд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт хийхээс өмнө сонгуулийн тогтолцооны талаар хэлэлцүүлэг хийгдэж, МАН болон АН-ын төлөөлөл холимог тогтолцоог хэрэглэх талаар ярьж байсан ч Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд энэ талаар тусгаагүй ажээ.⁸⁵

Судлаачдын зүгээс ч энэхүү хэлэлцүүлэгт хувь нэмрээ оруулж ирсэн ба жишээ нь, судлаач Н.Цолмонтаяа⁸⁶ тогтоосон тодорхой тойргуудад нэр дэвшигчдийг өрсөлдүүлдэг хувь тэнцүүлсэн тогтолцоог 1999 онд санал болгосон байдаг. 2009 онд профессор Д.Ноолон дүгнэхдээ Монгол Улс нь мажоритар болон хувь тэнцүүлсэн тогтолцоог 50/50 хувь тэнцүүлсэн, хувь тэнцүүлсэн хэсэг дээр 49 хувийн босго бүхий сонгуулийн холимог тогтолцоог ашиглавал илүү өргөн хүрээнд зөвшилцөл бий болж, үр дүнтэй байна хэмээн дүгнэжээ.⁸⁷ Бенжамин Райлли 2010 онд 26/50 загвар буюу сонгогчдын хэрэгцээнд нийцүүлэн газар зүйн байдалд тааруулан нэг аймаг/дүүрэг бүрээс нэг гишүүн сонгож, үлдэх 50 суудлыг хувь тэнцүүлсэн системээр сонгох загварыг зөвлөмж болгосон. Сонгуулийн тогтолцооны талаар сүүлд хийгдэж буй судалгаа ч холимог тогтолцоо зөв хэмээх зөвлөмжийг гаргах болсон ч⁸⁸ энэ нь зөвшилцсөн шийдвэр хэмээн үзэхэд арай эрт байна. Зарим талуудын зүгээс илүү эрс өөрчлөлт хийх, жишээ нь, хувь тэнцүүлсэн тогтолцоонд шилжих, эсвэл алтернатив тогтолцоог ашиглах зэрэг чиглэлээр ч хэлэлцүүлэг хийгдэж байна.⁸⁹

Дээр дурдсан бүх судлаачдын зүгээс улс төрийн намуудын институтийн хөгжил, төлөвшилтийг сайжруулах, сонгогчдын төлөөллийг нэмэгдүүлэх, бүс нутаг/дотоодын нөхцөл байдалд үндэслэн холимог, эсвэл пропорциональ сонгуулийн тогтолцоог ашиглах зэрэг саналууд гаргаж байжээ. Гэвч парламент буюу ерөнхийдөө эрх барьж буй нам нь сонгуулийн ямар тогтолцоо ашиглахыг сонгосоор байна. Одоогийн нөхцөл байдалд зарим эрдэмтдийн санал болгож байгаа холимог тогтолцоо нь сонгуулийн тогтолцооны шинэчлэлийн хувьд улс төрийн шинэ соёл бий болгох, сонгогчийн ирц,

⁸¹ Ж.Бямбадорж. 1998. Сонгох эрх ба сонгуулийн тогтолцооны шинэтгэл. Шинэ толь сэтгүүл №28

⁸² Сонгуулийн мажоритар тогтолцоог сайжруулах нь. Бодлогын зөвлөмж. 2005.

⁸³ НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр, 2005. Монгол Улсад ямар холимог тогтолцоо хамгийн зохистой вэ? Бодлогын зөвлөмж. <https://forum.mn/product/151960> [22/12/2022]

⁸⁴ Э.Гэрэлт-Од. 2021. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцооны улс төр, эрх зүйн түүхэн шинжилгээ 1992-2020. Судалгааны тайлангийн төсөл. Хуудас 18.

⁸⁵ Мөн тэнд.

⁸⁶ Н.Цолмонтаяа. 1999. Сонгуулийн тогтолцоо, тогтолцоог боловсронгуй болгох. Шинэ толь сэтгүүл. №25

⁸⁷ Д.Ноолон. 2009. “Монгол Улсын сонгуулийн тогтолцооны шинэтгэл” Бодлогын баримт бичиг, Фридрих Эбертын сан

⁸⁸ А.Алтанзул. 2021. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцоо: урт хугацааны хөгжлийн бодлого. Судалгааны тайлангийн төсөл

Э.Гэрэлт-Од. 2021. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцооны улс төр, эрх зүйн түүхэн шинжилгээ 1992-2020. Судалгааны тайлангийн төсөл. Хуудас 23.

⁸⁹ А.Бат-Оргил. 2021. Монгол Улсын сонгуулийн тогтолцоо: Харьцуулсан судалгаа. Судалгааны тайлангийн төсөл. хуудас 20.

төлөөллийг нэмэгдүүлэх, санал гээгдлийг бууруулах, улс төр, сонгуулийн санхүүжилтийг бууруулах, улс төрийн намын төлөвшлийг дэмжихүйц үндэсний хэмжээнд зөвшилцөлд хүрсэн шийдэл биш юм.

Түүнчлэн сонгуулийн аль ч тогтолцоог сонгосон ч эмэгтэйчүүдийн төлөөлөлд анхаарал хандуулах хэрэгцээ үүсээд байна. Өнгөрсөн хугацаанд болж өнгөрсөн найман удаагийн парламентын сонгуулийн үр дүнд УИХ-д эмэгтэйчүүдийн төлөөлөл хангалттай хэмжээнд огт бүрдэж байгаагүй, тэр ч байтугай 2011 оны УИХ-ын сонгуулийн тухай хуулиар нэр дэвшигчийн 20-оос доошгүй хувь нь эмэгтэйчүүд байх квот тогтоосон ч эмэгтэйчүүдийн төлөөлөл хангалтгүй байж иржээ. Парламент дахь эмэгтэйчүүдийн оролцоо олон улсын болон Ази тивийн дундажтай харьцуулахад доогуур байна. Сонгуулийн дийлэнхийн тогтолцооны хүрээнд парламент дахь эмэгтэйчүүдийн оролцоог хангах чиглэлээр бүхий л боломжит дэмжлэгийг нэгэнт үзүүлжээ. Тиймээс сонгуулийн тогтолцооны реформ нь цаашид эмэгтэйчүүдийн оролцоог илүү дэмжих боломжтой.

Төгс сонгуулийн тогтолцоо гэж байхгүй, тогтолцоо нэг бүр нь өөрийн гэсэн давуу болон сул талуудтай болохыг бүхий л оролцогч талууд ойлгох шаардлагатай байна. Тиймээс ямар нэгэн шинэтгэлийн үйл ажиллагааны баримтлах зарчмыг Монгол Улс тодорхойлохын тулд үнэт зүйл, тэргүүлэх чиглэл, эдгээрийг сонгуулийн тогтолцооны дизайнд хэрхэн нийцүүлэх талаарх үндэслэл бүхий хэлэлцүүлэг, мэтгэлцээнийг хийх шаардлагатай байна. Холимог тогтолцоо нь аль ч тогтолцооны давуу болон сул талуудын тэнцлийг хангах олон тооны боломжит сонголтыг бий болгох ч тодорхой нөхцөлд тухайн тэнцлийг хэрхэн хангаж, хэрэгжүүлэхийг ойлгох нь тэр бүр хялбар байдаггүй. Олон нийтийн хэлэлцүүлгийн үр дүнд ямар шинэчлэл (эсвэл одоогийн ашиглаж буй багц саналын тогтолцоог үргэлжлүүлэх шийдвэр) тодорхойлон гаргаснаас үл хамааран тогтвортой байдлыг тогтолцоонд нэвтрүүлэх нь суурь ач холбогдолтой байна. Энэхүү судалгааны Бүлэг II-т багтаан, харьцуулсан судалгаанд хамруулсан бусад бүх улсууд нь өөрийн сонгуулийн тогтолцоог 1991 оноос хойш хэвээр нь хадгалж ирсэн бол Монгол Улс нь энэ хугацаанд дөрвөн тогтолцоог ашиглаж, найман удаа өөрчлөлт хийжээ. Ийнхүү ойр ойрхон өөрчилж буй нь сонгуулийн тогтолцоог институтийн хувьд цаашид бэхжүүлэхэд саад тотгор болж, улс төрийн намын төлөвшил, институтийн хөгжилд сөргөөр нөлөөлж иржээ.

БҮЛЭГ IV

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛЬ

Зохиогч:

Марк Кэйниг, Д.Бадамдаш, Э.Гэрэлт-Од, Б.Эрдэнэдалай, Г.Шинэбаяр

Монгол Улс ардчилсан тогтолцоонд шилжиж, 1992 онд шинэ Үндсэн хуулиа батлан гаргаснаас хойш нийт найман удаагийн бүх нийтийн сонгууль зохион байгуулж, Монгол Улсын Ерөнхийлөгчийг сонгожээ. Энэ хугацаанд Ерөнхийлөгчийн эрх, үүрэг нь улс төрийн нөлөөллийн хүрээнд болон албан ёсоор хууль тогтоомжид хийсэн өөрчлөлтүүдийн хүрээнд өөрчлөгдөж ирсэн ба үр дүнд нь Ерөнхийлөгчийн эрх мэдэл шатлан нэмэгдсээр ирсэн гэж олон хүн үздэг.

Ийнхүү Ерөнхийлөгчийн эрх мэдэл өргөжин тэлж буйг Ерөнхий сайд ойр ойрхон солигдож, Ерөнхийлөгч нь илүү тогтвортой байдагтай холбон тайлбарлаж болно. Түүнчлэн Ерөнхийлөгчийн албан тушаалыг хашиж байсан улстөрчдийн нэр хүнд, хувь шинжтэй үүнийг холбон тайлбарлах боломжтой. Ерөнхийлөгчийг шууд сонгуулиар сонгодог тул Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшихийн тулд нам дотроо хүчтэй өрсөлдөх нь түгээмэл бөгөөд намын хамаарал болон нэр дэвшигчийн хувь хүний мэдлэг, чадварын аль аль нь амжилт гаргахад чухал үүрэг гүйцэтгэж иржээ. Энэ нь сонгогдон ажиллаж байсан бүх Ерөнхийлөгч нь олон нийтэд сайн танигдсан, нам дотроо ч удирдан манлайлах байр суурьтай хүмүүс байсныг харуулж байна. 2019 оноос хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр зарим талаар парламентын хүчийг нэмэгдүүлж, Ерөнхий сайдыг дэмжих зорилгоор Ерөнхийлөгчийн эрх мэдлийг хумих оролдлого хийжээ. Энэхүү өөрчлөлт нь цаашид хэр үр дүнтэй хэрэгжихийг хэлэхэд эрт байна.

Ерөнхийлөгчийн үүрэг

Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн анхны төсөлд улс төрийн тогтолцоог сонгодог парламентын системтэй байхаар боловсруулсан. Гэвч Ардын Их Хурал (АИХ)-ын депутатуудын хэлэлцүүлгийн үеэр энэхүү төсөлд өөрчлөлт оруулан Ерөнхийлөгчийг бүх нийтийн шууд сонгуулиар (эхний төсөлд УИХ нь Ерөнхийлөгчийг шууд бус сонгуулиар сонгоно гэж заасан байсан) сонгох болж, Төрийн тэргүүнийх нь хувьд эрх мэдлийг нь нэмэгдүүлжээ. Үндсэн хуулийн эхний төсөлд өөрчлөлт оруулж, улмаар эцэслэн баталсан хувилбараар бий болсон тогтолцоог олон ажиглагчид холимог эсвэл хагас Ерөнхийлөгчийн засаглал бүхий тогтолцоо хэмээн дүгнэхэд хүргэжээ.⁹⁰

⁹⁰Японы улс төр судлаач Юко Касуя өөрийн хийсэн "Ази тивийн улс орнуудын Ерөнхийлөгчдийн харьцуулсан судалгаанд" (粕谷祐子, アジアにおける大統領の比較政治学" 2010) Афганистан, Индонези, Солонгос, Киргизстан, Шри-Ланка, Тайвань, Филиппин, Зүүн Тимор болон Монгол Улсын Ерөнхийлөгчдийн эрх мэдлийг "Үндсэн хуулиар Ерөнхийлөгчид олгогдсон хууль тогтоох эрх" болон "Улс төрийн намаас хамаарах байдал" хэмээх хоёр хэмжүүрийн хүрээнд судалсан ба энэхүү хэмжүүрийг Майнваринг, Шугарт (Mainwaring and Shugart) нар Латин Америкийн улсуудын Ерөнхийлөгчийн тогтолцоонд хийсэн судалгаандаа мөн ашигласан. Энэхүү судалгаагаар судлаач нь Монгол Улсын хагас Ерөнхийлөгчийн тогтолцоотой хэмээн дүгнэсэн.

Ерөнхийлөгчид олгосон эрх мэдлийн ихэнхэд дараах эрх багтсан байна. Үүнд: шууд бүх нийтийн сонгуулиар сонгогдох; хуулийн төсөл санаачлах болон хууль тогтоомжид хориг тавих; улс төрийн нам, эвслүүдтэй зөвлөлдсөний үндсэн дээр Ерөнхий сайдад нэр дэвшигчийг санал болгох; Зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн үүрэг гүйцэтгэх; Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг даргалах; гадаад харилцаанд улсыг төлөөлөх зэрэг эрх олгосон нь Ерөнхийлөгчийн засаглал бүхий улс орнуудтай ижил байна. Монголд хийгдэж буй судалгаа, явагдаж буй яриа хэлэлцүүлгээс үзэхэд Монгол Улсад УИХ нь эрх барих дээд байгууллага болохын хувьд парламентын тогтолцоотой, парламент нь Ерөнхийлөгчид хариуцлага тооцох, УИХ-ын дарга нь Ерөнхийлөгчийн эзгүйд түүний үүргийг гүйцэтгэх эрхтэй байдаг тул Монгол Улс нь парламентын тогтолцоотой хэмээн үзэхэд хүргэж байна.⁹¹

1992 онд шинэ Үндсэн хуулийг батлан гаргаснаас хойш Ерөнхийлөгчийн албан болон албан бус эрх мэдэл нь өргөжин тэлж ирсэн гэдэгтэй бүхий л талууд ерөнхийдөө санал нийлж байна.⁹² Энэхүү Ерөнхийлөгчийн нөлөөлөл тэлэх үйл явц нь Ерөнхийлөгчийн эрх мэдлийг албан бусар нэмж, өргөтгөсөн хуулийн болон улс төрийн соёл, хэм хэмжээний өөрчлөлтийн хүрээнд явагджээ.

Өнгөрсөн жилүүдэд Ерөнхийлөгчийн эрх мэдэлд хийсэн өөрчлөлтүүдийн олонх нь шүүх эрх мэдлийн салбартай хамааралтай байна. 1992-2020 онд Үндсэн хуульд тусгайлан заагаагүй шүүх эрх мэдэлтэй холбоотой олон эрхийг Ерөнхийлөгч эдэлж иржээ. Энэ хугацаанд батлан гаргасан хуулиудын хүрээнд Ерөнхийлөгч нь Ерөнхий шүүгч нарыг (Дээд шүүхийн Ерөнхий шүүгчээс бусад) томилох; шүүгчийг томилох, түдгэлзүүлэх болон чөлөөлөх (1993); Шүүхийн сахилгын хорооны (2012 оноос Ёс зүйн хороо болж өөрчлөгдсөн) дарга болон гишүүдийг томилох (2002); Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, гишүүдийг томилох (2012); мөн Үндсэн хуулийн цэцийн гурван гишүүнийг (нийт 9 гишүүний гурвыг) УИХ-д санал болгон томилуулах зэрэг эрхийг эдэлж иржээ. Түүнчлэн 2019 оноос Ерөнхийлөгч нь Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн санал болгосноор (Ерөнхийлөгч даргалдаг) шүүгч нарыг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, Ерөнхий шүүгч, Авлигатай Тэмцэх Газрын (АТГ) дарга болон дэд дарга, Улсын ерөнхий прокурор, түүний орлогчийг чөлөөлөх эрхтэй болжээ. Ерөнхийлөгчийн эрх мэдлийн энэхүү өргөжилт нь зөвхөн шүүх эрх мэдлийн салбараар хязгаарлагдсангүй.

Үндсэн хуульд заагаагүй өөр олон эрхийг бусад хуулиар Ерөнхийлөгчид олгосон (1993 оны Ерөнхийлөгчийн тухай хуулиас эхлэн) ба үүнд Сонгуулийн ерөнхий хорооны 9 гишүүний 2-ыг нэр дэвшүүлэх, Монголын үндэсний радио телевизийн (МҮОНРТ) Үндэсний зөвлөлийн 15 гишүүний 4-ийг нэр дэвшүүлэх, Хүний эрхийн үндэсний комиссын 3 гишүүний 1-ийг нэр дэвшүүлэх, Төрийн албаны зөвлөлийн даргыг нэр дэвшүүлэн санал болгох, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Нарийн бичгийн дарга болон экспертүүдийг томилох, Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн дарга болон 9 гишүүнийг томилох, АТГ-ын Олон нийтийн зөвлөлийн бүх гишүүдийг томилох зэрэг эрх багтаж байна.⁹³

⁹¹ Ч.Чулуунбаатар 1999, О.Машбат 2015 (Үндсэн хууль: Улс төрийн эрх зүй- хяналт болон тэнцэл) хуудас.141, Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Удирдлагын академи, Судалгааны тайлан “Монгол Улсын эрх зүйн бүтцийг төгөлдөржүүлэх боломж” 2011, хуудас. 54

⁹² О.Мөнхсайхан. 2021. Монгол Улсын Ерөнхийлөгчийн статус, эрх мэдлийн эрх зүйн үнэлгээ (1992-2021) судалгааны тайлан. Г.Шинэбаяр. 2021. Ерөнхийлөгчийн институцын эрх, үүрэг, нөлөөллийг буцаан судлах нь (1990-2020). Судалгааны тайлангийн төсөл

⁹³ О.Мөнхсайхан. 2021. Монгол Улсын Ерөнхийлөгчийн статус, эрх мэдлийн эрх зүйн үнэлгээ (1992-2021) судалгааны тайлан.

Ерөнхийлөгчийн эрх мэдлийг хязгаарлах замаар Монгол Улсын засаглалын тогтолцоон дахь маргааныг шийдэх хүчин чармайлтуудыг 2000 болон 2019 онд Үндсэн хуульд хийсэн нэмэлт, өөрчлөлтөөс ажиглаж болно. Үндсэн хуулийн 2000 оны өөрчлөлт нь Ерөнхийлөгчийн зүгээс Ерөнхий сайд болон Засгийн газрын үйл ажиллагааг хязгаарлах боломж, эрх мэдлийг нь хасах чиглэлээр гаргасан хүчин чармайлтыг тодорхой харуулдаг.⁹⁴

Эдгээр нэмэлт, өөрчлөлтийг 1999 оны намар богино хугацаанд боловсруулж, 1999 оны арванхоёрдугаар сарын сүүлчээр УИХ-ын чуулганд оролцож санал өгсөн 61 гишүүний 58-ынх нь дэмжлэгээр баталжээ. Энэхүү нэмэлт, өөрчлөлтийн гол агуулга нь УИХ-ын гишүүн нь Засгийн газрын гишүүнээр давхар ажиллаж болох (“давхар дээл” хэмээн нэрлэдэг) заалтыг оруулж, Засгийн газрыг бүрдүүлэхэд хамаарах Ерөнхийлөгчийн эрхийг хязгаарлаж, Ерөнхий сайдыг томилоход заавал Ерөнхийлөгчтэй зөвшилцөх шаардлагыг (УИХ-д олонх болсон намаас санал болгосон Ерөнхий сайдад нэр дэвшигчийг ажлын таван өдрийн дотор батална) хязгаарлах зэрэг байжээ. Мөн нэмэлт, өөрчлөлтөөр Ерөнхий сайд нь УИХ-тай зөвшилцсөний үндсэн дээр Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнийг өөрчлөх эрхтэй болж, энэхүү томилгоог УИХ дээр нээлттэй санал хураалтаар хийдэг болгож, УИХ-ын 39 гишүүний ирцийн шаардлагыг бууруулжээ (1990-ээд оны үед кворум/ирцээр боомилох тактикийг байнга хэрэглэж байсны эсрэг). Үүний зорилго нь Засгийн газрыг байгуулах, бүтцийг зөвшилцөхтэй холбоотой парламент болон Ерөнхий сайдын эрх мэдлийг нэмэгдүүлэх, Засгийн газрыг байгуулахад Ерөнхийлөгчийн оролцоог бууруулахад чиглэжээ.⁹⁵

2000 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр Ерөнхийлөгчид төвлөрсөн эрх мэдлийг тэр даруй дорвитой хязгаарлаж, мөн Ерөнхий сайдын тогтворгүй байдлыг шууд багасгаж чадаагүй ажээ. Улмаар 2019 онд Үндсэн хуульд дахин нэмэлт, өөрчлөлт хийсэн ба энэхүү өөрчлөлтөөр мөн л Ерөнхийлөгчид төвлөрсөн эрх мэдлийг хязгаарлаж, парламент болон Ерөнхий сайдын эрх мэдлийн тэнцвэрийг хангахаар зорьжээ.⁹⁶ Уг нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд хийгдсэн тодорхой өөрчлөлтийг дурдвал 33.4 дүгээр зүйлд өөрчлөлт оруулан хуулиар Ерөнхийлөгчид олгож болох эрх мэдлийг тусгасан бөгөөд энэхүү эрх мэдэл нь Ерөнхийлөгчийн эрх, үүргийг 33 дугаар зүйлд тусгасан цар хүрээнээс хэтэрч болохгүйг тусгайлан заасан.⁹⁷ Өмнө нь Ерөнхийлөгчийн албан тушаалд дөрвөн жилээр хоёр удаа сонгогдож болохоор заасан байсан бол дээрх нэмэлт, өөрчлөлтөөр тус албан тушаалд нэг удаа зургаан жилийн хугацаагаар сонгогдож байхаар өөрчилжээ. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд багтсан бусад арга хэмжээ нь шүүх эрх мэдлийн салбарт томилгоо хийх УИХ-ын эрхийг сэргээж, Ерөнхий сайд өөрийн танхимыг хянах эрхийг⁹⁸ бэхжүүлж өгсөн (үүнд “давхар дээл” дээр хязгаарлалт хийж өгсөн ч энэхүү өөрчлөлтийг Үндсэн хуулийн цэц 2022 онд хүчингүй болгосон).⁹⁹ Ерөнхийлөгчид нэр дэвших насны доод хязгаар 45 байсныг 50 болгон нэмэгдүүлсэн.

Эдгээр өөрчлөлтийг хүчин төгөлдөр болгохын тулд олон тооны хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулан, батлах ёстой тул Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хүчин төгөлдөр болсноос хойш Ерөнхийлөгчийн эрх мэдэлд томоохон өөрчлөлт гарч, шилжилт хийгдэж байгаа эсэхийг хэлэхэд эрт байна.

⁹⁴ Л.Мөнх-Эрдэнэ. 2010. Монгол Улсын улс төрийн системийн шилжилт: Хагас парламентын засаглалаас парламентын засаглалд?. Азийн судалгаа. 50. 311-334. 10.1525/as.2010.50.2.311

⁹⁵ Мөн тэнд.

⁹⁶ О.Мөнхсайхан. 2021. Монгол Улсын Ерөнхийлөгчийн статус, эрх мэдлийн эрх зүйн үнэлгээ (1992-2021) судалгааны тайлан. хуудас 24

⁹⁷ Мөн тэнд.

⁹⁸ Д.Зоригт, 2020. Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтүүд: Дүн шинжилгээ, <https://www.gisreportsonline.com/r/mongolia-constitution-amendments/> [22/12/2022]

⁹⁹ Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2022 оны 02 дугаар тогтоол <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16530977997941> [22/12/2022]

Ерөнхийлөгчийн сонгууль - зохион байгуулалт, ирц

1992 оны Үндсэн хуулиар Ерөнхийлөгчийн сонгуульд насанд хүрсэн бүх иргэд шууд санал өгөхөөр заасан. 1993 онд зохион байгуулагдсан анхны сонгуулиас хойш нийт найман удаагийн Ерөнхийлөгчийн сонгуулийг Монгол Улс зохион байгуулаад байна. Сонгууль бүрийн үр дүнд өмнөх Ерөнхийлөгчийн эрх мэдэл шинээр сонгогдсон Ерөнхийлөгчид тайван замаар шилжиж байв. 1992 оноос хойш Ерөнхийлөгчийн сонгуулийн хуульд өөрчлөлт оруулсаар ирсэн ч ихэнх хугацаанд тогтолцоо нь үндсэндээ тогтвортой байж иржээ. 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр Ерөнхийлөгчийг нэг удаа, зургаан жилийн хугацаагаар сонгохоор өөрчилсөн боловч сонгуулийн тогтолцоо болон дүрэмтэй холбоотой өөрчлөлт ороогүй байна.

Сонгууль зарлах, санал хураалтын өдрийг товлох нь хуулиар УИХ-ын хүлээсэн үүрэг байна (Монгол Улсын Үндсэн хуулийн 25.1.3). УИХ-д суудалтай улс төрийн намууд дангаар, эсвэл бусад намтай хамтран эвсэл байгуулах замаар дотроосоо сонгон шалгаруулсан хүнээ Ерөнхийлөгчид нэр дэвшүүлнэ (Монгол Улсын Үндсэн хуулийн 31.2). Анхан шатны сонгуульд Монгол Улсын сонгуулийн насны иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхтэй нууц санал хураалтын зарчмаар оролцоно (Монгол Улсын Үндсэн хуулийн 31.3). Ерөнхийлөгчийн анхан шатны сонгуульд оролцсон нийт сонгогчийн олонхын санал авсан нэр дэвшигчийг УИХ Ерөнхийлөгчөөр сонгогдсонд үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсөн хууль гаргана (Монгол Улсын Үндсэн хуулийн 31.4). Анхан шатны сонгуульд нэр дэвшигчийн аль нь ч олонхын санал аваагүй тохиолдолд анхны санал хураалтад оролцсон нийт сонгогчийн хамгийн олон санал авсан хоёр хүнийг дахин санал хураалтад оруулна. Дахин санал хураалтаар сонгуульд оролцсон нийт сонгогчийн олонхын санал авсан нэр дэвшигчийг УИХ Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсөн хууль гаргана.

Хэрэв хоёр дахь санал хураалтаар Ерөнхийлөгчид нэр дэвшигчдийн хэн нь ч ийнхүү сонгогчдын олонхын санал аваагүй бол дахин сонгууль явуулна. Үндсэн хуулийн 32.1-т заасны дагуу Ерөнхийлөгч нь тангараг өргөн албан тушаалаа хүлээн авах ба хуучин Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа нь шинээр сонгогдсон Ерөнхийлөгч тангараг өргөснөөр дуусгавар болно. УИХ нь Ерөнхийлөгчийг сонгогдсон гэж үзэн бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсөн хууль гаргах, чөлөөлөх, огцруулах эрхтэй байна (Монгол Улсын Үндсэн хуулийн 25.1.5).¹⁰⁰ Ихэнх Ерөнхийлөгч нь дөрвөн жилийн хугацаагаар сонгогдож, дахин нэг удаа сонгогдох эрхтэй байсан бол 2019 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр Ерөнхийлөгч нь нэг удаа, зургаан жилээр сонгогдох болсон.

Ерөнхийлөгчийн сонгууль нь үндсэндээ УИХ-ын сонгуулиас бага ирцтэйгээр явагдаж иржээ (Хүснэгт 10). Монгол Улсад явагдаж буй бүхий л сонгуулиар сонгогчдын ирц буурч буй нийтлэг хандлагыг мөн ажиглаж болно.¹⁰¹ Нэг жилийн хугацаанд дараалан зохион байгуулагддаг гурван төрлийн сонгуулийн сүүлийнх нь болох Ерөнхийлөгчийн сонгуулийн ирцэд ажиглагдаж буй энэхүү ирцийн зөрүүтэй байдлыг сонгогчдын сонгуулиас залхсан байдалтай холбон тайлбарлаж болох юм. Сонгуульд нэр дэвшигчдийн өрсөлдөөний талаарх иргэдийн бодол, нэр дэвшигчдийн нэр хүнд, тэдний идэвх сонгуулийн ирцэд нөлөөлөхийн зэрэгцээ гуравдагч хүчнийг дэмжигчдийн оролцоо сонгуулийн ирцэд голлох нөлөө үзүүлж байна.

¹⁰⁰ О.Мөнхсайхан. 2021. Монгол Улсын Ерөнхийлөгчийн статус, эрх мэдлийн эрх зүйн үнэлгээ (1992-2021) судалгааны тайлан. хуудас. 16-17

¹⁰¹ Б.Эрдэнэдалай. 2021. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн дүнд хийсэн шинжилгээ. Судалгааны тайлангийн төсөл.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны сонгууль бусад онуудаас хамгийн бага буюу 59 хувийн ирцтэй байв. Тухайн сонгуулийн хувьд онцгой нөхцөл байдлаас үүдэлтэйгээр ирц буурсан. Тухайлбал, “Ковид-19” цар тахал, харьцангуй өрсөлдөөн багатай сонгууль болон олон хуваагдаж хагаралдсан сөрөг хүчин зэргээс үүдсэн байна.

Хүснэгт 10. УИХ-ын болон Ерөнхийлөгчийн сонгуулийн сонгогчдын ирцийн харьцуулалт

Он	1992/93	1996/7	2000/01	2004/5	2008/9	2012/13	2016/17	2020/21	Дундаж
УИХ-ын сонгуулийн ирц	95.6%	92.1%	82.4%	81.8%	76.5%	67.3%	73.7%	73.7%	80.39%
Ерөнхийлөгчийн сонгуулийн ирц	92.7%	85.1%	82.9%	75%	73.6%	66.5%	68.3% (эхний шатны санал хураалт)	59%	75.39%
Зөрүү	-2.9%	-7%	-0.5%	-6.8%	-2.9%	-0.8%	-5.4%	-14.7%	-5%

Сонгогчдын ирц аймгуудын хооронд огцом ялгаатай байдаггүй. 2000-2017 онд явагдсан сонгуулиудад хийсэн шинжилгээгээр 22 аймгийн 20-д нь сонгогчдын дундаж ирц 68-73 хувьтай байжээ. Энэ хугацаанд хамгийн өндөр ирцтэй нь Дундговь аймаг (нийт сонгогчдын 73.3 хувь нь оролцон санал өгсөн), хамгийн бага ирцтэй нь Дорноговь аймаг бөгөөд 67.1 хувийн ирцтэй байв.¹⁰² Сонгогчдын ирц хамгийн өндөр таван аймгийг хамгийн бага өрсөлдөөнтэй (Дундговь, Өвөрхангай, Говь-Алтай, Булган зэрэг аймаг нь МАН/МАХН-ыг найдвартай дэмждэг) болон өрсөлдөөн ихтэй (Улаанбаатар) аймаг/нийслэлтэй харьцуулж харж болно.

Хүснэгт 11. Сонгогчдын ирцийг аймгуудаар эрэмбэлсэн байдал (2000-2017)

Аймгууд	Сонгогчдын ирц	Байр	Аймгууд	Сонгогчдын ирц	Байр
Дундговь	73.3%	1	Говьсүмбэр	70.2%	12
Өвөрхангай	72.8%	2	Дорнод	70.0%	13
Говь-Алтай	72.6%	3	Баян-Өлгий	69.8%	14
Улаанбаатар	72.4%	4	Архангай	69.8%	15
Булган	72.0%	5	Орхон	69.7%	16
Баянхонгор	72.0%	6	Завхан	69.6%	17
Ховд	71.5%	7	Төв	69.3%	18
Сүхбаатар	71.4%	8	Дархан-Уул	69.3%	19
Өмнөговь	71.1%	9	Хэнтий	68.9%	20
Сэлэнгэ	71.1%	10	Увс	68.8%	21
Хөвсгөл	70.2%	11	Дорноговь	67.1%	22
Нийт	71.2% (Дундаж 70.1%)				

Ерөнхийлөгчийн сонгууль – нэр дэвшигчид

Монгол Улсад зохион байгуулагдсан нийт найман удаагийн Ерөнхийлөгчийн сонгуулийг эргэн харвал аль ч сонгуульд улс төрийн хоёр гол том нам болох МАН/МАХН болон АН-ын нэр дэвшигчид ялалт байгуулсаар иржээ. Сонгогдсон бүх нэр дэвшигч нь эрэгтэй байсан ба нийт 23 нэр дэвшигчийн дунд нэг л эмэгтэй нэр дэвшигч Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдсөн байна. Хуулийн дагуу зөвхөн УИХ-д суудалтай улс төрийн намууд л Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшүүлэх эрхтэй тул өмнөх бүхий л сонгуульд нэр дэвшигчдийн тоо хязгаарлагдмал байж иржээ. Нийт найман удаагийн сонгуулийн хоёрт нь хоёр нэр дэвшигч, тавд нь гурван нэр дэвшигч, 2005 оны сонгуульд дөрвөн нэр дэвшигч тус тус өрсөлджээ.¹⁰³

Монгол Улсын Ерөнхийлөгч нарын нас харьцангуй залуу, нэр хүнд өндөртэй байсан нь үе үеийн Ерөнхийлөгч нар улс төрийн нөлөө, олон нийтийн дэмжлэг хамгийн өндөртэй улстөрчид байсныг харуулж байна. Сант Марал Сангийн зүгээс хамгийн сүүлд хийсэн “Хамгийн өндөр рейтинг бүхий улс төрчийн судалгаа”-наас харвал Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөж, амжилт гаргаж байсан нэр дэвшигчид нь сонгуульд оролцох үедээ олон нийтэд хамгийн сайн танигдсан, рейтинг өндөртэй улстөрчид байжээ.¹⁰⁴ Хүснэгт 12-т харуулсанчлан 1996-2016 онд Ерөнхийлөгчөөр сонгогдсон бүх нэр дэвшигч нь иргэдэд хамгийн танигдсан топ-3 улстөрчийн тоонд сонгуулийн өмнөх жилд багтаж байжээ. Хүснэгт 13-аас харахад сонгуулийн жилд Монгол Улсын Ерөнхийлөгчийн дундаж нас нь 49.8 байжээ.¹⁰⁵ Үүнээс үзэхэд Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдон ажиллаж байсан хүмүүс нь Монголын улс төрд танигдсан, Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөх үедээ өөрийн карьерын оргилдоо хүрсэн улстөрчид байсан нь батлагдаж байна. Энэхүү ажиглалт болон Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшихийн төлөөх нам доторх хүчтэй өрсөлдөөн¹⁰⁶ зэргээс харахад тухайн албан тушаал нь ихээхэн өрсөлдөөн бүхий, өндөр албан тушаал болох нь ойлгомжтой байна. Энэ нь Монгол Улсын Ерөнхийлөгч нь хуулиар олгосон албан ёсны эрх мэдлээсээ гадна томоохон нөлөөтэй албан тушаалтан болохыг харуулж байна.

Хүснэгт 12. Ерөнхийлөгчийн сонгуульд ялалт байгуулсан нэр дэвшигчдийн улс төрийн нөлөөлөл¹⁰⁷

	1996	1997	2000	2001	2004	2005	2008	2009	2012	2013	2016
Багабанди	3-р байр 21.9%	1-р байр 40.2%	2-р байр 23.4%	1-р байр 41.9%	31%	15.1%	8%	11.4%	6.7%	8.9%	4.2%
Энхбаяр	0.4%	4.5%	22.2%	29.3%	1-р байр 54%	1-р байр 54.3%	4-р байр 13.2%	3-р байр 27.8%	18.2%	18.3%	21.2%
Элбэгдорж	27.5%	13.1%	4.1%	3.6%	18.1%	31.4%	2-р байр 20.9%	1-р байр 39.5%	3-р байр 15%	2-р байр 20.9%	7.3%
Баттулга	0.9%	1.6%	0.2%	0.1%	0.1%	0.1%	1.6%	0.4%	6.5%	3.6%	3-р байр 11.4%

¹⁰³ Э.Гэрэлт-Од. 2021. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль болон улс төрийн намуудын өрсөлдөөн. Судалгааны тайлангийн төсөл.

¹⁰⁴ Л.Сумати, Вернер Пролл, Ц.Сэргэлэн, 2018. Сонгогчдын дуу хоолой. Боть II. хуудас. 424-428

¹⁰⁵ 2019 онд Үндсэн хуульд хийсэн өөрчлөлтөөр Ерөнхийлөгчид нэр дэвшигчийн насны хязгаарын 50 насаар тогтоосон ба энэ нь цаашид нэмэгдэнэ.

¹⁰⁶ Э.Гэрэлт-Од. 2021. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль болон улс төрийн намуудын өрсөлдөөн. Судалгааны тайлангийн төсөл

¹⁰⁷ Л.Сумати, Вернер Пролл, Ц.Сэргэлэн, 2018. Сонгогчдын дуу хоолой. Боть II. хуудас. 424-428.

Хүснэгт 13. Ерөнхийлөгч нарын нас

№	Ерөнхийлөгч	Төрсөн он	Сонгогдсон		Хүйс
			Он	Нас	
1	П.Очирбат	1942	1993	51	Эрэгтэй
2	Н.Багабанди	1950	1997	47	Эрэгтэй
3		1950	2001	51	Эрэгтэй
4	Н.Энхбаяр	1958	2005	47	Эрэгтэй
5	Ц.Элбэгдорж	1963	2009	46	Эрэгтэй
6		1963	2013	50	Эрэгтэй
7	Х.Баттулга	1963	2017	54	Эрэгтэй
8	У.Хүрэлсүх	1968	2021	53	Эрэгтэй
	Дундаж нас			49.8	

Ерөнхийлөгчийн сонгууль - үр дүн

Монгол Улсад явагдсан нийт найман удаагийн Ерөнхийлөгчийн сонгуулийн хугацаанд (бүгдэд нь МАН/МАХН болон АН/АН-ын оролцоотой эвсэл ялалт байгуулсан) ялалт байгуулсан саналын дундаж хувь нь 56.24, хоёрдугаарт орсон өрсөлдөгчөөс илүү авсан саналын дундаж зөрүү нь 21.87 хувь байжээ.¹⁰⁸ Сонгуулийн нийт үр дүнгээс үзвэл тухайн үед Ерөнхийлөгчийн албан тушаал хашиж байсан нь дахин нэр дэвшихэд тодорхой давуу тал болоогүй нь харагдана. Нийт дөрвөн сонгуульд л тухайн үеийн Ерөнхийлөгч нар дахин нэр дэвшин өрсөлдсөнөөс хоёр нь л сонгогдож чаджээ. Эдгээр тохиолдолд амжилттай дахин сонгогдсон нэр дэвшигчдэд албан тушаал нь тодорхой давуу, эсвэл сул тал төдийлөн үүсгээгүй,¹⁰⁹ харин дахин сонгогдож чадаагүй хоёр нэр дэвшигч нь тухайн сонгуулийн өмнөх жилд намын эв нэгдэлтэй холбоотой асуудалтай нүүр тулж байжээ.¹¹⁰ 2019 онд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт хийснээр Ерөнхийлөгчөөр дахин сонгогдох боломжгүй болсон.¹¹¹

Хүснэгт 14. Ерөнхийлөгчийн сонгуулийн үр дүнгийн тойм¹¹²

Он	Ялагч	Нам	Нийт нэр дэвшигчийн тоо	Тухайн үед Ерөнхийлөгч байсан, эсэх	Ялагчийн эзлэх саналын хувь	Ялалт байгуулсан (хоёрдугаарт орсон нэр дэвшигчтэй харьцуулсан)
1993	П.Очирбат	МУАН, МСДН	2	Үгүй	57.78%	+19.08%
1997	Н.Багабанди	МАХН	3	П.Очирбат	60.81%	+32%
2001	Н.Багабанди	МАХН	3	Н.Багабанди	58.13%	+21.6%
2005	Н.Энхбаяр	МАХН	4	Үгүй	53.44%	+33.39%
2009	Ц.Элбэгдорж	АН	2	Н.Энхбаяр	51.21%	+3.8%
2013	Ц.Элбэгдорж	АН	3	Ц.Элбэгдорж	50.23%	+8.26%
2017	Х.Баттулга	АН	3	Үгүй	38.11% (Шат 1) 50.61% (Шат 2)	+7.79% (Шат 1) +9.45% (Шат 2)
2021	У.Хүрэлсүх	МАН	3	Үгүй	67.69%	+47.38

¹⁰⁸ Эдгээр тоог 2017 оны сонгуулийн хоёр дахь шатны санал хураалтын дүнг ашиглан тооцсон

¹⁰⁹ Хавсралт IV дээрээс дэлгэрэнгүй мэдээллийг харж болно.

¹¹⁰ ЭГэрэлт-Од, 2021, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль болон улс төрийн намуудын өрсөлдөөн. Судалгааны тайлангийн төсөл

¹¹¹ 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт 30.2 дахь заалт. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=103596&showType=1> [22/12/2022]

¹¹² Хавсралт IV дээрээс дэлгэрэнгүй үр дүнг харж болно.

Намын харьяалал, эв нэгдэл болон нэр дэвшигчийн чадавх чансааны ач холбогдол

Монгол Улсад явагдсан Ерөнхийлөгчийн сонгуулиудад улс төрийн хоёр гол хүчин болох МАН/ МАХН болон АН, мөн тэдэнд хамаарах эвслүүд давамгайлсаар иржээ. МАН болон АН тус бүр дөрвөн удаагийн Ерөнхийлөгчийн сонгуульд ялалт байгуулаад байна. Өнгөц харахад эдгээр хоёр намын дунд Ерөнхийлөгчийн суудлын төлөө хүчтэй өрсөлдөөн өрнөдөг мэт харагдах боловч бодит байдал дээр АН нь УИХ-ын сонгуулиас илүү Ерөнхийлөгчийн сонгуулиар амжилт гаргажээ. Гэвч өгөгдөлд нарийн шинжилгээ хийж үзвэл МАН/МАХН нь хавьгүй илүү давуу байдалтай байна. Профессор Б.Эрдэнэдалай хийсэн судалгаандаа хамгийн бага квадратын аргыг ашиглан МАН/МАХН-ын нэр дэвшигч бусад нэр дэвшигчээс 17.4 хувиар өндөр санал авах магадлалтайг тооцон гаргажээ.¹¹³

Энэхүү дүгнэлтийг нотлох хэд хэдэн өгөгдөл байна. Нэгдүгээрт, АН-ын нэр дэвшигчид ялалт байгуулахдаа дунджаар 52.46 хувийн саналаар ялалт байгуулсан бөгөөд ялалт байгуулсан саналын зөрүү нь дунджаар 10.15 хувь байна. МАХН/МАН-ын нэр дэвшигчдийн нийт саналын тоогоор ялалт байгуулсан дундаж хувь нь өндөр буюу 60.02, ялалт байгуулсан зөрүү нь 33.59 хувь байна.¹¹⁴ МАХН/МАН-ын ялагдсан сонгуулиудад хүртэл дээрх давуу тал мөн ажиглагдаж байна. Сонгуульд ялагдах үедээ МАХН/МАН-ын нэр дэвшигчид нийт саналын 42.31 хувийг авч байсан бол АН-ын нэр дэвшигч нь саналын дөнгөж 22.84 хувийг авч байжээ. Энэ нь МАХН/МАН-ын гишүүнчлэл их байгаатай холбоотой юм.

Мөн өрсөлдөөнийг газар зүйн тархцаар нь харахад МАХН/МАН-ын давуу тал тодорхой байна. Хүснэгт 15-д АН-ын ялалт байгуулж байгаагүй 6, зөвхөн нэг удаа ялалт байгуулсан 5, хоёр удаа ялалт байгуулсан 8, гурван удаа ялалт байгуулсан 4 болон 4 удаа ялалт байгуулсан 7 аймаг/дүүргийг (өнөөг хүртэл зохион байгуулагдсан найман Ерөнхийлөгчийн сонгуулийн дөрөвт нь) харуулсан. Дээр дурдсан 4 сонгуулийн хувьд ялалт байгуулсан 7 аймаг/дүүргээс 6 нь нийслэл Улаанбаатар хотын дүүрэг (нөгөө нь Архангай аймаг) байна. Мэдээж Ерөнхийлөгчийн сонгуульд улс даяар сонгогчид санал өгч оролцдог тул хэдэн байршилд ялалт байгуулсан нь чухал бус харин аль нэг байрлалд хэдэн санал авсан нь илүү чухал байдаг.

Гэвч МАХН/МАН нь газар зүйн тархалтаас хамаарч стратегиэ тодорхойлж хамгийн өрсөлдөөнтэй аймгуудад илүү төсөв зарцуулах, хүчин чармайлт гаргах боломжтой болж байна. Хүснэгт 15-д тусгаснаар хот суурин газарт (Улаанбаатарт болон Дархан хотод) АН ялалт байгуулах магадлал өндөртэйг харж болохоор байна.

¹¹³ Б.Эрдэнэдалай, 2021, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн дүнд хийсэн шинжилгээ. Судалгааны тайлангийн төсөл. хуудас 15.

¹¹⁴ Зурагт зөвхөн 2017 оны хоёр дахь шатны санал хураалтын мэдээллийг харуулсан.

Хүснэгт 15. Ерөнхийлөгчийн сонгуульд ялалт байгуулсан нам, аймаг/дүүргээр

	Аймаг/дүүрэг	1993	1997	2001	2005	2009	2013	2017	2021
АЙМАГ	Архангай	АН	МАХН	АН	МАХН	АН	АН	МАХН	МАН
	Баян-Өлгий	МАХН	МАХН	МАХН	МАХН	МАХН	АН	МАН	МАН
	Баянхонгор	МАХН	МАХН	МАХН	МАХН	МАХН	АН	АН	МАН
	Булган	МАХН	МАХН	МАХН	МАХН	МАХН	МАН	МАХН	МАН
	Говь-Алтай	АН	МАХН	МАХН	МАХН	МАХН	МАН	МАН	МАН
	Говьсүмбэр	МАХН	МАХН	МАХН	МАХН	МАХН	МАН	МАХН	МАН
	Дархан-Уул	АН	МАХН	МАХН	МАХН	АН	АН	МАХН	МАН
	Дорноговь	АН	МАХН	МАХН	МАХН	МАХН	МАН	МАХН	МАН
	Дорнод	МАХН	МАХН	МАХН	МАХН	АН	АН	МАХН	МАН
	Дундговь	МАХН	МАХН	МАХН	МАХН	МАХН	МАН	МАХН	МАН
	Завхан	МАХН	МАХН	МАХН	МАХН	АН	АН	МАН	МАН
	Орхон	АН	МАХН	МАХН	МАХН	АН	АН	МАХН	МАН
	Өвөрхангай	МАХН	МАХН	МАХН	МАХН	МАХН	АН	МАН	МАН
	Өмнөговь	МАХН	МАХН	МАХН	МАХН	МАХН	АН	МАХН	МАН
	Сүхбаатар	МАХН	МАХН	МАХН	МАХН	МАХН	МАН	МАН	МАН
	Сэлэнгэ	МАХН	МАХН	МАХН	МАХН	АН	АН	МАН	МАН
	Төв	МАХН	МАХН	МАХН	МАХН	МАХН	МАН	МАН	МАН
	Увс	АН	МАХН	МАХН	МАХН	МАХН	АН	МАН	МАН
	Ховд	АН	МАХН	МАХН	МАХН	АН	АН	МАН	МАН
	Хөвсгөл	МАХН	МАХН	МАХН	МАХН	АН	АН	МАН	МАН
Хэнтий	МАХН	МАХН	МАХН	МАХН	МАХН	МАН	МАХН	МАН	
ДҮҮРГЭГ	Баянзүрх	АН	МАХН	МАХН	МАХН	АН	АН	АН	МАН
	Хан-Уул	АН	МАХН	МАХН	МАХН	АН	АН	АН	МАН
	Сүхбаатар	АН	МАХН	МАХН	МАХН	АН	АН	АН	МАН
	Сонгинохайрхан	АН	МАХН	МАХН	МАХН	АН	АН	АН	МАН
	Чингэлтэй	АН	МАХН	МАХН	МАХН	АН	АН	АН	МАН
	Баянгол	АН	МАХН	МАХН	МАХН	АН	АН	АН	МАН
	Налайх	АН	МАХН	МАХН	МАХН	МАХН	АН	МАХН	МАН
	Багануур	АН	МАХН	МАХН	МАХН	АН	МАН	АН	МАН
	Багахангай	АН	МАХН	МАХН	МАХН	АН	МАН	МАН	МАН

Улс төрийн намын эв нэгдэлтэй байдал нь сонгуульд ялалт байгуулах, эсэхийг тодорхойлох үзүүлэлтүүдийн нэг байсаар иржээ. АН-ын хувьд хагарсан үедээ (1997 болон 2021 он) улс төрийн хувьд хамгийн муу цаг үе байсан бол 2009-2017 онд МАН болон МАХН-ын хуваагдал нь АН сонгуульд ялахад нөлөөлсөн нь тодорхой байна. 2009 оны сонгуульд МАН болон МАХН нь нэг нам байх үедээ орсон ч тухайн үеийн Ерөнхийлөгч байсан Н.Энхбаяр 2009 оны сонгуулийн өмнө намаас дэмжлэг аваагүйгээ олон нийтэд зарлаж, улмаар энэ нь хоёр нам хуваагдахад хүргэсэн.¹¹⁵

¹¹⁵ Э.Гэрэлт-Од, 2021, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль болон улс төрийн намуудын өрсөлдөөн. Судалгааны тайлангийн төсөл. хуудас 11-12..

УИХ-ын сонгуулийн үр дүнд (Ерөнхийлөгчийн сонгуулиас нэг жилийн өмнө явагддаг) аль нэг нам олонх болсны дараа буюу УИХ-д цөөнх болсон намд нь Монгол Улсын сонгогчид Ерөнхийлөгчийн сонгуулиар түлхүү санал өгөх замаар улс төрийн тэнцвэрийг хангадаг эсэх дээр олон төрлийн маргаан, хэлэлцүүлэг өрнөсөөр байна. Ерөнхийлөгч болон УИХ гэсэн засаглалын хоёр салбарыг нэг нам дангаар эзэлж байсан нийт хугацаатай (15.5 жил) харьцуулбал Монгол Улсын Ерөнхийлөгч болон УИХ нь өөр өөр намуудад хамаарах хугацаа нь (14 жил) богино байсан хэмээн үзэх ба үүнийг доорх хүснэгт 16-д харуулав.

Хүснэгт 16. Ерөнхийлөгч болон УИХ-ын суудал дахь олонх болсон намуудын хугацаа (29.5 жил)

УИХ болон Ерөнхийлөгчид хамаарах улс төрийн нам	Нийт жил	
АН-ын Ерөнхийлөгч болон УИХ (Ардчилсан холбоо эвсэл, эсвэл АН-МАХН-ын Шударга ёс эвсэл зэрэг АН-ын тэргүүлсэн эвсэл 1996 оны 6-р сараас 2000 оны 6 сар хүртэл)	5	Нэгтгээд 15.5 жил
МАН/МАХН-ын Ерөнхийлөгч болон МАН/МАХН-ын олонх бүхий УИХ	10.5	
МАН/МАХН-ын Ерөнхийлөгч болон АН-ын олонх болсон УИХ	3	Хуваан тооцсоноор 14 жил
АН-ын Ерөнхийлөгч болон МАН/МАХН-ын олонх болсон УИХ	11	
	29.5	

**Тайлбар: 2004 оны УИХ-ын сонгуулиар МАН/МАХН 37 суудал, АН 35 суудал авч эвслийн Засгийн газар байгуулсан. Үүнийг МАН/МАХН-ын Ерөнхийлөгч болон МАН/МАХН-ын олонх бүхий УИХ гэсэн ангилалд оруулав.*

Ерөнхийлөгчийн болон УИХ-ын сонгуульд санал авсан хувийг судлан үзвэл сонгогчдын зүгээс Ерөнхийлөгчийн сонгуульд санал өгөхдөө УИХ-ын сонгуульд ялсан намыг дэмжих нь бага гэсэн хандлага тодорхой харагдахгүй байна.

Бодит байдал дээр нийт найман удаагийн Ерөнхийлөгчийн сонгуулийн гуравт нь л УИХ-д олонх болсон намд өгсөн сонгогчдын санал буурсан байна (1993, 1997 болон 2016 оны сонгуульд). Хүснэгт 17-гоос үүнийг харж болох ба УИХ-ын болон Ерөнхийлөгчийн сонгуульд санал ихээхэн хуваагдах нь гуравдагч намуудад өгсөн саналтай холбоотой байна. Ерөнхийдөө гуравдагч улс төрийн хүчний хувьд Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр тэдэнд ирэх дэмжлэг ихээр буурдаг бөгөөд энэхүү хандлагыг найман сонгуулийн зургаагаас нь харж болно. Үүний шалтгаан нь сонгууль болгонд харилцан адилгүй ч доорх нийтлэг шалтгаанууд байж болох юм. Үүнд: сонгуульд томоохон намуудтай эвсэл байгуулан оролцсоноор өрсөлдсөн гуравдагч хүчний хувьд нэр дэвшигч дэвшүүлэх боломж гардаггүй (зөвхөн УИХ-д суудалтай нам л нэр дэвшүүлэх боломжтой), зарим сонгогчийн зүгээс гуравдагч хүчин Монголд хэзээ ч амжилт олохгүй хэмээн үзэж томоохон намуудын нэр дэвшигчийг сонгодог зэрэг олон шалтгаан багтаж болно. Энэ байдлаар улс төрийн эвсэл байгуулах, гуравдагч хүчний дэмжлэгийг татахын төлөө өрсөлдөх нь улс төрийн хоёр том намын хувьд Ерөнхийлөгчийн сонгуульд ялалт байгуулах гол хүчин зүйл болж байна.

Хүснэгт 17. УИХ-ын болон Ерөнхийлөгчийн сонгуульд намуудын авсан санал,
улс төрийн нам тус бүрээр

Он	Нам	УИХ	Ерөнхийлөгч	Зөрүү
1992/1993	МАХН/МАН	57.1	38.7	-18.4
	АН	31.1	57.78	26.68
	Бусад	11.8	0	-11.8
1996/1997	МАХН/МАН	45.7	60.81	15.11
	АН	39.9	29.81	-10.09
	Бусад	14.4	6.64	-7.76
2000/2001	МАХН/МАН	51.5	58.13	6.63
	АН	24.1	36.65	12.55
	Бусад	241.4	3.54	-21.06
2004/2005	МАХН/МАН	48.8	53.44	4.64
	АН	44.8	20.05	-24.75
	Бусад	6.4	25.16	18.76
2008/2009	МАХН/МАН	43	47.41	4.41
	АН	39.2	51.21	12.01
	Бусад	17.7	0	-17.7
2012/2013	МАХН/МАН	31.3	42.52	11.22
	АН	35.32	50.89	15.57
	Бусад	33.37	5.58	-27.79
2016/2017	МАХН/МАН	46.5	30.32	-16.18
	АН	34.2	38.11	3.91
	Бусад	19.3	30.19	10.89
2020/2011	МАХН/МАН	46.6	67.69	21.09
	АН	27.7	5.99	-21.71
	Бусад	25.6	20.31	-5.29

Тэгэхээр намын бодлого, улс төрийн үйл ажиллагаа нь Ерөнхийлөгчийн сонгуулийн үр дүнд чухал үүрэгтэй гэж харагдаж байгаа ч тухайн нэр дэвшигчийн онцлог нь мөн л чухал хүчин зүйл байна. Сант Марал Сангийн судалгаагаар дээр дурдсанчлан амжилттай өрсөлдөн ялалт байгуулсан нэр дэвшигчид нь тухайн сонгууль явагдах үед иргэдийн дунд хамгийн өндөр рейтинг бүхий гурван улстөрчийн нэгд багтаж байжээ.

Мөн сонгуулийн үр дүнд нэр дэвшигчийн чанар, чансаа, давуу талууд болон зарим гаднын хүчин зүйлс нөлөөлж болно. 2016 оны сонгуульд гуравдагч хүчин болох улс төрийн намууд сайн оролцсоны (МАН-аас салсны дараах МАХН) шалтгаан нь олон нийтэд танигдсан, 2015 болон 2016 оны хамгийн өндөр рейтингтэй улстөрч болох С.Ганбаатарыг нэр дэвшүүлсэнтэй холбоотой байна.¹¹⁶ 2005 оны сонгуульд ч мөн тухайн үеийн гуравдагч хүчнүүд болох Эх орон нам болон Бүгд найрамдах нам нийтэд танигдсан, өмнө нь топ-5 улстөрчид багтаж байсан хүмүүсийг нэр дэвшүүлсэн тул мөн л амжилттай байжээ.¹¹⁷

¹¹⁶ Л.Сумати, Вернер Пролл, Ц.Сэргэлэн, 2018. Сонгогчдын дуу хоолой. Боть II.

¹¹⁷ Мөн тэнд.

Томоохон улс төрийн намууд сонгуульд амжилт багатай, сул оролцсон шалтгаан нь өмнөх сонгуулиар амжилт үзүүлээгүй, сайн танигдаагүй улстөрчдийг нэр дэвшүүлсэнтэй холбоотой ба 2017 оны МАН-ын нэр дэвшигч, 2021 оны АН-ын нэр дэвшигч нар гуравдагч хүчний (ХҮН болон МАХН) нэр дэвшигчээс бага санал авсан жишээнээс үүнийг харж болно. Сүүлийн сонгуульд хүчингүй саналын хуудасны тоо хамгийн өндөр тоологдсон нь боломжит сонголтын хязгаарлагдмал байдалд сонгогчид сэтгэл ханамжгүй байгаагаар илэрхийлсэнтэй холбоотой. Доорх Хүснэгт 18-аас 2017 оны сонгуулийн хоёрдугаар шатны санал хураалт (эдгээрийн олонх нь хоёрдугаар шатанд багахан саналын зөрүүгээр шалгарч чадаагүй МАХН-ын нэр дэвшигч С.Ганбаатарын дэмжигчид байсан байх магадлалтай) болон 2021 оны сонгуулийн (АН хоёр хуваагдсан) дүн мэдээг харж болно.

Хүснэгт 18. Ерөнхийлөгчийн сонгуулийн хүчингүй саналын хуудас

Он	Саналын хуудасны төрөл	Тоо	Хувь
1997	Хоосон саналын хуудас	-	-
	Хүчингүй саналын тоо	26,970	2.74
2001	Хоосон саналын хуудас	545	0.05
	Хүчингүй саналын тоо	17,411	1.74
2005	Хоосон саналын хуудас	466	0.05
	Хүчингүй саналын тоо	12,092	1.30
2009	Хоосон саналын хуудас	938	0.09
	Бүх нэр дэвшигчийг тэмдэглэсэн санал	749	0.07
2013	Хүчингүй саналын тоо	13,522	1.23
	Хоосон саналын хуудас	13,688	1.10
2017	Хүчингүй саналын тоо	-	-
	Хоосон саналын хуудас	18,663	1.37
2017	Бүх нэр дэвшигчийг тэмдэглэсэн санал	99,494	8.23
	Хүчингүй саналын тоо	-	-
2021	Хоосон саналын хуудас	71,937	5.92
	Хүчингүй саналын тоо	-	-


Сонгуулийн кампанит ажлын стратеги, хэвлэл мэдээллийн сурталчилгаа, мэтгэлцээн зэрэг нь сонгуулийн дүнд хэрхэн нөлөөлдөг талаар хийсэн судалгаа нь ямар нэгэн тодорхой хандлагыг харуулаагүй. Глоб Интернетшнл ТББ-ын зүгээс 2009, 2013 болон 2017 онд хийсэн хэвлэл мэдээллийн мониторингийн судалгаагаар хэвлэл мэдээллээр явуулсан зар сурталчилгаа (үндсэндээ сурталчилгаа) болон авсан саналын (доорх Зураг 10) хооронд эерэг хамаарал байгаа нь харагдаж байна.¹¹⁸ Гэвч хэвлэл мэдээллээр гарах хугацаа болон сонгуульд гаргасан амжилт хоорондын хамаарлыг тогтооход дата мэдээлэл хэт хязгаарлагдмал байна.

Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийн халз мэтгэлцээний ач холбогдлын талаар товч шинжилгээ хийж үзлээ. Монгол Улсад явагдаж байсан Ерөнхийлөгчийн бүхий л сонгуулийн сурталчилгааны үеэр (нэр дэвшигчдийн нэг нь "ковид-19" туссан учир товлосноос хэд хоногийн өмнө цуцлагдсан 2021 оны сонгуулиас бусад) нэр дэвшигчдийн халз мэтгэлцээн багадаа нэг удаа болж байжээ. 2013 болон 2017 оны сонгуультай холбоотой дата мэдээллээс харвал мэтгэлцээнийг үзсэн хүмүүсийн тоо маш өндөр, 2013

¹¹⁸ Б.Эрдэнэдалай. 2021. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн дүнд хийсэн шинжилгээ. Судалгааны тайлангийн төсөл

оны мэтгэлцээнийг нийт телевиз үзэгчдийн 50 хувь нь, 2017 оны мэтгэлцээнийг 70 хувь нь үзсэн байдаг. Гэвч Монгол Улсын хуулиар Ерөнхийлөгчийн сонгуулийн сурталчилгааны хугацаанд олон нийтийн санал бодлыг тандах судалгаа хийхийг хязгаарладаг тул (судлаачдыг судалгаа хийхийг зөвшөөрдөг харин хэвлэл мэдээллийн хэрэгслийг судалгаа хийхийг зөвшөөрдөггүй ба судалгааны үр дүнг сонгуулийн кампанит ажлын хугацаанд олон нийтэд түгээхийг хориглодог) мэтгэлцээн нь сонгогчдын санал бодол, сонгуулийн дүнд хэрхэн нөлөөлснийг тодорхойлон гаргахад шаардлагатай дата мэдээлэл байхгүй.¹¹⁹

Зураг 10. Авсан саналын тоо болон хэвлэл мэдээллээр сурталчилсан хугацаа хоорондын хамаарал¹²⁰



Эх сурвалж: Глоб Интернейшнл

Сонгуулийн сурталчилгааны санхүүжилт, нэр дэвшигчийн зүгээс сонгуульд зориулан гаргасан зардлын хэмжээ нь сүүлийн сонгуулиудад ихээр нэмэгдсэн боловч¹²¹ энэхүү нэмэгдсэн зардлаас бий болсон нөлөөлөл, үр дүн тодорхойгүй байна. Нэр дэвшигчдийн хамгийн ихээр тайлагнасан сонгуулийн санхүүжилтийн эх үүсвэрүүдийг дурдвал: хувь хүмүүс, аж ахуйн нэгжийн хандив, багахан хувийг намын гаргасан санхүүжилт эзэлж байна. Шинжилгээнээс харвал сонгуулийн сурталчилгаанд зарцуулсан зардал (хэдий хэмжээний мөнгийг үнэн зөвөөр ил тод болгож буй нь асуудалтай)¹²² болон авч буй санал хооронд хамаарал байж болох ч энэ талаар дүн шинжилгээ хийхэд хангалттай дата мэдээлэл байхгүй.¹²³ Энэхүү учир дутагдалтай (дата мэдээлэл хангалтгүй) шинжилгээг цаашид улам гүнзгийрүүлэн судлах, мөн сонгуулийн санхүүжилтийн талаарх боломжит мэдээллийг улам сайжруулах хэрэгцээ байна.

¹¹⁹ Д.Бадамдаш. А.Бат-Оргил. 2021. Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн мэтгэлцээн (1993-2017). судалгааны материал


¹²⁰ Б.Эрдэнэдалай. 2021. Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн дүнд хийсэн шинжилгээ. Судалгааны тайлангийн төсөл

¹²¹ <https://ikon.mn/n/28se> [22/12/2022]

¹²² Шилэн нам авлигын эсрэг түншлэл. 2018. Улс төрийн санхүүжилтийн ил тод байдал, авлигын эрсдэлийн үнэлгээ судалгааны тайлан https://www.uih.mn/upload/sudalгаа/files/96_2509657.pdf [22/12/2022]

¹²³ Б.Эрдэнэдалай. 2021. Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн дүнд хийсэн шинжилгээ. Судалгааны тайлангийн төсөл

Зураг 11. Нэр дэвшигчийн санхүүжилтийн задаргаа: 2009-2017¹²⁴



Эх сурвалж: Сонгуулийн ерөнхий хороо

Дүгнэлт

1993 оноос хойш Ерөнхийлөгчийн эдэлж ирсэн эрх мэдэл болон энэ хугацаанд хийгдсэн Ерөнхийлөгчийн сонгуулийн судалгаанаас тухайн албан тушаал нь эрх мэдэл болон нөлөөллийн хувьд улам өсөн нэмэгдэж, Монгол Улсын тэргүүлэх улстөрчид Ерөнхийлөгчөөр сонгогдож ирснийг тодорхой харж болохоор байна. Энэхүү дээр дурдсан хоёр асуудал нь сүүлийн жилүүдэд Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшихтэй холбоотой намын дотоод өрсөлдөөнийг улам нэмэгдүүлсэн бөгөөд улмаар улс төрийн намын төлөвшил болон тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж болох юм.¹²⁵ Түүнчлэн нэр дэвшигчийн гаргах амжилт нь намын эв нэгдэл, зохион байгуулалтаас ихээхэн хамааралтайн зэрэгцээ эвсэл байгуулах, улс төрийн жижиг намуудын дэмжлэгийг татах нь шийдвэрлэх хүчин зүйлс байж болох юм. Нэр дэвшигчийн мэдлэг чадвар, сонгуулийн сурталчилгаа эхлэхийн өмнөх олонд танигдсан байдал, хэвлэл мэдээллийн оролцоо, санхүүжилт зэрэг нь мөн үр дүнд нөлөөлж болох ч энэ талаар цаашид гүнзгийрүүлэн судлах шаардлагатай. Нөгөөтээгүүр, УИХ-ын сонгуультай адил Ерөнхийлөгчийн сонгуульд оролцох сонгогчдын ирц багасаж буй нь хэвийн үзэгдэл болоод байна. Мөн 2013 оноос эхлэн сонгогчид санал тэмдэглэлгүй саналын хуудсаа уншуулах буюу цагаан сонголт хийх нь ихэссэн. Дээрх хоёр хандлага нэгдэн Ерөнхийлөгчийн эрх мэдэл, нэмэгдсэн хэдий ч олон нийтээс авах дэмжлэг нь багасаж байгааг илэрхийлнэ.

Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр Ерөнхийлөгчийн эрх үүрэгтэй хамаарах томоохон өөрчлөлтүүд хийсэн. Энэхүү нэмэлт, өөрчлөлтөөр Ерөнхийлөгчийн эрх мэдэл өргөжиж буйг хязгаарлах, одоогийн сонгуулийн мөчлөгийг өөрчлөх зорилт тавьсан нь тодорхой харагдаж байна. Ерөнхийлөгчийн сонгууль нь УИХ-ын сонгуулиас нэг жилийн дараа нийт найман удаа зохион байгуулагдсаар ирсэн бол одооноос эхлэн УИХ-ын сонгуулиас хойш нэг жилийн дараа болон УИХ-ын сонгуулиас 1 жилийн өмнө гэсэн мөчлөгөөр зохион байгуулагдахаар болж байна.

¹²⁴ Б.Эрдэнэдалай. 2021. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн дүнд хийсэн шинжилгээ. Судалгааны тайлангийн төсөл. хуудас 14.

¹²⁵ Э.Гэрэлт-Од. 2021. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль болон улс төрийн намуудын өрсөлдөөн. Судалгааны тайлангийн төсөл

Хүснэгт 19. УИХ болон Ерөнхийлөгчийн сонгуулийг зохион байгуулах хугацаа

УИХ-ын сонгууль	Ерөнхийлөгчийн сонгууль	Хугацаа
2020	2021	1 жилийн дараа/3 жилийн өмнө
2024	2027	3 жилийн дараа/1 жилийн өмнө
2028		
2032	2033	1 жилийн дараа/3 жилийн өмнө
2036	2039	3 жилийн дараа/1 жилийн өмнө
2040		

Сонгуулийн хуваарьт ийнхүү өөрчлөлт орж байгаа нь хэд хэдэн нөлөөллийг үзүүлж болно. Сонгууль хоорондын хугацаанаас хамааран сонгогчдын ирц өөрчлөгдөж болох ба сонгуулийн хугацаанаас хамааран парламент дахь суудал бүхий намуудад илүү давуу болон сул талууд үүсэх боломжтой. Энэхүү өөрчлөлтийн явцыг цаашид нарийвчлан судлах, мөн өмнөх Ерөнхийлөгчийн сонгуулийн үр дүнг харгалзан үзэж, байнгын дүн шинжилгээг хийх шаардлагатай.

БҮЛЭГ V

МОНГОЛ УЛСЫН ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬ

Зохиогч:

Д.Бадамдаш, Б.Эрдэнэдалай, Д.Ундрах, Б.Сарантуяа, Марк Кэйниг

Өнөөг хүртэл Монгол Улс нь УИХ, ОНС, Ерөнхийлөгчийн сонгуулийг ойролцоогоор нэг жилийн дотор зохион байгуулсаар иржээ.¹²⁶ ОНС нь УИХ болон Ерөнхийлөгчийн сонгуулиудын хооронд зохион байгуулагддаг бөгөөд эдгээр гурван сонгууль дотроос хамгийн бага ирцтэй нь байдаг. ОНС-ийн дата мэдээлэл болон судалгааны чанар нь УИХ-ын болон Ерөнхийлөгчийн сонгуультай харьцуулахад хүртээмж муутай байдаг тул засаг захиргааны болон эрдэм шинжилгээний байгууллагуудын хувьд ч ОНС-ийг судлах нь төдийлөн ач холбогдолгүй байдаг. 2000, 2004, 2016, 2020 оны ОНС-ийн дата мэдээлэл нь зөвхөн аймаг, нийслэлийн хэмжээнд олдоцтой байсан тул судалгааны ажилд оролцсон судлаачид зөвхөн эдгээр оны мэдээлэлд үндэслэн товч дүн шинжилгээ хийсэн. Иймд одоогоор судлагдсан байгаа ОНС-ийн үр дүнд хийсэн судалгаа нь хамрах хүрээний хувьд хязгаарлагдмал болсон ба цаашид ОНС-ийн цогц, түүхчилсэн мэдээллийг олох, нэгтгэх, судлан шинжлэхэд онцгой анхаарал хандуулах шаардлагатайг харуулж байна.

Өнгөрсөн хугацаанд багц саналын, олонхын болон холимог мажоритар сонгуулийн тогтолцоонууд ашиглаж ирсэн ба УИХ-ын сонгуулийн тогтворгүй байдал нь орон нутгийн сонгуулийн хувьд ч нөлөөлж байна. Сонгуулийн тойрог хуваалт, тойрогт ногдох мандатын тоо ч тогтмол өөрчлөгддөг нь сонгуулийн үр дүнд дүн шинжилгээ хийхэд хүндрэл учруулдаг.

ОНС-ийн ирц бага байгаа нь тухайн сонгуулийн ач холбогдлыг бага гэж үзэж буй сонгогчдын ойлголттой холбоотой байна.¹²⁷ Монгол Улсын Засгийн газар нэгдмэл бүтцээ хадгалахын зэрэгцээ орон нутгийн засаг захиргааны түвшинд шийдвэр гаргалт, төлөвлөлт, санхүүгийн менежментийг сайжруулахын тулд хууль тогтоомжоор дамжуулан орон нутгийн засаг захиргааг шат дараатайгаар чадавхжуулж байгаа ч иргэдийн дээрх хандлага хэвээр байна.

Орон нутгийн сонгууль - сонгуулийн тогтолцоо ба удирдлага

Монгол Улс нь ОНС-ийг УИХ-ын сонгуультай адил олон хуулиар зохицуулж ирсэн бөгөөд цаг хугацааны явцад нөхцөл байдалдаа тохируулан өөрчилсөөр иржээ. Ардчилалд шилжсэнээс хойших 30 жилийн хугацаанд ОНС-ийг зохион байгуулахтай холбоотой дараах таван хуулийг баталжээ. Үүнд:

¹²⁶ 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацааг зургаан жил болгосон тул цаашид УИХ-ын/ОНС-ийн болон Ерөнхийлөгчийн сонгуулиуд зөрж зохион байгуулагдана.

¹²⁷ Ардчилал судлалын төв. НУС. МУИС. 2022. Орон нутгийн сонгуулийн талаарх иргэдийн ойлголт, хандлага тодорхойлох судалгаа

- 1996 онд - Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хууль анх батлагдав.
- 2007 онд - Орон нутгийн ИТХ-ын сонгуулийн тухай хууль
- 2012 онд - Нийслэлийн ИТХ-ын сонгуулийн тухай хууль болон аймаг, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хууль
- 2015 онд - Сонгуулийн тухай хууль (энэ хуульд УИХ, Ерөнхийлөгчийн сонгууль болон аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай заалтуудыг багцаар нь тусгасан).
- 2020 онд - Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хууль батлагдав.

ОНС бүрд тухайн жилийн УИХ-ын сонгуульд ашигласан сонгуулийн тогтолцоог ашиглаж ирсэн. Тухайлбал, 1992, 2008, 2020 онд багц саналын, 1996, 2000, 2004, 2016 онд олонхын мажоритар, 2012 онд холимог мажоритар тогтолцоог ашиглаж байв. Сонгуулийн тогтолцоог өөрчлөхөөс гадна эдгээр хуулиар сонгуулийн сурталчилгааны үргэлжлэх хугацаа, нэр дэвшигчдэд тавигдах шаардлага, санал хураалтын өмнөх зохион байгуулалт, санал авах байр хаагдах хугацаа зэрэг санал хураалт явуулахтай холбоотой төрөл бүрийн холбогдох дүрэм, журмын зохицуулалтуудыг хийдэг.


ОНС-ийн ирцийг нэмэгдүүлэх зорилгоор тус сонгуулийг УИХ-ын сонгуультай хамт товлон, зохион байгуулах хэрэгтэй эсэх асуудал сонгуулийн жилүүдэд байнга хөндөгддөг. Дэлхийн олон оронд ОНС болон УИХ-ын сонгуулийг нэгтгэн зохион байгуулдаг бөгөөд энэ нь сонгуулийн зардлыг бууруулж, ОНС-ийн ирцийг өндөр байлгадаг сайн талтай. Гэвч давхар сонгууль зохион байгуулахад сул тал ч бий. Тухайлбал, сонгогчид ОНС-ийн нэр дэвшигчдийг үнэлж дүгнэхээс илүү УИХ-ын сонгуульд ач холбогдол өгдөг; эсвэл УИХ-ын сонгуулийн тухай мэдээ мэдээлэл хэвлэл мэдээллийн хэрэгслээр давамгайлснаар олон нийтийн анхаарал тухайн сонгуульд илүү төвлөрч, сонгогчид ОНС-ийн өрсөлдөөн болон саналын хуудсанд бичигдсэн нэр дэвшигчдэд анхаарал хандуулахгүй өнгөрөх сул талтай. 2012 болон 2016 оны сонгуулиар аймаг, нийслэлийн ОНС-ийг УИХ-ын сонгуультай хамт зохион байгуулсан хэдий ч бусад шатны (сум, дүүргийн) орон нутгийн сонгуулийг тухайн намар нь тусад нь зохион байгуулсан. Сонгуулийг ийнхүү хамт товлон, зохион байгуулах нь хэр үр дүнтэй байсан талаар дорвитой дүгнэлт хийхэд дата мэдээлэл дутмаг, хангалтгүй байгаа юм. Гэсэн ч сонгогчид ОНС-д төдийлөн анхаарал хандуулдаггүй, олон нэр дэвшигчид, орон нутгийн болон үндсэн намуудын мөрийн хөтөлбөрийг хооронд нь ялгаж салгаж чаддаггүй зэргийг харуулсан судалгаа байдаг.¹²⁸

ОНС болон УИХ-ын сонгуулийг ихэвчлэн тус тусад нь зохион байгуулж байгаагийн гол үндэслэл нь сонгуулийн үр ашигтай байдлыг нэмэгдүүлэх зорилгоос илүүтэй улс төрийн болон практик хэрэгцээтэй холбоотой байх магадлалтай юм. Улс төрийн талаасаа ОНС нь УИХ-ын сонгуульд ялалт байгуулж чадаагүй нэр дэвшигчдэд ОНС-д оролцох замаар улс төрийн идэвхтэй байх боломжийг олгодог. Үнэхээр ч 2020 оны ОНС-ийн хуулиар нэр дэвшигчдэд олон түвшинд (тухайлбал, сум, аймаг) өрсөлдөх боломж олгосон нь нэр дэвшигчдэд нөөц хувилбартай байх боломж бүрдүүлсэн. Мөн УИХ-ын болон Орон нутгийн сонгуулийг хамтад нь зохион байгуулахад сонгуулийн тойрог нь хоёр сонгуулийн хувьд өөр байдаг зэрэг ээдрээтэй, тодорхойгүй байдал үүсгэж, будлиантуулах нөхцөл бий болгох эрсдэлтэй юм. Хоёр сонгуулийг хамтад нь зохион байгуулснаар сонгуулийн дүнг үнэн зөв гаргахад хүндрэл үүсэж болзошгүй.

¹²⁸ Ардчилал судлалын төв. НУС. МУИС. 2022. Монгол Улсын 2000 оноос хойших Орон нутгийн сонгуулийн үр дүнд хийсэн шинжилгээ. Судалгааны төсөл.

Сонгуулийн тогтолцоотой холбоотой дээрх асуудлуудын зэрэгцээ сонгогчдын ОНС-ийн талаарх ойлголт, оролцоо, чиг хандлага мөн анхаарал татаж байна. Доорх Зураг 12-оос харахад ОНС-ийн ирц бусад сонгуулийнхаас хамаагүй доогуур, мөн буурах хандлагатай байгаа нь тодорхой харагдаж байна.

Зураг 12. УИХ-ын, Ерөнхийлөгчийн болон ОНС-ийн ирцийн харьцуулалт
(Ерөнхийлөгчийн сонгуультай жилүүдийг хаалтад дурдав)



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо, 2021

Тэмдэглэл: 2016 оны зургаадугаар сард УИХ-ын сонгууль аймаг, нийслэлийн ОНС-тай нэг өдөр болсон. 2016 оны аравдугаар сард сум, дүүргийн ОНС болсон.

ОНС-ийн ирц бага байгаа нь сонгогчид тухайн сонгуулийн талаарх мэдлэг, мэдээлэл дутмаг, УИХ-ын сонгуулиас хойш хэдхэн сарын дараа дахин сонгуульд санал өгөхөөс залхсан байдал, мөн дараагийн Ерөнхийлөгчийн сонгуульд анхаарлаа хандуулж байгаа зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалж болох юм. Мөн СЕХ болон сонгуулийн талаар олон нийтэд сурталчлан таниулах, сонгогчийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэн үйл ажиллагаа явуулдаг хэвлэл мэдээлэл, ТББ зэрэг бусад байгууллагууд ОНС-д анхаарал бага хандуулж, УИХ-ын болон Ерөнхийлөгчийн сонгуульд илүү төвлөрдөг нь ажиглагдаж байна. Сонгогчид ОНС-ийг харьцангуй ач холбогдол багатай гэж үзэж буй нь иргэд бодлогын гол асуудлуудыг шийддэг төвлөрсөн засаглалын талаар илүү сайн ойлголттой хэдий ч орон нутгийн засаг захиргааны бүтцийн талаар муу ойлголттойг харуулж байна. Нөгөөтээгүүр, ОНС-ийг намар товлодгоос хичээлийн жилтэй холбоотой шилжилт хөдөлгөөн тус сонгуулийн ирцэд сөргөөр нөлөөлдөг. Учир нь сонгогч өөрийн бүртгэлтэй тойрогтоо биеэр очихгүй бол сонгуульд оролцох боломжгүй байдаг. 2022 онд хийгдсэн сонгогчдын зан төлөвийн судалгаагаар ОНС-д оролцоогүй сонгогчдын хамгийн өндөр буюу 30 хувь нь шилжилт хөдөлгөөн бол санал өгөхөд саад болдог гол хүчин зүйл гэж хариулсан байна (доорх Зураг 13-ыг харна уу).¹²⁹

¹²⁹ Ардчилал судлалын төв. НУС. МУИС. 2022. Орон нутгийн сонгуулийн талаарх иргэдийн ойлголт, хандлага тодорхойлох судалгаа

Зураг 13. Орон нутгийн сонгуульд оролцоогүй шалтгаан¹³⁰



Сонгогчдын ирцийг бууруулдаг, улс төрийн стратегид нөлөөлдөг бас нэг хүчин зүйл бол ОНС-ийн хуульд сонгуулийн сурталчилгааны хугацааг маш богино байхаар зааж өгсөн явдал юм. 1996-2020 онд сонгуулийн сурталчилгааны хамгийн богино хугацаа нь 12 хоног (1996 онд), хамгийн урт хугацаа нь 17 хоног (2016 онд) бөгөөд ихэнхдээ сурталчилгааны хугацааг 14 хоногоор тогтоосон байна. Сонгуулийн сурталчилгааны энэ богино хугацаа нь улиран нэр дэвшиж буй улстөрчдөд давуу талыг бий болгох магадлалтай ч намын харьяалал болон цаг үеийн нөхцөл байдал нь тухайн нэр дэвшигчийн рейтингд нөлөөлөхөөс илүү сонгогчийн санал өгөх зан төлөвт нөлөөлөх магадлалтай байна. Энэ маш богино хугацаа нь жижиг намуудад ОНС-д ялалт байгуулахад бэрхшээл учруулж, томоохон намуудад давуу тал үүсгэх талтай.

Орон нутгийн сонгуулийн дүн

Өмнө дурдсанчлан ОНС-ийн дүн мэдээ дутуу, зөрүүтэй, нэгтгэгдээгүй байгаа нь дүн шинжилгээ хийхэд ихээхэн хүндрэл учруулж байна. Олдсон дата мэдээлэл нь харилцан адилгүй, цэгцгүй, заримдаа зөрүүтэй байв. Энэ нь Монгол Улсын ОНС-ийн талаарх судалгаа хангалтгүй байгаагийн гол шалтгаан юм. Олдсон мэдээллийг нягталж үзэхэд 2000, 2004, 2016, 2020 оны ОНС-ийн мэдээлэл байсан тул дүн шинжилгээнд ашиглав. Бусад оны ОНС-ийн дата мэдээлэл СЕХ-д байгаагүй¹³¹ бөгөөд дутуу байгаа жилүүдийн мэдээллийг олж, нэгтгэх үйл явц нь алдаа гаргах өндөр магадлалтай, гар аргаар маш их хэмжээний өгөгдөл шивж оруулах шаардлагатай нүсэр ажил юм.

¹³⁰ Ардчилал судлалын төв. НУС. МУИС. 2022. Орон нутгийн сонгуулийн талаарх иргэдийн ойлголт, хандлага тодорхойлох судалгаа

¹³¹ СЕХ нь сонгуультай холбоотой хамгийн сайн (чанартай) өгөгдлийг олоход тус болсон. СЕХ-ны орон нутгийн сонгуулийн мэдээллийг удирдах бүрэн эрх нь сүүлийн жилүүдэд л тодорхой болсон бөгөөд өмнөх үр дүнг архивлахад багахан л хэмжээний хөрөнгө оруулалт зарцуулагдсан

Олдсон дөрөвхөн сонгуулийн дата мэдээллийг шинжлэн ОНС-ийг дүгнэх боломжгүй ч тодорхой хэмжээний дүгнэлт хийхийг оролдов. Тус онуудад МАН УИХ болон Орон нутгийн аль аль сонгуульд амжилт үзүүлснийг доорх Хүснэгт 20-д харуулж байна. Бусад төрлийн сонгуулиудын адилаар ОНС-д сөрөг хүчний намууд эвсэл байгуулсан, эсэх нь гаргах үр дүнд нь нөлөөлж байна. Үүний тод жишээ нь, 2020 онд ОНС-д АН бусад намтай эвсэл байгуулснаар амжилттай үр дүн гаргасан. МАН, МАХН хоёрын хуваагдал нь МАН-ын саналын хувийг бууруулахад ахин голлон нөлөөлсөн ч МАХН-ын төлөөлөгчид МАН-аас Засаг даргад нэр дэвшигчдийг ерөнхийдөө дэмжин ажилласан нь МАН бараг бүх аймагт гүйцэтгэх засаглалыг удирдахад хүргэсэн үр дүнд хөтөлсөн. 2020 онд МАХН-тай нэгдсэн АН-ын эвсэл найман аймагт ялалт байгуулсан нь тус намын хувьд ОНС-д гаргасан хамгийн сайн үзүүлэлт болсон юм.

Эдгээр үр дүнг харахад нэг сонирхолтой хүчин зүйл ажиглагдаж байгаа нь сонгуульд өрсөлдсөн намуудын тоо юм. Энэ нь 2020 онд эрс нэмэгдсэнийг дата мэдээллээс харж болох ч өсөх чиг хандлагатай гэж дүгнэхэд хэтэрхий эрт байна. 2000 онд долоо, 2004 онд тав, 2016 онд тав, 2020 онд 11 нам оролцож байжээ. Энэ хугацаанд бие даан нэр дэвшигчид ОНС-д тодорхой хэмжээний амжилт гаргасан. Тухайлбал, 2000 онд 20, 2004 онд 12, 2016 онд 20, 2020 онд 16 бие даагч (эвсэл нам бус нэр дэвшигч) тус тус ялалт байгуулжээ. 2004 онд сонгогдсон бие даан нэр дэвшигч болон бусад жижиг намын төлөөллийн тоо нэмэгдсэн (185 нэр дэвшигч) нь мөн эвсэл байгуулагдсантай холбоотой. АН 2004 оны УИХ-ын сонгуульд өрсөлдөхийн тулд сөрөг хүчний намуудыг нэгтгэн эвсэл байгуулсан нь амжилттай стратеги болж чадсан ч ОНС-ийн хувьд нам бүр дангаар оролцсон. Улмаар УИХ-ын сонгуульд авсан АН тэргүүтэй эвслийн багц санал ОНС-ийн хувьд хуваагдсан юм.

Хүснэгт 20. 2000, 2004, 2016 болон 2020 оны ОНС-ийн дүнгийн хураангуй¹³²

	2000				2004				2008
	МАН	АН	Бусад	Нийт	МАН	АН	Бусад	Нийт	
Нийт авсан суудлын тоо (улсын хэмжээнд)	573	54	63	690	442	67	181	690	Өгөгдөл хангалтгүй
Нийт суудлын тоонд эзлэх хувь (улсын хэмжээнд)	83%	8%	9%	100%	64%	9.7%	26%	100%	
Олонх болсон аймгийн тоо (УБ хот багтсан)	22	0	0	22	21	1	0	22	
Олонх болсон аймгийн хувь	100%	0%	0%	100%	95%*	5%	0%	100%	

¹³² Хавсралт VI-аас дэлгэрэнгүйг харна уу.

	2012	2016				2020			
		МАН	АН	Бусад	Нийт	МАН	АН	Бусад	Нийт
Нийт авсан суудлын тоо (улсын хэмжээнд)	Өгөгдөл хангалтгүй	533	229	48	810	469	321	30	820
Нийт суудлын тоонд эзлэх хувь (улсын хэмжээнд)		66%	28%	6%	100%	57%	39%	4%	100%
Олонх болсон аймгийн тоо (УБ хот багтсан)		20	2	0	22	14	8	0	22
Олонх болсон аймгийн хувь		91%**	9%	0%	100%	64%	36%	0%	100%

* 2004 онд Хөвсгөл болон Сүхбаатар аймагт МАН олонх суудлыг авч чадаагүй, харин нэгтгэн тооцвол жижиг намууд хамгийн олон суудал авсан. Гэхдээ МАН аймаг бүрдээ хамгийн том нам хэвээр байсан.

** 2016 онд Дорнод болон Дундговь аймагт МАН даруй олонх болж чадаагүй бөгөөд МАН-ын авсан суудал АН болон бусад намын авсан суудлын нийт тоотой тэнцүү байв. Гэсэн ч аймаг бүрийн удирдлагыг авч чадсан.

ОНС-ийн дата мэдээлэлтэй холбоотой асуудлууд

Монгол Улсын ОНС-той холбогдох судалгаа шинжилгээний ажилд тулгамдаж байгаа хамгийн чухал асуудал бол одоогийн боломжит байгаа статистик болон дата мэдээллийн чанар юм. Энэхүү мэдээллүүд нь зохион байгуулсан нутаг дэвсгэр бүрд бүртгэгдсэн байж болох ч СЕХ-нд албан бусаар нэгтгэгдсэн мэдээллийн хувьд ихэнх ОНС-ийн дата мэдээлэл бүрэн бус байна. Учир нь 2020 оны ОНС-иар хүртэл ОНС-ийн мэдээллийг СЕХ нэгтгэх үүргийг албан ёсоор хүлээгээгүй байсантай холбоотой. Улмаар ОНС-ийн тойрог бүр дор бүрнээ санал хураалтыг хариуцаж ажилласан бөгөөд мэдээллийг цэгцтэй, ойлгомжтой, нэгдмэл, жигд байдлаар цуглуулан, нэгтгээгүй байна. 2020 оны ОНС-ийн дата мэдээллийн чанар харьцангуй сайн байгаа хэдий ч өмнөх сонгуулийн дүнгүүд үүнтэй ижил хэмжээний чанартай байж чадахгүй байна. Зарим оны сонгуулийн цаасан болон цахим хэлбэрээр байгаа дата мэдээлэл нь маш сайн (гэхдээ төгс биш) өгөгдөл болж чадаж байгаа ч бусад оны сонгуулийн дата мэдээллийг нэгтгэн боловсруулахад асар их хүч хөдөлмөр шаардагдахаар байна. Анхны ОНС-иудын дүн (1992, 1996) СЕХ-ны бүртгэлд цаасан хэлбэрээр ч үлдээгүй байх магадлалтай байгаа юм.

1992-2020 оны сонгогчдын ирц, нийт сонгогчдын тоо зэрэг дата мэдээлэл бүртгэгдэж ирсэн боловч ихэнх жилүүдэд дээрх мэдээллийг аймаг, дүүргээр салгаж бүртгээгүй байна. Сонгогчдын ирцийн мэдээлэл өөр, өөр эх сурвалжуудад зөрүүтэй байгаа бөгөөд үүнийг цогц дата мэдээлэлгүйгээр эцэслэн шийдэхэд хүндрэлтэй. Ихэнх оны сонгуулиудын хувьд зөвхөн ялалт байгуулсан нэр дэвшигчдийг л бүртгэж ирсэн бөгөөд өрсөлдсөн нэр дэвшигчдийн тоо болоод тэдгээрийн авсан саналын хувь зэрэг мэдээллүүд бүртгэгдээгүй үлджээ. Түүнчлэн хүчингүй саналын хуудас болон "цагаан саналын"-ын хувь хэмжээ зэрэг мэдээлэл бүрэн хэмжээнд байхгүй байна.

Нэр дэвшигчид, тэр байтугай сонгогдсон төлөөлөгчдийн хүн ам зүйн мэдээлэл олдоц муутай байдаг. Тухайлбал, 1992, 1996, 2008, 2016, 2020 оны нийт нэр дэвшигчдийн тоо, 1992, 1996, 2008 оны сонгогдсон төлөөлөгчдийн нэрс олдоогүй боловч зарим ИТХ-ын вэбсайтаас энэ мэт мэдээллийг тодорхой хэмжээнд олох боломжтой юм. Мөн сонгуулийн тогтолцоо бүрийн хувьд мандат авсан нэр дэвшигчдийн нэгтгэсэн, баталгаатай мэдээлэл байхгүй байна. Судалгааны баг цаасаар болон дижитал хэлбэрээр цуглуулсан дата мэдээллийг гараар шивж, тулган, нэгтгэх хэрэгтэй болсон. Үүнээс гадна сонгуулийн тойргийн мандаттай холбоотой томоохон асуудлууд тулгарч байгаа ба эдгээр мэдээлэл нь өөр өөр эх сурвалжуудад зөрүүтэй байв. Сонгуулийн жил бүр мандатыг өөр өөрөөр товлож, сонгуулийн тойргийг өөрчилдөг нь дүн шинжилгээ хийхэд хүндрэл, бэрхшээл учруулж байна.

Дата мэдээлэл нь олдсон ч шивж оруулахдаа алдаа гаргасан байх магадлалтай байгаа нь дата мэдээллийн чанарт эргэлзээ төрүүлж байна. Тухайлбал, 2004 болон 2008 оны сонгуулийн тоо баримтыг нягталж үзэхэд хэд хэдэн аймгийн дүн (Говь-Алтай, Сэлэнгэ, Сүхбаатар) хоёр оны хувьд яг ижил байсан. Энэ нь алдаа байж болзошгүй бөгөөд аль нэг сонгуулийн үр дүнг андуурч хуулбарласан байх магадлалтай юм. Түүнчлэн нэг сонгуулийн үр дүнг өөр өөр форматаар тайлагнасан ч тохиолдол гарав. Өөрөөр хэлбэл, зарим аймгийн түвшний мэдээллийг сумдаар, заримыг нь санал авах байраар (сумыг нь тодорхой тэмдэглээгүй) нэгтгэсэн байгаа нь харьцуулсан дүгнэлт хийхэд бэрхшээл учруулж байна.

СЕХ нь судлаачидтай нээлттэйгээр мэдээлэл солилцож байсан бөгөөд 2012 оноос өмнөх дата мэдээллийг баталгаажуулах, эсвэл дүн шинжилгээнд ашиглахад хүндрэлтэй байгаатай санал нэгдсэн. Үүгээр судалгааны явцад тулгарсан дата мэдээлэлтэй холбоотой сорилтуудыг тоймлохыг зорив. Монгол Улсын ОНС-ийг цаашид судлахад дээрх асуудлуудыг анхаарч үзэх нь нэн чухал бөгөөд өндөр ач холбогдолтой.

Дүгнэлт

Хамгийн гол бөгөөд хамгийн том асуудал бол ОНС-ийн мэдээллийг нэгтгэж, оновчтой дүн шинжилгээ хийх ба дата мэдээллийг олох, нэгтгэх, нэгдсэн стандартад оруулж цэгцлэх нь томоохон хэмжээний чухал ажил юм. Ингэхийн тулд орон нутгийн Сонгуулийн хороо бүрээс, нам, архиваас мэдээлэл цуглуулж, нэгтгэх шаардлагатай. Цаашид СЕХ мэдээлэл цуглуулах ажиллагааг сайтар төлөвлөж, бүрэн хэрэгжүүлэх нь чухал ач холбогдолтой бөгөөд дээрх ажлыг хийхэд дорвитой хөрөнгө оруулалт шаардлагатай.

Мэдээлэл хязгаарлагдмал тул ОНС-ийн үр дүнд дүн шинжилгээ хийх нь бэрхшээлтэй юм. Бусад сонгуулийн адил ОНС-д ч МАН/МАХН нь ихээхэн амжилт гаргаж байгаа нь тодорхой байна. МАН/МАХН нь орон нутагт төлөөлөл, гишүүнчлэл ихтэй байгаа нь ОНС-д онцгой давуу тал болж, сонгуулийн мөчлөг бүрт МАН/МАХН хамгийн олон аймагт засаглаж байна. Сөрөг хүчний амжилт нь эвсэл байгуулах эсэх болон МАН/МАХН-ын дотоод эв нэгдлээс хамааралтай байна. МАХН/МАН-ын хуваагдал нь ОНС-ийн үр дүнд ч нөлөөлсөн байх магадлалтай. Нөгөөтээгүүр, АН-ын 2020 онд гаргасан амжилт нь эвсэл байгуулж сонгуульд өрсөлдсөнтэй зарим талаараа холбоотой.

